


СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

ДУГААР 2025 №3 (12)

ᠰᠣᠩᠭᠤᠯᠢᠶᠢᠨ
ᠪᠣᠯᠣᠪᠣᠰᠣᠷᠣᠯ



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо

МОНГОЛ УЛСАД “СОНГУУЛЬ
АЖИГЛАХ АЗИЙН ЖИШИГ
ТӨВ” БАЙГУУЛНА

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан референт-хэвлэлийн төлөөлөгч

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

ГИШҮҮД

Т.Дорж

Академич, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор

Ч.Содномцэрэн

Академич, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Дашпүрэв

Философийн шинжлэх ухааны доктор, профессор

Д.Даваа-Очир

Хууль зүйн доктор, профессор

Д.Гангабаатар

Хууль зүйн доктор, профессор

З.Сүхбаатар

Бизнесийн удирдлагын доктор, профессор

О.Хатанболд

Улс төр судлалын доктор

А.Эрдэнэцогт

Хууль зүйн доктор, профессор

Д.Бат-Эрдэнэ

Хууль зүйн магистр

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын Гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн Тэргүүн

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн Удирдах зөвлөлийн ахлагч

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

4

Б.ЧИМИД “СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ” НОМООС...

- Сонгуулийн байгууллага

10

ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

- Монголын улс төрийн намын төлөвшил өнөөгийн нийгмийн үйл явцад нөлөөлөх нь

24

ДУГААРЫН ЗОЧИН

- Э.Гэрэлт-Од: Өнгөрсөн 30 жилийг марта. Намууд шинэ соёлоор төлөвшиж, амьд байх үе эхэллээ

29

НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛ

- “Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал” өгөгдлийн дүрслэлийн цахим үзэсгэлэн

37

ХУУЛЬ ТОГТООМЖ

- Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим систем хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр боловсруулж байна

39

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

- Сонгуулийн төв байгууллагын бүтэц - чиг үүргийн тухай
- “Сонгууль-2024” эрдэм шинжилгээний илтгэл
Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн биелэлтийг хангах нь (Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдлыг сайжруулах хүрээнд)

56

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ-2025

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль
- Д.Алтаншагай: Орон нутагт сонгуулийн байгууллагын байнгын төлөөлөл бий болгох хэрэгтэй

60

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

- Монгол Улсад “Сонгууль ажиглах азийн жишиг төв” байгуулна
- Шинэ Зеланд Улсын Парламентын төлөөлөгчдийн танхимын дарга Жерард Браунлид бараалхлаа
- Үндэсний номын санд сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхим ажиллуулна
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээр Сонгуулийн ерөнхий хороо тэргүүлээ

62

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Гадаад орнуудын үндсэн хуулиас...



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА*

Бяраагийн Чимид

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор

“Сонгуульд суралцахуй” номоос цувралаар хүргэж байна.

4.1. СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦЫГ ЭРХЛЭХ, ТҮҮНД ОРОЛЦОХ ХОЁРЫН ЯЛГАА

Засаг төрийн төлөөлөх байгууллагын сонгууль бол улс төрийн өргөн цар хүрээтэй нарийн дэгтэй, нийлмэл үйл явц юм. Түүнд бараг бүх байгууллага татагдан орно. Тэгэхдээ илүүц “санаачилга” гаргаж дур үзэмжээрээ буюу санасан зоргоороо хандаж болохгүй. Харин хууль ёсны үүрэгтэй байгууллага л хуулиар тогтоосон эрх хэмжээнийхээ дотор мөн түүнд заасан арга, хэлбэр, журмыг чанд баримтлан оролцоно. Асуудлыг ерөнхийлж багцаалдалгүй, “сав саванд нь” багтааж эрэмбэтэй ойлгохын тулд тэр олон янз байгууллагыг эрхиш ангилж бүлэглэх нь дээр. Сонгуулийн үйл явцад хуулиар ногдуулсан үүрэг бүхий байгууллагуудыг **“сонгуульд оролцогч байгууллага”, “сонгууль эрхэлсэн байгууллага”** (товчоор “сонгуулийн”) гэж хоёр их хэсэгт хувааж болно. Энэ нь эрх зүйн талаас зааглаж ойлгох ялгамжтайгаар зохицуулах арга зүйн нэг үндэс болно. Сонгуулийн үйл явцын аль шатанд хэн юу хийх ёстойг зааглан мэдэж, ёсчлон баримтлах нь сонгуулийг зөв хөтлөн явуулахад тустай.

Сонгуулийг эхнээс бэлтгэн, хуулийн биелэлтийг эрхлэн зохион байгуулж, хянан зохицуулах, шалган дүгнэх бүрэн эрх бүхий байгууллагыг сонгуулийн байгууллага гэнэ. Харин сонгуулийн үйл явцын тодорхой үе шатанд хуулиар ногдуулсан ямар нэг тусгай үүрэг гүйцэтгэдэг бол **сонгуульд оролцогч байгууллага** гэж болно. **«Оролцогч байгууллага»** гэдэгт төрийн төв, орон нутгийн болон өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, аж ахуйн нэгжийг хамааруулан хураангуйлсан болно. Тэдгээр нь сонгуулийн үйл явцын зөвхөн тодорхой үе шат, цувралд хамаатай. Нэг нь эрхэлдэг, бусад нь оролцдог, тэр нь хязгаартай гэсэн үг. Бусдын ажил



хэрэгт оролцохыг бус ногдсон үүрэгт ажилдаа бүрэн эзэн болохыг хариуцлага гэдэг.

4.2. СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ, ОРОЛЦОО

Сонгуулийн бүх үе шатыг тойрон улс төрийн их давалгаа үүсэж, эдийн засаг, улс төр, зохион байгуулалтын олон талт арга хэмжээнд төр, нам, иргэний нийгмийн бусад байгууллага татагдан орохдоо дээр тэмдэглэсэнчлэн өөр өөрийн хууль ёсны эрх хэмжээний дотор л ажиллана. Зарим жишээг баримтаар авч үзье.

4.2.1. Улсын Их Хурал

Сонгуулийг товлон зарлахаас, нэгдсэн дүнг хэлэлцэж, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх хүртэл үйл явцыг эрх зүйн талаар зохицуулах нийтлэг зарчмын бүх асуудлыг хуульчлан шийдвэрлэнэ. УИХ-ын сонгуулийн талаар тус Их Хурлын шийдвэрлэх асуудал:

№	Шийдвэрлэх асуудлын агуулга	Хуулийн нэр, зүйл, хэсэг
1	Сонгуулийг зарлах	СТХ-ийн 8.3;
2	Сонгуулийн зардлын хэмжээг тодорхойлох	СТХ-ийн 10.1; 10.2;
3	Нөхөн сонгууль зарлах	СТХ-ийн 54.2; 54.3;
4	Тойрог байгуулах, өөрчлөх	СТХ-ийн 12.2; 12.6;
5	Гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх	УИХ-ын тухай хууль

* Б.Чимид. “Сонгуульд суралцахуй”. УБ 2008. 81-90 тал

4.2.2. Засгийн газар, түүний орон нутгийн нэгж (Засаг дарга)

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хувьд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж сонгуулийн байгууллагуудаас түүний гүйцэтгэлийг хангахад дэмжлэг үзүүлэх, зөрчлөөс сэргийлэх арга хэмжээ авна. Энэ нь тэдгээрийн Үндсэн хуулийн чиг үүргээс урган гарна.

СТХ-ийн 14 дүгээр зүйлээс:

«14.7. Сонгууль бэлтгэн явуулахад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу оролцоно.»

УИХ, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, НӨУБ нь улс төрийн намын төлөөлөлтэй, тэгээд бас үндсэн бүрэлдэхүүн нь сонгуульд аль нэг нам, эвслээс нэр дэвших буюу ухуулан оролцдог учир сонгуулийн үйл явцыг удирдахгүй. Өөрөөр хэлбэл сонгуулийг бэлтгэж явуулах үйл явцад **«хөндлөнгөөс хутгалдан оролцох ёсгүй»** гэсэн зарчмын ойлголт, шаардлага бий. Тэдгээр нь зөвхөн сонгуулийн «гадаад» орчин, аятай нөхцөл бүрдүүлж, эрх зүйн талаар зохицуулан иргэдийн сонгуулийн эрхийг хамгаална. ИТХ, Засаг дарга оролцох зарим үүргийг жишээ болгон үзүүлбэ.

№	Шийдвэрлэх асуудлын агуулга	Хуулийн нэр, зүйл, хэсэг
1	Хэсгийг байгуулах	СТХ-ийн 13.1 (сум, дүүргийн ИТХ);
2	Нэрийн жагсаалт гаргахад оролцох	СТХ-ийн 20 (Засаг дарга);
3	Сурталчилгааны зүйл байрлуулах газрыг тогтоож өгөх	СТХ-ийн 37.6 (Хурлын тэргүүлэгчид);
4	Сонгуулийн хороодыг ажлын байр, унаа тээвэр, холбооны бусад хэрэгслээр хангах; нэр дэвшигчдийн уулзалтад тэгш дэмжлэг үзүүлэх зэрэг	СТХ-ийн 10.4; 38.2 (тухайн шатны нэгжийн Засаг дарга);
5	Санал хураалтын бэлтгэл ажиллагаанд оролцох	СТХ-ийн 43.3 (сум, дүүргийн Засаг дарга);

Мөн нэгжийн Засаг дарга сонгогчдын нэрийн жагсаалт гаргах, уулзалтад туслах, зарлан мэдээлэх үүрэгтэйг холбогдох бүлгүүдэд өгүүлсэн болно.

4.2.3. Улс төрийн нам, эвсэл

Улс төрийн нам, эвсэл бол сонгуулийн үйл явцыг бүхэлд нь эрхлэн хөтлөхгүй. Зөвхөн тус тусын сонгуулийн мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийг дэмжин сурталчилж сонгуульд ялахын төлөө олон нийтийг өөртөө татан оролцуулахад шууд чиглэсэн хуулиар хориглоогүй арга хэмжээг зохион байгуулна. Олон нийтийн хяналт тавина. Өөрөөр хэлбэл удирдах бус **оролцооны байгууллага** болно. Түүний үүрэг, оролцооны эрхийг дараахь хүснэгтээр тоймлон харуулав.

№	Шийдвэрлэх асуудлын агуулга	Хуулийн нэр, зүйл, хэсэг
1	Сонгуульд оролцох нийтлэг эрх	СТХ-ийн 24.1;
2	Эвсэл байгуулж оролцох	СТХ-ийн 25.1; 25.2; 25.3;
3	Нэр дэвшүүлэх тухай	СТХ-ийн 28.1; 28.3;
4	Нэр дэвшигчийн оронд өөр хүнийг нэр дэвшүүлэх	СТХ-ийн 31.1;
5	Нөхөн нэр дэвшүүлэх	СТХ-ийн 32.1;
6	Шаардлагатай мэдээлэл лавлагаа авах эрх	СТХ-ийн 35.1;
7	Хуулийн дагуу сонгуулийн сурталчилгаа явуулах	СТХ-ийн 37.2;
8	Гомдол гаргах	СТХ-ийн 21.1;

Нам, эвслийн сонгуулийн үйл явцад оролцох зарим ажилбарыг энд дурдсангүйг анхаарч хуулиас тодруулж үзээрэй.

4.2.4 Бусад байгууллага

Сонгууль бэлтгэн явуулахад хууль ёсны дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бусад байгууллагыг СТХ-д цохон нэрлэж, хийх ажлыг нь хэмжээлж заасан байдаг. Тэдгээрийн төрөл, оролцооны зарим үүргийг дараахь хүснэгтээр тоймлон харуулав.

№	Шийдвэрлэх субъект	Шийдвэрлэх асуудлын агуулга	Хуулийн нэр, зүйл, хэсэг
1	Цагдаа, эмнэлэг, амралт, сувиллын газрын удирдлага	Нэрсийн жагсаалт гаргахад мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх	СТХ-ийн 20.9;
2	Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн алба	Нэрийн жагсаалтыг гаргах	СТХ-ийн 20.11;
3	Ажиглагч	Сонгуулийн үйл явцыг хөндлөнгөөс хянах	СТХ-ийн 46;
4	Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч	Санал тоолоход байлцах (ажиглах), эрх	СТХ-ийн 48.2;
5	Олон нийтийн болон бусад радио, телевиз	Сонгуулийн сурталчилгаанд	СТХ-ийн 37.7; 37.9;
6	Төрийн болон орон нутгийн өмчийн мөн түүний оролцоотой аж ахуйн нэгж, албан газар	Нэр дэвшигчийн уулзалтад зориулж байр, танхим, өрөө тасалгааг гаргаж үнэ төлбөргүйгээр ашиглуулах	СТХ-ийн 38.3

Энд бид дээр дурьдсан байгууллагуудын сонгуульд оролцох үүргийг бүгдийг дурьдаж чадаагүйгээ онцолж хэлэх нь зүйтэй. Тэгэвч дээр өгүүлсэн жишээ баримт нь оролцогч байгууллагын үүрэг тусгай шинжтэй. Түүгээрээ сонгуулийн байгууллагаас ялгаатайг харуулах буйзаа.

4.3. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

Сонгуулийн байгууллага нь хуульд заасан журам, хугацаагаар байгуулагдаж сонгуулийг бэлтгэж явуулах ажлыг эрхлэн зохион байгуулдаг.

Энэхүү тогтолцоо нь:

- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (ЕХ);
- Сонгуулийн тойргийн хороо (ТХ);
- Сонгуулийн тойргийн салбар хороо (ТСХ);
- Сонгуулийн хэсгийн хороо (ХХ)-оос бүрдэнэ.



Эдгээр салаа мөчрийг ерөнхийд нь сонгуулийн төв, орон нутгийн байгууллага гэх ба орон нутгийнх нь 3 шаттай, байнгын биш (түр зуурын) шинжтэй юм.

СТХ-ийн 14 дүгээр зүйлээс:

«14.1. Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь сонгуулийн төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ.

14.3. Сонгуулийг улс, тойрог, хэсгийн хэмжээнд Сонгуулийн ерөнхий хороо болон тойрог, салбар, хэсгийн хороо /цаашид "сонгуулийн хороод" гэх/ эрхлэн явуулахыг зааж бүрэлдэхүүн, зарчмыг тогтоожээ »

Сонгуулийн тойргийн төрөл, бүтцээс хамааран сонгуулийн байгууллагын байршил, эрх зүйн байдал өөрчлөгдөн хувьсаж байдаг.

Улс нь нэгдмэл нэг тойрог болох ахул тойргийн хороо байгуулахын оронд Сонгуулийн ЕХ шууд удирдаж аймаг, нийслэлд салбар хороод байгуулах; олон мандаттай тойрогт бол тойргийнхоос гадна сумдад салбар хороо байгуулах жишээтэй.

4.3.1. Сонгуулийн ерөнхий хороо

Сонгуулийн ЕХ бол сонгуулийн төв байгууллага бөгөөд түүний эрх зүйн байдлыг «Сонгуулийн Төв байгууллагын тухай хууль» (СТБТХ)-иар тодорхойлсон байна.

СТБТХ-ийн 3 дугаар зүйл:

«3.2 Сонгуулийн ерөнхий хороо /цаашид "хороо" гэх/ нь Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага мөн».

Уг хуульд зааснаар: Сонгуулийн ЕХ нь 9 гишүүнтэй. Тэдний тавыг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг УДШ төрийн жинхэнэ албан хаагчдын дотроос санал болгож УИХ 6 жилийн хугацаагаар томилно. Хорооны дарга, нарийн бичгийн дарга хоёр орон тооны байх ба тэднийг гишүүдийн дотроос УИХ томилно» (СТБТХ-ийн 4.1-4.4),

Хорооны эрх зүйн байдлыг түүний чиг үүрэг, бүрэн эрх илэрхийлдэг. Сонгуулийн ЕХ дараахь үндсэн чиг үүрэгтэй.

1. Сонгуулийн хуулийн биелэлтийг зохион байгуулах үндсэн дээр:
 - ард нийтийн санал асуулга
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль;
 - УИХ-ын сонгуулийг эрхлэн явуулж, дүгнэх;
2. сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх арга ажиллагааны журмыг тогтоох, мөрдүүлэх буюу нормчлон тохируулах;
3. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн орон нутгийн хороодыг удирдах;
4. ИТХ-ын сонгуулийг зохион явуулахад аргачилсан туслалцаа үзүүлэх;
5. сонгуулийн үйл явц, түүнд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа санхүүжилтэд эрх зүйн хяналт тавьж зохицуулан маргааныг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх;
6. сонгуулийн асуудлаар хүн амыг мэдээллээр хангаж, лавламж, мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулж үйлчлэх. Эдгээрийг хэрэгжүүлэх тодорхой эрх, үүрэг (бүрэн эрх)-тэй юм. Хураангуйлж томьёолбол, сонгуулийн хуулийн биелэлтийг зохион байгуулах, сурталчлан мэдээлэх, сонгуулийн үйл явцыг аргачлан удирдах, нормчлон тохируулах, хянан шалгах, маргаан шийдвэрлэх чиг үүрэг бүхий тусгай эрх хэмжээтэй гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болно. Тиймээс улс төрийн байгууллагуудаас хараат бус зарчмаар бие даасан байдалд ажиллана.

Энэ хүрээнд Сонгуулийн ЕХ-ны үндсэн бүрэн эрхийг СТБТХ-ийн 7 дугаар зүйлд 15 хэсгээр тодорхойлжээ. Түүнийг бага сага хураангуйлан дор сийрүүлэв:

1. Ард нийтийн санал асуулга болон сонгууль (хойшид зөвхөн сонгууль гэв) бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах;

2. сонгуулийн биелэлтэд хяналт тавих;
3. сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;
4. сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэлтэй холбогдсон асуудлаар төрийн зохих байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
5. сонгуулийн зардлын төсвийг батлагдсан хэмжээний дотор хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;
6. сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах;
7. хуульд заасан дүрэм, журам, заавар, баримт бичгийн загвар маягт батлах;
8. сонгуулийн төв архивыг зохион байгуулах, үүнтэй холбогдуулан архивын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран сонгуулийн баримт бичгийг архивт шилжүүлэх, хадгалах журам баталж мөрдүүлэх;
9. сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхэд оруулах;
10. сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар Улсын Их Хуралд санал тавих;
11. сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдсон асуудлаар шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал, Засгийн газарт санал оруулах;
12. Хорооны дүрмийг хэлэлцэн батлах¹ ;
13. Хорооны төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
14. өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар сонгуулийн хороод, сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад туслах үүрэг гүйцэтгэх байгууллага, түүний бэлтгэл ажлыг хангахад туслах үүрэг бүхий төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн хууль тогтоомжид заасан асуудлаар холбогдох бусад байгууллагаас шаардлагатай баримт, мэдээ сэлтийг гаргуулж авах, зохих албан тушаалтны мэдээллийг сонсож, хууль биелүүлэх асуудлаар үүрэг даалгавар өгөх;
15. хуульд заасан бусад бүрэн эрх. "Бусад" гэдэг нь сонгуулийн болон бусад хуульд заасан эрх, үүргийг хэлжээ.

УИХ-ын сонгуулийг бэлтгэж, зохион явуулах талаар Сонгуулийн ЕХ дараах эрх үүрэгтэй:

1. тойрог байгуулах, өөрчлөх саналыг Улсын Их Хуралд оруулах;
2. тойргийн хороо байгуулах, түүний бүрэлдэхүүнийг батлах;
3. тойргийн хорооны үйл ажиллагааг дуусгавар болгох;
4. тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан

гомдол болон сонгуулийн асуудлаар гаргасан бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх, хэрэв хууль тогтоомжид нийцээгүй бол тухайн тойргийн хорооны шийдвэрийг хүчингүй болгох;

5. УИХ-ын сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх;
6. сонгуульд оролцогч нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагатай сонгуулийн асуудлаар харилцах;
7. УИХ-ын гишүүнд нэр дэвшигчийн бүртгэлийг хуульд заасан үндэслэл байвал хүчингүй болгох;
8. саналын хуудасны загварыг батлах, түүнийг хэвлүүлэх, хуваарилах;
9. сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, сонгогдсон Улсын Их Хурлын нийт гишүүний нэрийн жагсаалтыг үйлдэж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган мэдүүлэх, тэдгээрийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, нийтэд мэдээлэх;
10. нам, эвсэл, нэр дэвшигчийн авсан хандивын хэмжээ, зарцуулалтад хяналт тавих;
11. сонгуулийн зардлын тайланг хянан хэлэлцэх, дүнг нийтэд мэдээлэх эрх, үүрэгтэй.

Хуульд заасан "бусад бүрэн эрхтэй" гэсэн заалт бас бий. Энэ нь ямар ч байсан бүх эрх, үүрэг нь хуульд тодорхойлогдсон байх зарчимтайг илэрхийлнэ.

4.3.2. Сонгуулийн орон нутгийн байгууллага (хороод)

СТХ-д зааснаар Сонгуулийн тойргийн хороо, тойргийн салбар хороо, хэсгийн хороодыг сонгуулийн **орон нутгийн байгууллага** гэнэ (СТХ-14.2).

Тойргийн хороо бол өөрийн салбар болон хэсгийн хороодыг удирдан тойргийнхоо харьяа нутаг дэвсгэрт сонгуулийг эрхлэн явуулах үндсэн чиг үүрэгтэй юм.

Аймаг, дүүрэг хоёр УИХ-ын сонгуулийн томсгосон буюу олон мандат бүхий тойрог болсон учир 2008 оны сонгуулиар 20 аймаг², 6 дүүрэг³ тойргийн хороо байгуулагдсан бөгөөд харин сумд, мөн дүүрэг, хороодод тойргийн **салбар хороог** ажлын шаардлага харгалзан түүгээрээ байгуулах юм.

Сонгуулийн **бүх шатны хороод** сонгуулийг эрхэлсэн байгууллагын хувьд хуулиар тогтоосон нийтлэг зарчмыг баримтална. Үүнд:

1. Орон нутгийн **хороод түр зуурын шинжтэй**. Тэдгээр нь үндсэндээ сонгуулийн хугацаанд ажиллана. Сонгуулийн дараа ажлаа дүгнэж, архиваа цэгцэлж дээш, дээш нь тушаасны эцэст Сонгуулийн ЕХ тойргийн хорооны үйл ажиллагааг; тэр нь харьяалах салбар болон хэсгийн хорооны үйл ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гаргана (СТХ-14.3.2).

¹ "Хорооны хөдөлмөрийн дотоод журам" гэж ойлгох нь зөв болов уу.- Б.Чимид

² Говьсүмбэр аймгийн хүн ам цөөн учир нутаг дэвсгэрийг нь зэргэлдээ Дорноговь аймагтай нь нэгтгэн нэг тойрог зохиожээ (УИХ-ын 2007-12-27 №9 дүгээр тогтоол)

³ Нийслэлийн зарим дүүргийг нөгөөтэй нь нэг тойрог болгожээ (УИХ-ын 2007-12-27 №9 дүгээр тогтоол)

2. Эдгээр хорооны бүрэлдэхүүн **нам, эвслийн адил тооны төлөөлөлтэй** байх зарчимтай. Уул бүрэлдэхүүнд аль нэг нам, эвслийн төлөөллийг давамгайлуулах, улс төрийн албан тушаалтныг, эсхүл сонгуульд нэр дэвшигчийг оруулах, хорооны дарга, нарийн бичгийн дарга хоёр нэг нам, эвслийн байхыг хориглоно.
3. Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хэн боловч үүргээ **нам, улс төрийн байгууллагаас хараат биш** байх үндсэн дээр хэрэгжүүлнэ. Энэ нь тэдгээрийн хууль зүйн болон ёс зүйн үүрэг мөн. Энэ тухайд УИХ-аас баталсан **“Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрэм”**-ийг баримтална. Түүний үндсийг сонгуулийн хуулиар тогтоон баталгаажуулжээ.

СТХ-ийн 14 дүгээр зүйлээс:

«14.3.7. сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд, түүнчлэн санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх, бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, хүчингүй саналын хуудсаар санал авах зэрэг хууль бус аливаа үйлдлийг зохион байгуулах, өөгшүүлэх, бусад хэлбэрээр дэмжихийг хориглох» гэжээ.

Сонгуулийн хороодоос сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, ухуулагч, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг мөн хуулиар хориглосон байна.

4. Хорооны бүрэлдэхүүн **дархан эрх эдэлнэ**. Энэ талаар СТХ-д «тойрог, салбар, хэсгийн хороодын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно» гэжээ (СТХ 14.6).

Энэ бол сонгуулийг зөв шударгаар явуулахын тулд тогтоосон баталгааны нэг бөгөөд гагцхүү дээрх дархан эрх, зарчмыг сайтар ухамсарлаж зөвхөн Сонгуулийг бэлтгэн явуулахын тулд хууль ёсоор эдэлбэл зохино. Түүнийг зөрчвөл хүлээлгэх захиргааны хариуцлагыг мөн хуулийн 14.8. болон бусад зүйлд заасан бий.

4.3.3. Хорооны бүрэлдэхүүнийг Та анхаарах учиртай шүү

Сонгууль бол угтаа иргэдээс улс төрийн үндсэн эрхээ бие даан хэрэгжүүлэх, **өөрийн удирдлага бүхий үйл ажиллагаа** мөн. Сонгуульд яаж оролцох, хэнийг дэвшүүлж, дэмжих, эцсийн саналаа аль хүчин, хэний төлөө өгөх зэрэг

нь сонгогчдын эрх мэдлийн асуудал, иргэний журамт үүрэг мөн. Иймд **сонгуульд бэлтгэж, явуулах ажлыг сонгогчид өөрсдөө мэдэж зохион байгуулах боломжийг аль болохоор хангах нь ардчилсан ёсны шаардлага юм. “Засгийн эрх ард түмний мэдэлд”** гэдэг зарчмын уг чанар энд бас оршино. Сонгогчид гэгдэх ард түмэн энэхүү эрх мэдлээ өөрсдийн **шууд оролцооноос** гадна сонгуулийн хороодоор **дамжуулан** хэрэгжүүлнэ.

Тэгэхээр орон нутгийн хороод бол уг чанар, нийгмийн үндэс, бүрэлдэхүүн, үүрэг зорилгоороо тэндэхийн иргэд (сонгогчид)-ийн байгууллага шууд ардчиллын хэлбэр мөн. Энэ бол онолын баримтлал юм. Харин СТХ-д сонгуулийн хороодыг дээрээс нь, төвөөс томилж байгуулах зарчим тогтоосон нь эргэлзээтэй ч “хууль бол хууль” учир гүйцэтгэхээс аргагүй. Чингэхдээ тэдгээрийн бүрэлдэхүүнд тухайн тойрог хэсгийнх нь сонгогчдын дэвшүүлсэн төлөөлөгч нь оролцож тэдний язгуур ашиг сонирхлын төлөө л ажиллах нь зүйн хэрэг. Сонгуулийн хорооны гишүүд аль нэг «нам эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчдын эрхээ хэрэгжүүлэхэд саад хийх»-ийг сонгуулийн хуулиар хориглосныг дээр эшлэсэн (СТХ-14.3.7). Энэ бол хороо, түүний дарга, гишүүд нь сонгогчдын ямар нэг бүлгийн өмнөөс биш **нийтийн ашиг сонирхлын** үүднээс, өөрөөр хэлбэл “цэвэр иргэний байр суурь”-ийг баримтлан ажиллах зарчмын тусгал мөн.

ЗӨВЛӨМЖ

Иргэн Та сонгуулийн үйл явцад иргэний идэвхтэй байр суурь баримтлан, эрх мэдэлтэй, илүү үр дүнтэй оролцоё гэвэл сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах буюу эсвэл ажилд нь хөндлөнгөөс хяналт тавьж оролцох нь зүйтэй.

Ингэж оролцох, хийж бүтээхийн тул мэдэх, юуны өмнө хороодын онцлог үүрэг, ажиллах журмыг мэдүүштэй байдаг. Тэр мэдлэг эрхээ бүрэн эдлэхэд тань тустай.

4.3.4. Хороод ямар “орон тоо”, эрх үүрэгтэй вэ?

Тойргийн хороог сонгуулийн ЕХ сонгуулийн өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж нийтэд зарлан мэдээлнэ. Хорооны бүрэлдэхүүнд тухайн **тойргийн сонгогчдын** дотроос аймаг, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид нэр дэвшүүлнэ. Энд таны санал, оролцоо чухал үүрэгтэй.

Хороо нь тойргийнхоо хэмжээнд дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1. сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах;
2. сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;
3. харьяалах салбар болон хэсгийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах, хэсгүүдийн дугаарыг тогтоох;
4. сонгууль бэлтгэн явуулах асуудлаар тойргийнхоо

нутаг дэвсгэр дэх төрийн зохих шатны байгууллагын үйл ажиллагааг уялдуулж зохицуулах, удирдлагынх нь мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

5. сонгуулийн төсвийн хөрөнгийн харьяалах салбар, хэсгийн хороонд хуваарилах, зориулалтын дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
6. нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох;
7. тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг нэгтгэн гаргаж, Сонгуулийн ЕХ-нд хүргэх, олон нийтэд мэдээлэх;
8. зохих үндэслэл тогтоогдвол дахин санал авах, дахин болон нөхөн сонгуулийг зохион байгуулах;
9. хэсгийн хорооны шийдвэр, үйлдлийг хуульд харшилбал хүчингүй болгох, сонгуулийн тухай маргаан бүхий өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;
10. архив бичиг хэргийн болон Сонгуулийн ЕХ-ноос өгсөн, хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Салбар хороо:

Тойргийн хороо нь аймаг, дүүрэгт байх учир харьяа сум, хороодод сонгуульд бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулахын тулд **салбар хороог** байгуулна. Тэдгээрийг тойргийн хороо сонгуулийн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5 эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд зарлан мэдээлнэ.

Салбар хороо нь үндсэндээ хэсгийн дугаар олгох, нэр дэвшигчийг бүртгэхээс бусад тойргийн хорооны эрх, үүргийг, мөн тойргийн хорооноос өгсөн бусад үүргийг хэрэгжүүлнэ.

Хэсгийн хороо нь хэсгийн төвд байрлаж, сонгогчидтой шууд "тулж" ажилладаг сонгуулийн анхан шатны байгууллага мөн. Түүнийг нийслэлд тойргийн хороо, аймагт салбар хороо сонгуулийн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зарлан мэдээлнэ.

Хэсгийн хороог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан тухайн хэсэгт:

- 2000 хүртэл сонгогчтой бол 9, эсхүл 11;
- 2001-3500 хүртэл сонгогчтой бол 11, эсхүл 13;
- 3501-ээд дээш сонгогчтой бол 13, эсхүл 15 хүний бүрэлдэхүүнтэй байхаар СТХ-д тодорхойлжээ.

Хэсгийн хороо нь өөрийн хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлж, тогтмол ажиллана.

Дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- сонгогчийн үнэмлэх олгох;
- сонгогчдод шилжүүлэг олгох, шилжиж ирсэн сонгогчийг бүртгэх;
- сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд

үнэн зөв нэгтгэж, сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаягийг тулгах шалгах;

- санал авах байр, саналын хайрцаг зэрэг шаардлагатай бусад зүйлийг бэлтгэх;
- сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;
- санал хураалтын дүнг гаргаж, салбар хороонд, тийм хороогүй бол тойргийн хороонд хүргэх;
- сонгуулийн асуудлаар гарсан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;
- сонгуулийн бичиг баримтыг цэгцэлж, салбар буюу тойргийн хороонд хүлээлгэн өгөх, хуульд заасан болон харьяалах хорооноос өгсөн бусад үүргийг биелүүлнэ.

4.3.5. Хороодын ажлын зохион байгуулалт

Сонгуулийн хороод нь хамтын удирдлагатай. Эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэнэ. Тогтоол гаргаж түүнд тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

Хороод нь үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулна. Гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тодорхойсон дэгийг хуралдаанаараа баталж мөрдөнө.

Сонгуулийн **тойргийн** болон **салбар хороод** нь:

- хорооны гишүүдийг үндсэн ажлаас түр чөлөөлүүлж, сонгуулийн ажилд татан оролцуулах;
- хууль тогтоомжийн биелэлтийг харьяалал харгалзахгүйгээр шалгах;
- сонгуулийн бэлтгэл, үйл явцын асуудлаар тус тусын нутаг дэвсгэр дэх зохих шатны (төрийн болон өөрөө удирдах) байгууллагын эрх баригчдын илтгэлийг сонсож хууль ёсны заалт өгч, шаардлага тавьж, хариу авах;
- төсвийнхээ хэмжээнд багтаан ажил гүйцэтгэх гэрээ байгуулах зэрэг эрхтэй.

Сонгуулийн хороодоос бүрэн эрхийнхээ дотор гаргасан шийдвэр, хуулийн дагуу өгсөн үүргийг зохих байгууллага, албан тушаалтан биелүүлэх, хэрэв шаардлага тавьсан бол түүнийг хүлээн авснаас хойш **ажлын хоёр өдрийн** дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэх үүрэгтэй (СТХ-19.9; 19.13).

Сонгуулийн хороодын дарга дотоод асуудлаар захирамж гаргана. Бичиг хэргийг журмын дагуу хөтөлж, сонгууль дууссаны дараа архивыг цэгцэлж харьяалах дээд шатныхаа хороонд хүргүүлэх зэрэг **дотоод ажлын дэг журмыг** СТХ-д заажээ. Түүнийг хэрэглэх журмыг Сонгуулийн ЕХ-оос зохих заавраар тодруулан мөрдүүлдэг байна.

Сонгуулийн хороод (тамга) тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШИЛ ӨНӨӨГИЙН НИЙГМИЙН ҮЙЛ ЯВЦАД НӨЛӨӨЛӨХ НЬ*



О.Хатанболд, (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА

ХУРААНГУЙ

Ардчилсан улс орнуудад улс төрийн нам нь төлөөллийн ардчилалдонцгой үүрэгтэй оролцогч институт болохын хувьд нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ агуулгаараа үзэл суртлын ба төрийн бодлого зохицуулалтын үйл хэрэгт чухал нөлөөтэйгээс гадна улс төр дэх шударга өрсөлдөөнийг дэмжихэд улс төрийн намын үүрэг нэн чухал. Тиймээс улс төрийн намуудын зүгээс олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хууль, эрх зүйн хүрээнд чанд нарийн гүйцэтгэж, санхүүгийн дэмжлэгээ зохих журмын дагуу тайлагнаж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадвартай байхыг шаарддаг. Энэ бүх институциональ үүргээр дамжуулан Монгол Улс дахь улс төрийн намуудын төлөвшлийг дараах функциональ (Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад, 2021, хууд. 123) хандлагаар буюу ард түмний хүсэл зориг, олон нийтийн үзэл бодол бүрэлдэхэд хэрхэн нөлөөлөх; иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх; иргэдийн улс төрийн идэвхтэй оролцоог хэрхэн хангах; төрийн алба хаах, хариуцлага хүлээх чадавхтай иргэнийг бэлтгэх; сонгуульд нэр дэвшүүлэн оролцох; улс төрийн зорилт, мөрийн хөтөлбөрөө төрийн бодлого, шийдвэртэй хэрхэн уялдуулах; төр ба ард түмний хооронд байнгын хийгээд тогтвортой идэвхтэй холбоо үүсгэн хамтран ажиллах, улс төрийн соёл, ёс зүйн өндөр хариуцлагатай хандах боломжийг судалгааны холбогдох эмпирик баримт болгон тэдгээрийн түшиглэн хамаарлыг тодруулсан бэсрэг судалгааны үр дүнгээр илэрсэн мэдээллийг тоймлон энэхүү өгүүлэлдээ гаргахыг зорьсон болно.

НЭГ.

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХУЙ

Улс төрийн намын тухай асуудал нь улс төр судлаачдын маргаан хэлэлцүүлгийн гол сэдэв байсаар ирсэн бөгөөд энэ нь ихэвчлэн *улс төрийн намын нийгэмд эзлэх байр суурь, үүргийн* эргэн тойронд өрнөдөг нь маргаангүй үнэн. Олон арван жилийн турш үргэлжилсэн энэхүү маргаан, мэтгэлцээний дүнд ардчилал нь олон янзын идеал хэв маяг, бодит загваруудтай байлаа ч эцэстээ орчин үеийн ардчилалд намын гүйцэтгэх үүрэг онцгой хэвээр байгааг өрнөдийн томоохон судлаачид хүлээн зөвшөөрөх болсон нь санамсаргүй (Richard S.Katz, Peter Mair, 1995, хуудсд. 5-28) хэрэг огт биш. Тухайлбал, Ричард Катц орчин үеийн ардчилал бол намын ардчилал бөгөөд улс төрийн нам бол либерал ардчиллын үр дагавар (Katz, 1980) хэмээн дүгнэсэн бол, С.Элдерсвельд намыг орчин үеийн нийгмийн улс төрийн гол бүтэц мөн (Eldersveld S., 1982, p. 1) хэмээн онцолсон байдаг. Улс төрийн намыг тойрсон эл маргаан өнөөдрийг хүртэл зогсоогүйгээр үл барам, цаашдаа сэдвийн өргөн хүрээг хамран шинэ байдлаар өрнөж, дээрх судлаачдын санааг сэргүүлсэн янз бүрийн дүгнэлт үндэслэлүүдийг (Ковлер А.И., 1997, хууд. 1) гаргах болсон. Энэ нь бүх эрх мэдэл, бүх санаачлагыг гагцхүү нам гартаа авч, бүх зүйлийг намын хэмжүүрээр авч үзэх нь орчин үеийн ардчиллын сул тал хэмээн үзэх болжээ.

Орчин үеийн улс төрийн нам, түүний системийн тухай ойлголт XVII зууны Их британи, XVIII зууны АНУ-аас үүсэлтэй хэмээдэг. Их британий хувьд иргэний дайн, дайны дараах хувьсгал, Алдарт хувьсгал (*Glorious Revolution*)-ын үр дүнд бий болсон фракцууд органик байдлаар удаан хугацааны туршид нам болж төлөвшсөн нь тухайн улсад улс төрийн намын тодорхой бие даасан хууль бараг байдаггүй. Энэ нь улс төрийн намын тухай тогтсон ойлголт нь бичигдээгүй

* ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын 2025 оны ЭШУА-ны төлөвлөгөөний сонгон судалж буй сэдвийн хүрээнд бэлтгэв.



хууль, улс төрийн соёл, хэм хэмжээгээр зохицуулагдаад удаж буй тул заавал "de jure" хуульд тусгаж өгөх шаардлагагүй (Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад, 2021, хууд. 98) гэдэгтэй шууд холбоотой.

Харин Ларри Даймонд, Ричард Гунтер нарын "Намуудын төрөл ба чиг үүрэг" хэмээх нэгэн өгүүлэлд (Richard Gunther and Larry Diamond, 2001, pp. 7-8) орчин үеийн улс төрийн намын долоон чиг үүргийн тухай дурдахын сацуу намуудын гүйцэтгэдэг гол чиг үүрэг нь элитийг татан оролцуулахад оршдог болохыг онцлоод эдгээр нь гагцхүү сонгуулийн үйл явцын хоёр үе хамааралтай болохыг тэмдэглэсэн байдаг.

Үүнийг тодруулбал, сонгуулийн үйл явцын хоёр үед хамаатай:

1. Сонгуульд тухайн намыг төлөөлөн өрсөлдөх хүнийг тодруулж, нэрийг нь дэвшүүлэх,
2. Намууд нэр дэвшигчээ дэмжүүлэхийн тулд сонгогчдынхоо сэдлийг идэвхжүүлж, зарим тохиолдолд тэднийг сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцох бололцоогоор хангах зорилготой сонгуульд дайчлах,
3. Янз бүрийн асуудлаар сонголт, алтернативыг бүтэцжүүлэх буюу асуудлыг бүтэцжүүлэх чиг үүрэг,
4. Нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөх чиг үүрэг,
5. Ашиг сонирхлыг нэгтгэн нягтруулах,
6. Засгийн газрыг байгуулах, ажиллуулах чиг үүрэг,
7. Нийгмийг интеграцчлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Дээрх судлаачид намын эдгээр чиг үүргийг хэлбэрийн хувьд дотоод, гадаад гэж ангилан заагласан байх ба: намын гадаад чиг үүрэгт: тухайн намын нийгэм дэх улс төрийн систем, засаглалын харилцааны хүрээнд гүйцэтгэх бүлэг чиг үүргүүдийг багтаан үзнэ. Дотоод чиг үүрэгт: намын өөрийнх нь улс төрийн бие даасан амьд организмын хувьд оршин тогтноход нь хэрэгтэй түүний дотоод амьдралын хүрээний бүлэг чиг үүргийг хамруулна. Тэгвэл, Ж.Болдбаатар, А.Цанжид нар «Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг» хэмээх өгүүлэлдээ «...намын нийгэмд гүйцэтгэх үүргийг ерөнхий байдлаар авч үзсэн байдаг. Тодруулбал, нийгмийн бүлгүүдийн сонирхлыг илэрхийлэх, томьёолох, үндэслэх; нийгмийн бүлгүүдийг идэвхжүүлэх, нэгтгэж, нягтруулах; үзэл суртал, улс төрийн номлолыг бий болгох; улс төрийн системийг төлөвшүүлэх, түүний бүрдэл хэсэг, үйлчлэлийн ерөнхий зарчим зэргийг тодорхойлоход оролцох; төрийн засаглалын төлөө тэмцэлд оролцох; төрийн бодлогыг тодорхойлох, засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох; боловсон хүчнийг бэлтгэж, төрийн болон бусад байгууллагын албан тушаалуудад ажиллуулах; олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх; нийгмийн гишүүдийн улс төрийн нийгэмшилтэд тус дөхөм болох зэргийг нэрлэж болохыг дурдсан» (Болдбаатар Ж, Цанжид А, 1991, хуудсд. 35-36) байдаг. Тэд цааш нь намуудад тэдгээр чиг үүргээ бодитой хэрэгжүүлэхийн тулд тодорхой нөхцөл хэрэгтэй байх тухай сонирхолтой санааг тус тус дэвшүүлсэн нь эл сэдвийн хүрээнд авч үзсэн онолын үндэслэл болно.

ХОЁР.

МОНГОЛ УЛС ДАХЬ УЛС ТӨРИЙН НАМЫН ТӨЛӨВШЛИЙН ФУНКЦИОНАЛЬ ХАНДЛАГЫН ТУХАЙД

Улс төрийн намууд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн дамжуулах, бас гүйцэтгэгчийн үүргийг өөртөө хүлээдэг. Үүгээрээ улс төрийн намууд засгийн газрын шийдвэр, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах үр нөлөөтэй суваг (National Endowment for Democracy, 1999) болно. Энэ нь ч тухайн улс орнуудад хариуцлагатай, шударга, ил тод, нээлттэй үйл ажиллагааг явуулах ардчилсан улс төрийн намуудын үйл ажиллагааны үүрэг, үнэт зүйлс болдог. Улс төрийн намуудын төлөвшил бол үндэсний аюулгүй байдалд тэр тусмаа дотоодын аюулгүй байдалд чухал үүрэгтэй. Тиймээс улс төрийн намууд өөрт хамаарах үүргээ ардчилсан, үр өгөөжтэй байдлаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн болон бусад бодит эх үүсвэр, эдийн засгийн нөөцийн чадавхтай байх ёстой. Угтаа аливаа нэг дэмжлэгт дулдуйдах замаар өөрийн оршин тогтнох боломжийг бүрдүүлнэ гэж үзвэл, энэ нь улс төрийн намуудын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь нөхцөл огт болохгүй. Тухайн хуримтуулсан нөөц боломжоо өөрийн улс төрийн институцийн суурь бүтцийг бэхжүүлэх, иргэдтэй харилцах, тэдний улс төрийн оролцоог дээшлүүлэх, иргэдийг нийгэмшүүлэх үйл хэрэгт зохистой ашиглах, өөрийн хүртээмж, нөлөөг өргөн түвшинд түгээн дэлгэрүүлэх нь намуудын нэн тэргүүнд анхаарах зүйл болно. Чингэхийн тулд улс төрийн намууд элитийг татан оролцуулах байдлаар зарчмын байр суурь, чиг үүргийг баримтлах нь зайлшгүй.

Тус сэдвийн хүрээнд улс төрийн намын улс орны засаглалын болон нийгмийн хөгжлийн төлөө дараах долоон чиг үүргийг хариуцлагатай биелүүлж гэмээ нь мөн чанарын хувьд өөрөө төлөвшин бэхжинэ. Ингэхийн зэрэгцээ улс орны дотоод аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ. Тодруулбал, (i) сонгуульд тухайн намыг төлөөлөн өрсөлдөх хүнийг тодруулж, нэрийг нь дэвшүүлэх үе; (ii) намууд нэр дэвшигчээ дэмжүүлэхийн тулд сонгогчдынхоо сэдлийг идэвхжүүлж, сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцох бололцоогоор олон нийтийг хангах зорилготой сонгуулийн дайчилгааны үе; (iii) нийгмийн бүлгүүдийн илүү урт хугацааны ашиг сонирхолд тулгуурласан асуудлыг бүтэцжүүлэх; (iv) нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөх чиг үүрэгтэйгээр нийгмийн төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх; (v) ашиг сонирхлыг нэгтгэн нягтруулах замаар бүлгүүдийн сонирхлыг түгээмэл биш юмаа гэхэд илүү өргөн хүрээнд нэгтгэн нягтруулах; (vi) бодлогын тогтвортой байдлыг тасралтгүй хангах зорилгоор засгийн газрыг байгуулж хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагажуулан ажиллуулах; (vii) нийгмийн интеграцлалын үүргийг гүйцэтгэдэгийнхээ хувьд улс төрийн үйл явцад үр дүнтэй оролцох боломжийг иргэдэд олгодог байх; (viii) оролцсон иргэд тодорхой амжилтанд хүрэхдээ системийг цааш нь үргэлжлүүлэн авч явах сонирхолтой байх тэрхүү хандлагыг төлөвшүүлэхийг үндсэн чиг үүргээ хэмээн үзэх хэрэгтэй.

Энэ бүх институциональ үүргээрээ дамжуулан монголын улс төрийн намуудын төлөвшлийн функциональ (Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад, 2021, хууд. 123) хандлагаар хураангуйлан үзвэл, өнөөдрийн ард түмний хүсэл зориг, олон нийтийн үзэл бодол бүрэлдэхэд улс төрийн намын төлөвшил, түүнийг бэхжүүлэхэд чиглэгдсэн улс төрийн намын хүсэл зориг хурц дайчин бус, иргэдийн улс төрийн боловсрол, мэдлэг доогуур буйгаас үүдэлтэй улс төрийн идэвхтэй оролцоо хангалтгүй байгааг илтгэдэг. Эдгээр сул талыг хангахын тулд нэн тэргүүнд мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх, хариуцлага хүлээх чадавхтай эрүүл, шударга иргэнийг бэлтгэх нь төр ба ард түмний хооронд байнгын хийгээд тогтвортой идэвхтэй эргэх холбоо үүсгэн хамтран ажиллах улс төрийн бодит соёлыг бий болгох хэрэгцээ бий болж, басхүү эрчимжүүлэх шаардлагатай байна. Ингэхдээ улс төрийн намын хууль эрх зүйн зохицуулалтыг эргэн харах түүнийг өнөөгийн цаг үе, шинэ үеийнхэний үзэл бодол, хандлага, төлөвшилтэй уялдуулах хэрэгтэй болно.

Монгол Улс дахь улс төрийн намын хууль, эрх зүйн зохицуулалтыг дэлгэрүүлбэл, өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хуулийг 1990 онд баталж, улс төрийн намын эрх зүйн үндсийг анхлан тогтоосон билээ. Ингэснээр ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн олон намын тогтолцоо бүрдэх үндэс суурь тавигдсан гэж үзэх нь зүйн хэрэг. Үүнийг доорх цаг хугацааны илэрхийлэмжээс түүний агуулга, мөн чанарын дүр зураг харагдана. /Зураг 1/

2005 онд Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулснаар улс төрийн намын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг илүү нарийвчлан тусгаж, намын хөрөнгө, тайлагналын талаар зарим дэвшилттэй зохицуулалтыг оруулсан нь чухал алхам байв. Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Улс төрийн намын тухай хуульд (2005) улс төрийн намд нийгмийн өмнө тухайлсан үүрэг ногдуулаагүй байгааг өөрчилж, улс төрийн намыг ард түмэн, олон нийтийн өмнө хариуцлага хүлээлгэж, үүрэг хүлээдэг хариуцлагатай,

ил тод институт болгон хариуцлагажуулах явдлыг эрчимжүүлсэн гэж болно.


Улс төрийн хүрээнд хамрагдах хууль тогтоомжууд болон түүнд тавих хяналтыг сайжруулснаар иргэдийн эрх зүйн ухамсарын сул мэдлэг, хууль зөрчих явдлыг бууруулахад чиглэгдэнэ. Нөгөө талаар «Хууль тогтоогчийн эрх зүйн ухамсар» төрийн тусламжтайгаар бүх нийтээр дагаж мөрдөх шинжийг олдог нийгмийн материаллаг амьдралыг тусгаж буй «хууль зүйн санаа» болохын хувьд эрх зүйн хэм хэмжээ нь өөрөө хүмүүсийн ухамсарт тусгагдах ба тодорхой нийгмийн бодит байдлын хүрээнд тэдгээрийн боломжит, зөвшөөрөгдсөн зан үйлийг тодорхойлдог. Энэхүү бодит байдал, соёл, хүмүүсийн ухамсарт өөрчлөлт гарснаар эрх зүйн ухамсрын «тогтоогдсон хэсэг» нь өөрчлөгдөж болно. Ийм байдлаар эрх зүйн ухамсрын төрөөс чанд тогтоосон хэсгийн «эзлэхүүн» нь эрх зүй болох бөгөөд түүнийг өргөжүүлж бас явцууруулж (Долгорсүрэн М., Жаргал Ц, 2020, хууд. 248) болдог. Үүнийг зарим нэг судалгааны үр дүнгээр тодруулбал: монголчуудын төрөө дээдлэх, хуулиа дагах уламжлалт хандлага эдүгээ хүртэл уламжлагдан оршиж байгааг судалгаанд оролцогчдын 92.2 хувь нь улсынхаа хуульд захирагдах ёстой гэж үзсэн нь иргэдийн хуулиа дээдлэх эрх зүйн ухамсартай шууд холбоотой. Харин хотын иргэдийн 6.7 хувь, хөдөөгийн иргэдийн 4.8 хувь нь хуульд захирагдах албагүй гэсэн хариултыг өгсөн нь хэдийгээр бага хувь мэт боловч иргэд ийнхүү үзэх болсон шалтгааныг тодруулах хэрэгтэйг харуулж (Хатанболд О, Хишигдаваа А, Жаргал Ц, ба бусад, 2019, хууд. 67) байна.

Олон жилийн турш маргаан мэтгэлцээний сэдэв болж өрнөсөн, энэ явцдаа парламентад хэд хэдэн төсөл өргөн баригдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг Монгол Улсын Их Хурал 2019 онд эцэслэн баталсан. Нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах, ард нийтээр хэлэлцүүлэх, парламентад хэлэлцэн батлах бүх үйл явц нь төрийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн болон иргэний

Зураг 1. Улс төрийн намын тухай хуулийн цаг хугацааны хураангуй илэрхийлэмж



нийгмийн оролцоог хангах орчин үеийн арга хэлбэрүүдийг ашиглах томоохон жишиг болсон гэж үзэж болно. Нэг үгээр өнөөгийн улс төрийн намын эрх зүйн шинэтгэлийн үндэслэл, шаардлага юунд оршиж буйг тодруулбал:



Хүн төрөлхтний түүхээс үзэхэд, хүмүүсийн амьдралд шууд холбоотой хүн ёсны харилцаа нь амьдралаа зохицуулах «ганц хууль» нь болоод зогсохгүй хүний ёс, төрт ёс хоёр зүй ёсны шүтэлцээтэй бөгөөд тэр нь ёс суртахуун, улс төрийн ухамсрыг нөхцөлдүүлдэг аж. Төр, нийгмийн харилцаа улс төрийн ухамсарт цогцолдог учраас нийгмээ зүй ёсоор засан тохинуулах хэрэгцээ, арга замын асуудал улс төрийн ухааны гол утга нь болж байдаг. Гэвч төрийн эрх мэдэл улс төрийн бүлгийн эрх ашигт захирагдан улс төрийн үзэл санааны өөр өөр чиглэлийг олдог. Үүний чин эрмэлзэл нь төр, иргэний ардчилал, хүний эрх, эрх чөлөөний асуудлыг дээшлүүлэхэд хүргэдэг учиртай (Цэрэннадмид А, 2001, хуудсд. 63, 68). Учир нь тэгш байдал, шударга ёсны зарчим дээр бүрэлдсэн эдийн засаг-нийгмийн шинэ системийг цогцлоон бүрдүүлэх нь чухал. Ингэхийн тулд эрүүл мэндийн үйлчилгээний болон боловсролын хүртээмжтэй байдал, орлогын тэгш байдал, нийгмийн хамгааллын тэгш байдал, үйлдвэрлэл, жижиг бизнес эрхлэх зэрэг санхүүгийн эх үүсвэрт хүрэх бололцооны тэгш байдал, хүйсийн тэгш байдал зэргийг хангах чиглэлээр оюунаа уралдуулах нь алсдаа тогтвортой, өсөлттэй, хангалуун нийгэм бий болгоход (Энхсайхан М, 2020, хуудсд. 278-279) төр засгийн нэн тэргүүний зорилго чиглэгдэх нь зайлшгүй. Тийм болохоор нийгмийн санаа бодол, амьдралын өөрчлөлтийг даган хувьсаж, уламжлалт ёс заншлаа шинэчилдэг агаад нийгмийн сэтгэл зүй ийнхүү амьдралд зохицох санаа сэтгэлийн хүч болж, улмаар энэ амьдралын хэрэгцээ, сэтгэл зүйн хувьсал, шинэчлэлийн сэдээгч хүч нь болж өгдөг.

Үндсэн хуулийн үзэл санаагаар баяжсан ардчилал сүүлийн 30 жилийн хугацаанд оргилуун хүсэл, сэтгэл хөдлөлөөс хальж, олон түмний өдөр тутмын аж байдал, үйл хэрэг нэгэнт болсон тул өнөөдөр бид ардчиллын чанар ямар байгаа, гол сул тал нь чухам юу болох, ардчиллыг бэхжүүлэхэд бид юунаас эхлэх ёстойг авч үзэх (Хатанболд О, 2019, хууд. 123) нь зайлшгүй хэрэгтэй. Чингэхийн тулд улс төрийн намын эрх зүйн шинэтгэлийг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу олон улсын жишиг, парламентын засаглалтай улс орнуудын сайн туршлагыг харгалзан хийхдээ дараах зүйлсийг тусгайлан авч үзэх нь зүйтэй болов уу.

Ардчилсан нийгмийн бодлого боловсруулагч гол институт болох улс төрийн намууд нийгмийн өмнө үүрэг хүлээдэг, хариуцлагатай, судалгаа шинжилгээнд үндэслэн бодлого явуулдаг, санхүүжилт нь ил тод үйл ажиллагаа нь ардчилсан болон төлөвших эрх зүйн үндэс тавигдсан

Дурдсан шалтгааныг эрх зүйн шинэтгэл хийснээр улс төрийн намуудын эрх зүйн орчин сайжирч, тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг нэмэгдэх,

-Улс төрийн намд итгэх иргэдийн итгэл дээшилж, төрийн бодлого, шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэдэг нэг чухал үүрэг бол иргэд, сонгогчдын улс төрийн боловсрол олгох үйл ажиллагаа юм. Нам иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх институтынхээ хувьд мөнгө санхүү, орон нутгийн намын боловсон хүчний чадавхаас шалтгаалан үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх шаардлагатай

Үндсэн хуулийн дээрх зарчимд нийцүүлсэн улс төрийн намыг төлөвшүүлэхийн тулд өнөөгийн монголын улс төрийн намууд нэн тэргүүнд бодлогын нам болон төлөвших цаг үеийн шаардлага урган гарах боллоо. Ингэхийн тулд мэдээж тодорхой шалгууруудыг давах нь зүйн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Нам Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна." гэж заасан нь иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэж улс төрийн нам байгуулах эрхийг баталгаажуулж өгсөн.

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй" гэж, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д "Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох," гэж, 7.1.9-д "хууль тогтоомжид заасан журмын дагуу намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж, сонгогчдод танилцуулах, сурталчлах," гэж тус тус заасан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намууд хуульд нийцүүлж дүрэм, журмаа шинэчлэн бүртгүүлэх зүй ёсны шаардлага үүссэн.


Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт "Намын дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ." гэж, 17 дугаар зүйлийн 17.2.1-д "намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах," гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт "Намын төлөөллийн төв байгууллагын

гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна.” гэж тус тус хуульчилсан боловч нэгэнт үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа улс төрийн намын хувьд дүрэм, журмаа Улсын дээд шүүхэд бүртгүүлчихсэн тул зөвхөн дүрэм, журмаа хуульд нийцүүлэн шинэчлэн батлаад бүртгүүлэх асуудал үүссэн. Энэхүү асуудлыг Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар шийдвэрлэхээр болсон. Тодруулбал, Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ.” гэж заасан. Тус хууль хэрэгжиж эхэлсэн 2024 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын ээлжит сонгууль, 10 дугаар сард орон нутгийн сонгуулийн жил таарсан нь улс төрийн намуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хэд хэдэн хориглосон заалтыг зөрчих магадлал үүссэн нь улс төрийн намууд дүрэм, журмаа өөрчлөх талаар хэлэлцүүлэг, намын бүх шатны гишүүдийн шат шатны хурлуудаа хийж чадахгүйд хүргэсэн гэж болно. Улс төрийн намууд 2024 оны 1 дүгээр сараас эхлэн Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулах, нэр дэвшигчээ тодруулах, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хурал болон шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах, үүний дараа орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаа явагдаж дуустал аль нэг улс төрийн намуудад дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэн засварлах боломж, хугацаа ч хангалттай байгаагүйг онцлох нь зүйтэй.

Ташрамд дурдахад, улс төрийн нам дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намууд хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, намууд их хурлаа хийж тэндээс батлагдсан дүрмийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулахад багагүй хугацаа шаардлагатайг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталж, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн батлуулж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг хойшлуулж улс төрийн намуудад бодит хугацааг тогтоож өгөх хуулийн төслийг санаачлан боловсруулсан. Тус хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжих боломжтой болоод зогсохгүй Улс төрийн намууд дүрэмдээ өөрчлөлт оруулахдаа намын бүх гишүүд, аймаг, нийслэлийн анхан шатны намын нэгж хуралдах, сумын, аймгийн намын хорооны гишүүдээс санал авах, эцэст нь нам их хурлаа хийж тэндээс батлагдсан

дүрмийг Улсын дээд шүүхэд бүртгүүлэх боломж бүрдэх юм.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан мөнхүү бодлогын намын тухай ойлголт 1950-иад оноос хойших үеийн АНУ-ын улс төр судлалаас үүсэлтэй гэж судлаачид үздэг (Downs, 1957; Lipset and Rokkan, 1967). Уг ойлголт нь улс төрийн процессыг иргэд/сонгогчдын болон тэдний хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлыг төлөөлөх, биелүүлэх үүрэг бүхий улс төрч/нам хоёрын хоорондын харилцаа холбооны үр дүнд бий болдог. Энэхүү «principle - agent» онолын суурь агуулга нь дараах таван зарчмаас бүрдэнэ.



Эх сурвалж: Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал.

Я.Төгөлдөр нар. Уб., 2021. 101-102 дахь тал

Бодлогын нам иргэдээс дэмжлэг авахын тулд өрсөлдөгч намаас аль болох өөр үзэл санаанд суурилсан бодлогын хувилбарыг дэвшүүлэхээс гадна үзэл санаагаараа голчлон өрсөлддөг. Бодлого нь ихэнхдээ улс нийтийг хамарсан томоохон зорилттой уялдаатай байдаг бөгөөд сонгуульд тухайн намыг дэмжсэн эсэхээс үл хамаарч бүх нийтэд ашиг тус өгөх зорилттой байх нь элбэг (Төгөлдөр Я, Одмаа Б,

Мягмарсүрэн Д, ба бусад, 2021, хуудсд. 101-102). Бодлогын намын шалгуур үзүүлэлтүүдэд (Herbert Kitschelt, Steven I. Wilkinson, 2007, p. 110) дараах зүйлс багтдаг.


- 1 Намууд хоорондын улс төр, сонгуулийн өрсөлдөөний гол хэрэгсэл нь үзэл баримтлалдаа суурилсан бодлого байх
- 2 Намын дэмжигчдийн сайн сайхны төлөө эсвэл улс төр, эдийн засгийн цөөнхийн бүлэгт үйлчилсэн бодлого хэрэгжүүлэхээс зайлсхийх
- 3 Иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үйл ажиллагааг тогтмол явуулж байх
- 4 Нийгмийн ялгаатай бүлгүүдийн ашиг сонирхлыг жигд илэрхийлэх, төлөөлөхийг хичээж, аль нэг бүлэг давхаргыг илтэд дэмжихээс зайлсхийх
- 5 Иргэдийн саналыг ил далд аргаар худалдаж авах аливаа оролдлогоос эрс татгалздаг, клиентелист аргаар иргэд, сонгогчидтой холбогдохгүй байх

Ийнхүү бодлогын нам болон төлөвшин хөгжихийн тулд улс төрийн намын санхүүжилтийн зөв зохистой төлөвшлийг хангах учиртай. Энэ асуудал бол тулгамдсан сэдэв мөн. Учир нь уг асуудлыг зохистой шийдвэрлэх нь улс төрийн төдийгүй эдийн засгийн үлэмжхэн ач холбогдолтой. Өнөө үед эдийн засгийн хямрал доройтлыг засамжлах, нам дахь авлигын сүлжээг саармагжуулах үйл явц намуудын санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс ихээхэн хамаарч байна. Улс төрийн нам өнөөдөр улс орны улс төрийн амьдрал, үйл явцад онцгой үүрэг нөлөөтэй оролцож байгаа нь бодитой зүйл. Тиймээс намуудын шинэчлэл, түүнийг тойрсон асуудал үнэхээр анхаарал татаж буй нь зүй ёсны хэрэг. Намын санхүүжилтийг аливаа улс төрийн

намын оршихуйн суурь нөхцөл гэж үзвэл бид түүнийг хэрхэн ил тод, нээлттэй шударга зарчимд тулгуурлан гүйцэтгэх сорилттой тулгарч болно. Нам санхүүжилтийн асуудлаа зүй зохистой шийдвэрлэсэн байдлаас хамаарч улс орны улс төрийн амьдрал, тогтолцоо, улмаар эдийн засгийн өнөөгийн байдал төлөв тогтворжин зүгшрэх учиртай. Өдгөө намын санхүүжилтийг үр нөлөөтэй, зохистой шийдвэрлэх ямар хувилбар, боломж, механизм, гарц шийдэл байж болох тал дээр дээр улс төрчид, судлаачид ухаанаа уралдуулж, санал бодлоо идэвхтэй солилцсоор буй.

Улс төрийн намууд бол төлөөллийн ардчилалд онцгой үүрэгтэй оролцогч институт мөн. Энэ агуулгаараа үзэл суртлын болон төрийн бодлого зохицуулалтын үйл хэрэгт чухал нөлөөтэйн дээр улс төр дэх шударга өрсөлдөөнийг дэмжин тэтгэхэд чухал үүрэгтэй. Намууд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээн дамжуулах, бас гүйцэтгэгчийн үүргийг өөртөө хүлээдэг гэдэг утгаараа засгийн газрын шийдвэр, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах үр нөлөөтэй суваг, чухал механизм нь улс төрийн намууд юм. Улс төрийн намууд өөрт хамаарах үүргээ ардчилсан, үр өгөөжтэй байдлаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн болон бусад бодит эх үүсвэр, эдийн засгийн нөөцийн хувьд хүчтэй байж, түүний дэмжлэгт дулдуйдах нь тэдний оршин тогтнох хийгээд улс төрийн намуудын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь нөхцөл нь болдгийг ямагт ухамсарлаж байх учиртай. Эцэст нь тэмдэглэхэд, Томас Гоббс ардчилал нь норматив (хэм хэмжээтэй) байх ёстой бөгөөд нийгмийн тэгш байдал, шударга ёсонд хүн бүр ижил тэгш байхыг чухалчилж байсан нь өнөөгийн бидний өмнө тулгарч буй гол сорилт болж байна. Нийгмийн тэгш байдал, шударга ёсонд хүн бүр ижил тэгш байхын зэрэгцээ нийгмийн болоод ард түмний ашиг сонирхол, эрх чөлөөний төлөө өөрийн сэтгэлийн дуудлага болон байгалиас заяасан шударга зан төлөвийг урьтал болгох нь утгаа сэтгэлийн гүнд буй өөрийн зөрчлөөсөө ангижрах боломжийг бий болгож буйн илрэл хэмээн дэвшүүлсэнийг эргэн санах нь зүйн. /Зураг 2/

Зураг 2. Монголчуудын улс төрийн мэдлэг, иргэнлиг байдлын тухайд



Эх сурвалж: «Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох нь» Экспертийн судалгаа. Улс төр, эрх зүйн салбар, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 2019


Улс төрийн намуудын улс төрийн соёлын төлөвшлийг дараах долоон үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэхэд улс төрийн намуудад дунджаас доогуур үнэлгээ өгсөн хэдий ч эрх баригч намын хувьд бусад намаас дөнгөж +0.1 пунктээр илүү байгаа нь тухайн улс төрийн намуудын улс төрийн соёлын төлөвшлийн өнөөгийн байдал хангалтгүй түвшинд байгааг судалгааны үр дүн нотлон харуулж байна. Монголчуудын улс төрийн мэдлэг ба иргэнлэг байдлын тухайд үзэхүл, улс төрийн хэв маягууд бодит байдал дээр улс төрийн амьдралын олон талт, нарийн төвөгтэй шинжийг тусгаж чадахгүйн дээр улс төрийн холимог хэв маягууд зонхилж байгааг илтгэнэ (Энхболд Д., Хатанболд О, 2019). Дурдсан судалгаанд оролцогчдын хувьд ардчилалд саад болж буй хүчин зүйлсийг тодорхойлсон ойлголтуудын хамгийн их давтамжтай хариултын агуулгаар нь багцлан үзвэл: иргэдийн улс төрийн мэдлэг боловсрол сул, улс төрийн ташаа ойлголттой (28.3%), улс төрийн оролцоо сул, авлига, улс төрийн санхүүжилтийн асуудал (16.6%), улс төрийн тогтолцоо, төрийн эрх мэдлийн хуваарилалтын алдаа (10.5%), улс төрийн намын төлөвшил (8.3%) гэсэн агуулга өндөр үзүүлэлттэй байгаа нь дээрх судалгааны дүнтэй мөн таарч байна. Нэг үгээр бол, соёл, институт хоёрын харилцаа холбоо нарийн бөгөөд хэдийд аль нь илүү хөдлөнг шинжтэй байна гэдгээс харилцан үйлчлэлийн шинж чанар нь хамаарахыг судалгаанд хамрагдсан шинжээчид тодорхойлсон. Тухайлбал, шинжээчдийн дийлэнх нь улс төрийн соёлын төлөвшлийг дундаас доош, тэр тусмаа бүрэлдэх төдий шатанд явж буй хэмээн 51.3 хувь нь 2-3 оноогоор, 28.2 хувь нь 4-5 оноогоор тус тус үнэлж «тааруу» хэмээн дүгнэжээ. Чингэхдээ дараах гол агуулгыг чухалчилсан байна.

Улс төрийн соёл, ёс зүйн агуулгын хүрээнд - Засгийн газрын ёс зүйгүй байдал - Улс төрийн соёлын суурь тогтолцоо бүрдээгүй. - Улс төрийн голлох 2 нам ардчилсан улс төрийн шударга зарчим баримталдаггүй. - Үзэл баримтлалаасаа ямагт няцдаг. - Иргэний нийгмийн орон зай хязгаарлагдсан. - Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх	Бүлэглэлийн хүрээнд асуудал шийдвэрлэх - Улс төрийн нам-бизнесийн олигарх бүлэглэл бий болсон. - Хувийн эрх ашгийг илүү үзэж ашиг сонирхлын зөрчилд өртөх. - Авлигад өртөмтгий байдлаас үүдэлтэйгээр хөгжлийн ухралтад орсон. - Хууль, эрх зүйн хэрэгжилт сул, хариуцлагын тогтолцоо улам дордсон.
---	---

Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдлын талаарх судалгаанд (АТГ, 2023, хууд. 106) оролцсон шинжээчдийн төсөөллийг нэгтгэсэн байдлаас үзвэл, хамгийн их авлигад автсан байж болох намыг нэрлүүлэхэд:

судалгаанд оролцсон шинжээчдийн 35.6 хувь өнөөгийн эрх барьж буй Монгол Ардын Нам (МАН)-ыг «хамгийн их» авлигад автагдсан хэмээн үзжээ. Харин тэдний 37.4 хувь нь Ардчилсан Нам (АН)-ыг, 9.5 хувь нь Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ыг, 10.4 хувь нь Хөдөлмөрийн Үндэсний Нам (ХҮН)-ыг, 1.7 хувь нь Монголын Ногоон Нам (МНН)-ыг тус тус нэрлэжээ. Харин улс төрийн бусад намуудыг 5.2 хувь нь авлигад автсан гэсэн төсөөлөлтэй буйгаа илэрхийлсэн байна. Судалгаанд хамрагдсан нийт шинжээчдийн 73 хувь МАН, АН тус бүрийг авлигад автсан гэсэн төсөөлөлтэй байгаа нь доорх зургаас харагдана (Зураг 3).

Зураг 3. Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдал (харьцуулсан дүнгээр)



Эх сурвалж: Улс төрийн хүрээнд авлигын төсөөлөл. Шинжээчдийн судалгааны дүнгээс. АТГ, УБ, 2021 (а), 2022 (б).

Монгол Улс дахь улс төрийн намуудын авлигад автсан байдлын талаар 2022 оны судалгаанд оролцсон шинжээчдийн байр суурийг тодруулахад эрх барьж буй намын авлигад өртөх байдал илүү өндөр болохыг илэрхийлж байв. Улс төрийн намуудын авлигад автсан байдлын талаарх үнэлгээг ихээх нь бага руу эрэмбэлүүлэхэд: судалгаанд хамрагдсан нийт шинжээчдийн 41.3 хувь өнөөгийн эрх барьж буй Монгол Ардын Нам (МАН)-ыг хамгийн их авлигад автагдсан хэмээн үзжээ. Түүнчлэн, 77.8 хувь МАН, АН-ыг илүү их авлигад автсан хэмээн төсөөл буйг эндээс харч болохоор байна.

ГУРАВ.

УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Тухайн улс орнуудын одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндсэн хууль дахь улс төрийн намын зохицуулалт, түүний хуулиар олгогдсон бүрэн эрх, хязгаарлалт, эрх үүрэг зэргийг гол голлон авч үзэв. Ингэхдээ тухайн улс орнуудын үндсэн хууль дахь улс төрийн намуудын зохицуулалтын агуулгын сэдвүүдийг тусгасан Харьцуулсан Үндсэн хууль (Comparative Constitutions Project's Dataset)-ийн төслийн өгөгдлийн багц дахь хувьсагчдад үндэслэн боловсруулав. Тодруулбал, улс төрийн намуудыг, ялангуяа зарим орнуудын улс төрийн намуудын талаарх зохицуулалтыг тухайн улс орнуудын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндсэн хуульд зааснаас өөрөөр буюу түүнийг зөрчсөн эсэхийг тогтоох үүрэгтэй намуудыг зохицуулах эрх бүхий төрийн эрх мэдлийн ямар салбар, байгууллага зэргийг харьцуулалтын хүрээнд тусгайлан судалсан болно. Энэ хүрээнд Харьцуулсан Үндсэн хууль (Comparative Constitutions Project's Dataset)-ийн цахим санд буй нийт улсаас хорин найман улсыг засаглалын хэлбэр, "ардчилсан" үндсэн хуулийн төлөвшил болон төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, бүгд найрамдах засаглалтай улс орнуудыг сонгон авч тойм шинжилгээ хийснийг дараах байдлаар танилцуулж байна.

Хүснэгт 1. Улс төрийн намын талаарх зохицуулалтыг тодорхой хувьсагч болгон асуулгын хэлбэрээр ангилсан байдал

№	Улсын нэр	Улс төрийн намын тодорхойлолт	УТН-д тусгайлан хориглосон үйл ажиллагаа	УТН-ын эрх, үүргийг зохицуулсан байдал	УТН-ыг албан ёсоор бүртгэх субъектийн зохицуулалт	УТН-ын санхүүжилтийн ил тод байдлын талаарх зохицуулалт
1	Албани		✓	✓	✓	
2	Армени	✓	✓	✓	✓	✓
3	Бутан	✓	✓	✓	✓	✓
4	Болгар	✓	✓	✓	✓	
5	Буркина Фасо		✓	✓	✓	
6	БН Молдав Улс		✓	✓	✓	
7	БН Солонгос Улс		✓	✓	✓	✓
8	Гайана	✓	✓	✓	✓	
9	Гамби	✓	✓	✓	✓	✓
10	Герман		✓	✓	✓	✓
11	Гүрж	✓	✓	✓	✓	

№	Улсын нэр	Улс төрийн намын тодорхойлолт	УТН-д тусгайлан хориглосон үйл ажиллагаа	УТН-ын эрх, үүргийг зохицуулсан байдал	УТН-ыг албан ёсоор бүртгэх субъектийн зохицуулалт	УТН-ын санхүүжилтийн ил тод байдлын талаарх зохицуулалт
12	Египет		✓	✓	✓	
13	Кебо Верде	✓	✓	✓	✓	✓
14	Литва		✓	✓	✓	
15	Либерии	✓	✓	✓	✓	
16	Мексик	✓	✓	✓	✓	✓
17	Мьянмар	✓	✓	✓	✓	✓
18	Польш	✓	✓	✓	✓	✓
19	Румын	✓	✓	✓	✓	
20	Словак			✓	✓	
21	Словени		✓	✓	✓	
22	Тайвань		✓	✓	✓	
23	БН Турк Улс		✓	✓	✓	✓
24	Филиппин	✓	✓	✓	✓	✓
25	Хорват		✓	✓	✓	✓
26	Чад		✓	✓	✓	
27	Чили		✓	✓	✓	✓
28	Эстони		✓	✓	✓	

Дээрх харьцуулалтад хамрагдсан улсуудын 50 гаруй хувь нь улс төрийн намыг хуулийн хүрээнд байгуулж, үйл ажиллагааг нь явуулж ирсэн нь улс төрийн намыг нийгмийн болон улс төрийн амьдралын салшгүй бүрэлдэхүүн хэмээн үзэж буйг илтгэж байна. Үүнийг тодруулбал «...үндэсний бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс, ардчиллын зарчмуудыг эрхэмлэн, иргэдийн улс төрийн хүсэл зоригийг үгүйсгэх, илэрхийлэхэд хувь нэмрээ оруулна; ... мөн улс төрийн намуудын гол зорилго нь ардчилалд ард түмний оролцоог дэмжих, үндэсний төлөөллийн байгууллага, иргэний байгууллагуудын нэгдмэл байдлыг дэмжих, хөтөлбөр, зарчим, үзэл баримтлалын дагуу иргэдийн төрийн эрх мэдэлд хүрэх боломжийг хангах; ...бүх нийтийн, чөлөөтэй, нууц, шууд санал хураалтаар үндэсний болон орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийн жендэрийн тэгш байдлыг баталгаажуулсан дүрэмтэй байна» гэж тухайн улсуудын үндсэн хуулинд нийтлэг байдлаар тодорхойлогдсон байна. Харьцуулсан судалгааны үр дүнд дараах тодорхой зарчмуудыг улс төрийн намууд үндсэн үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байгааг анхаарч үзэх учиртай.

Нэмж хэлэхэд, харьцуулсан судалгаанд хамрагдсан хорин найман улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндсэн хууль дахь улс төрийн намын зохицуулалт, түүний хуулиар олгогдсон бүрэн эрх, хязгаарлалт, эрх үүрэг зэрэгт тулгуурлан дараах шинжилгээг хийв. Тус шинжилгээгээр улс орнуудын ардчиллыг бэхжүүлэхийн төлөө гүйцэтгэж байгаа зонхилох загваруудаас үл хамааран улс төрийн намын талаар баримталж буй хууль тогтоомжийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг зарчмуудыг мөрдлөгө болгох зорилгоор дараах байдлаар танилцуулж байна.

ЗАРЧИМ 1. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба легитимт шинж

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг нийгмийн үнэт зүйлс болгон тээх үүргийг улс төрийн намууд хариуцлагатай, ёс зүйтэй биелүүлэхийг чандлан сахиж, түүнийг хангахын төлөө ямагт эрмэлзэхийг чухалчлах ёстой. Улс төрийн намууд өөрийн удирдлагын сайн засаглалтай байж түүгээр дамжуулан хариуцлагын суурь зарчмуудыг намын дотоод ардчилал, өдөр тутмын үйл ажиллагааны үндэс, хэм хэмжээ болгон төлөвшүүлэхийг урьтал болгоход анхаарч ажиллахад эвлэлдэн нэгдэх эрх чөлөө түүний легитимт шинж чиглэгдэнэ. Намуудын мөрдлөгө болгон баримталдаг дүрэм нь тухайн улс төрийн намын дотоод, гадаад орчинтой харилцах харилцаа, үйл ажиллагааг зохицуулахад оршино. Энэ нь прагматик шинжтэй байхаас бус норматив зарчим болох учиргүй. Улс төрийн намын тогтолцоо нь зөвхөн үндсэн эрх, зөв бодлогод нийцэхийг урьтал болгохын сацуу тэрхүү зөв бодлогоо үр дүнтэй засгийн газрын бодлогоор хэрэгжүүлж ардчилсан төрийг бэхжүүлэх хууль ёсны хэрэгсэл болгохыг тэргүүнд үзнэ. Энэ зорилгоор улс төрийн орон зайд тодорхой уялдаа холбоог хангах үүднээс жижиг намуудын сонгогдох, парламентад бие даан ажиллах, төрийн эх үүсвэрээс хүртэх зэрэгт тодорхой хязгаарлалт тавих явдал улс төрийн намуудад чухлаар тавигдах учиртай. Улс төрийн намын эвлэлдэн нэгдэх эрх чөлөө бол ямар нэгэн хөндлөнгийн оролцооноос ангид байж, өөрийн намын дотоод, гадаад үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглосон аливаа үйл ажиллагаа явуулаагүй л бол тухайн намын үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах, татан буулгахыг үл зөвшөөрнө.

ЗАРЧИМ 2. Хүндлэх, хамгаалах, дэмжих үүргээ ухамсарлах

Аливаа улсын төр хувь хүний болоод сонирхогч талуудын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангахад дэмжлэг үзүүлэхийн сацуу үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцох гадны эрсдэлээс хамгаалах, авч хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрт нь хүндэтгэлтэй хандах үүрэгтэй. Тэрхүү үүрэг нь улс төрийн намуудын нэр дэвшигчид, дэмжигчдийг аливаа хүчирхийллээс хамгаалах зохих бодлого, арга хэмжээг төр хариуцана гэсэн үг. Улс төрийн намыг бусадтай чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, шинээр нам эвсэл үүсгэн байгуулах эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхэд шаардлагатай механизмыг холбогдох ерөнхий болон тусгай хууль тогтоомжоор хангах нь төрийн үүрэг. Энэ үүрэгт улс төрийн намуудын хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагаанд төрийн зүгээс дарамт,

шахалт учруулахгүй байх явдал хэмээн үзэх нь зүйтэй. Чухамдаа төр бол улс төрийн намуудын хуулиар олгогдсон эрхийг хамгаалах үүрэгтэй ч, улс төрийн намууд мөн адил нийгэм, олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлэх үүрэгтэй. Улс төрийн намууд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг аль нэг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөн зэрэг олон нийтийн байгууллагуудын төлөөллөөс хийж буй аливаа арга хэмжээ, үзэл бодлыг шүүмжлэх хэлбэрээр тэдний эсрэг үзэл бодлоо илэрхийлж жагсаал цуглаан хийх эрхтэй. Энэ эрхээ эдлэх явцдаа ямар нэгэн хүчирхийлэлд уриалах, өдөөн хатгах, уриалан сэдэлжүүлэхийг хатуу хориглохыг харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын үндсэн хуульд нийтлэг туссан байна. Хэрэв ийм төрлийн үйл ажиллагаа явуулсан, зохион байгуулсан эсхүл өдөөн турхирсан бол хуулийн хатуу шийтгэл ногдуулдаг болох нь харьцуулсан судалгаагаар илэрсэн.

ЗАРЧИМ 3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Улс төрийн намууд зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд эрх баригчид, албан тушаалтнууд, шийдвэр гаргагчдад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ бол улс төрийн намууд, тэдгээрийн гишүүдийн баримталж буй байр суурь нь төрийн бодлоготой нийцэж байгаа эсэх, хууль эрх зүй, нийгмийн өөрчлөлтийг дэмжигч, эсвэл зарим хүмүүсийн дургүйцлийг хүргэж, доромжилсон байр суурьтай эсэхээс үл хамааран улс төрийн, олон нийтийн мэтгэлцээнд оролцох бүрэн эрхтэйг илтгэж буй хэрэг. Энэхүү зарчим нь эвлэлдэн нэгдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хоорондын хамаарлыг хангах, цаашлаад олон ургалч үзлийг ардчиллын зохистой үйл ажиллагаагаар дамжуулан бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс улс төрийн намууд өөрийн бодлого, үзэл баримтлалдаа тууштай байж, үүсэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж чаддаг байхаас гадна дан ганц улс төрийн намын үзэл баримтлалд дулдуйдах бус хувь хүмүүсийн хуулиар олгогдсон эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах нэгдсэн үзэл санаатайгаар эрхээ эдлэхийг хүссэн хүн бүрийн төлөө энэхүү эрхийг хэрэгжүүлж, түүний төлөө шударгаар зүтгэхийг улс төрийн намууд үргэлж хүсэмжилж байх зарчим улс орнуудын үндсэн хуулийн зохицуулалтад нийтлэг тусгагдсан байна.

ЗАРЧИМ 4. Улс төрийн плюрализм (олон ургалч үзэл)

Улс төрийн намуудын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж нь олон ургалч үзлийг эрхэмлэсэн улс төрийн орчныг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Нэг ёсондоо хувь хүмүүсийн улс төрийн олон янзын үзэл бодлыг эрэлхийлэх, мэдээллээ олж авах, сурталчлах чадвар нь улс төрийн намын мөрийн хөтөлбөрөөр дамжуулан хүчирхэг ардчилсан нийгмийн чухал элемент гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг байх нь хувь хүмүүсийг эрх чөлөөтэй байлгахын тулд зайлшгүй шаардлагатай алхам болно. Улс төрийн намууд мөнхүү сонголтод хөндлөнгөөс нөлөөлөхгүйн тулд хувь хүний сонголт хийх эрхийг дээдэлж, хүндэтгэлтэй хандах учиртай. Улс төрийн олон ургалч үзэл бол үр дүнтэй ардчилсан засаглалыг хангах, иргэдэд хэрхэн засаглахаа сонгох жинхэнэ боломжийг олгодоггоороо чухал ач холбогдолтой.

Үндсэн хууль дахь улс төрийн намын талаарх зохицуулалт болон улс төрийн намын тухай хууль тогтоомж нь олон ургалч үзлийг бүх хүн, бүлэг, тэр дундаа цөөнхийн оролцоог баталгаажуулах хэрэгсэл юм. Энэ утгаараа ямагт дэмжиж ажиллах нийгмийн үүрэг улс төрийн намуудад төлөвшсөн байх нь чухал. Учир нь улс төрийн нам нь нийгмийн харилцаа, олон нийтийн өдөр тутмын амьдралд сөрөг хүчний үзэл бодлыг илэрхийлэх, эрх мэдлийн ардчилсан шилжилтийг хийх боломжийг үргэлж олгодог, ард түмний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талбар байхыг чухалчилсан хуулийн нийтлэг агуулга ажиглагдаж байна.

ЗАРЧИМ 5. Хууль ёсны хязгаарлалт

Хувь хүний болон улс төрийн намын эвлэлдэн нэгдэх үндсэн эрхийг хязгаарласан аливаа хязгаарлалт нь олон улсын жишигт нийцсэн байна. Нэг ёсондоо хуулиар тогтоосон, олон улсын жишгээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны зорилгыг эрхэмлэн дээдэлнэ гэсэн үг. Тодруулбал, холбогдох хууль нь нарийн тодорхой, урьдчилан харж болохуйц байхаас гадна төрийн эрх бүхий этгээдэд ямар нэгэн үзэмжээр хандах эрх олгосон заалтуудыг хязгаарласан байна. Хэрэв ямар нэгэн байдлаар эрх бүхий этгээдэд тусгайлан үзэмжээр хандсан заалт буй аваас түүнийг хэрхэн тайлбарлах, хэрэглэх талаар үндэслэлтэй заалтаар томъёолсон байх учиртай. Хэрэв хууль зөрчсөн тохиолдолд түүнээс үүдэн гарах үр дагаварыг урьдчилан таамагласан аливаа хязгаарлалтуудыг ойлгомжтой, шударга хэрэгжих ёстой гэдгийг улс төрийн намууд түүний удирдлага, жирийн гишүүд, дэмжигчид бүгдээр ухамсарлаж ойлгосон байхыг шаардана. Энэ бол хууль бүх хүнд ижил тэгш үйлчлэх ёстой учраас хувь хүн ч, улс төрийн намууд ч өөрсдийн эрх ашгаа ухамсарлаж, зан үйл, үйл ажиллагаагаа хуульд нийцүүлэн явуулах бүх боломжийг бүрдүүлж, хүртээмжтэй олон нийтийн оролцоо, хяналтаар баталгаажсан ардчилсан үйл явцаар илэрхийлэгдэнэ. Улс төрийн намуудын болон тэдгээрийн гишүүдийн чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан аливаа хязгаарлалт нь "улс орны болон ард түмний аюулгүй байдал, тусгаар тогтнол, эмх замбараагүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах" зэрэг үндэсний эрх ашгийг хөндсөнөөс бусад тохиолдолд үндэслэсэн хязгаарлалтаас бусдыг энд хязгаарлахгүй хэмээн ойлгоно.

ЗАРЧИМ 6. Хууль ёсны хязгаарлалтын хэрэгцээ ба тэнцвэрт байдал

Улс төрийн намуудын эрхийг хязгаарлах аливаа хязгаарлалт нь ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай байж болох ч, энэ нь тодорхой мөн чанар, цаг хугацааны хувьд тэнцвэртэй байх зарчмыг баримтална. Нэг үгээр хууль ёсны хязгаарлалтын хэрэгцээг сайтар нягталж үзсэний үндсэн дээр тухайн сонгосон хязгаарлалтыг тэнцвэрт байдлаар хэрэгжүүлж тавьсан зорилгодоо хүрэхэд улс төрийн намуудад зарим нэгэн саад тодгор учирч болзошгүй. Гэхдээ хууль ёсны аливаа хязгаарлалт нь тухайн улс төрийн намын үйл хэрэг, зорилго үзэл баримтлалд санаатайгаар саад учруулах арга хэрэгсэл болох ёсгүй. Ялангуяа улс

төрийн намуудын хувьд тэдний ардчиллын үйл явц дахь үндсэн үүргийг нь харгалзан хориглох арга хэмжээг явцуу хэрэглэж, эрхийг хэзээ ч бүрэн унтрааж, намын дотоод мөн чанарт нь үл халдана. Улс төрийн нам байгуулахыг нь хориглох, улс төрийн намыг татан буулгах зэрэг нь эцсийн арга хэмжээ бөгөөд онцгой тохиолдолд л хатуу нөхцөл ногдуулах учиртай. Улс төрийн намуудын хууль ёсны зорилгодоо хүрэх аливаа арга хэмжээ нь ардчилсан нийгэмд зайлшгүй байх ёстой үзэгдэл тул төрөөс "нийгмийн тулгамдсан хэрэгцээ", "холбогдох хангалттай" шалтгаан байгаа эсэхийг нь нотлох шаардлагатай. Ингэхдээ улс төрийн намуудын чөлөөт эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлаж болох аливаа хязгаарлалтыг улс орон бүр шүүхийн явцуу утгаар тайлбарлаж, шийдвэрийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудын зохицуулалтыг хязгаарлагдмал байдлаар нэвтрүүлж, хэрэгжүүлэх ёстой. Түүнчлэн улс төрийн намыг байгуулах, үйл ажиллагааг нь зохицуулахад тавих аливаа хязгаарлалт нь тэнцвэртэй байхаас гадна тухайн намын хууль ёсны зорилгоо хязгаарлах арга хэрэгсэл болох үүргээ биелүүлч чадахгүй тохиолдолд л татан буулгахыг эцсийн арга хэрэгсэл болгон хэрэглэнэ. Энэ бол улс орнуудын үндсэн хуульд буй улс төрийн намын зохицуулалтын хамгийн хатуу шийтгэл бөгөөд зөвхөн ноцтой зөрчил илэрсэн онцгой тохиолдолд оногдуулсан шийтгэл хэмээн үзсэнийг харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын үндсэн хуулийн зохицуулалтууд баталсан байна.

ЗАРЧИМ 7. Үр дүнтэй арга хэмжээ

Аливаа улс төрийн намыг татан буулгахтай холбоотой асуудал нь иргэний эрх бус улс төрийн эрхтэй холбоотой байдаг учраас энэ асуудалтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа бол хамгийн үр дүнтэй, шударга шүүхийг шаардана. Өөрөөр хэлбэл, улс төрийн намуудын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний намын бие даасан байдлын амин сүнс нь юм. Нөгөөтээгүүр ардчилсан үйл явцын үндэс болохын хувьд улс төрийн намуудад тавьсан аливаа хязгаарлалт нь ямар нэгэн үр дагаварт хүргэж болзошгүйг харгалзан улс төрийн үйл ажиллагаанд нь тавих хязгаарлалтад няхуур нухацтай хандах учиртай. Намын эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хараат бус шүүхээр, наад зах нь эцсийн шатны шүүхээр хянуулах боломжтой байхаар шийдвэрлэнэ. Улс төрийн намыг хориглох/татан буулгах асуудлыг ч мөн адил бие даасан шүүх ямагт шийдвэрлэх ёстой нь нэг талаас үр дүнтэй арга хэмжээ авч буй хэрэг мөн. Үр дүнтэй байх зарчим нь зарим арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэхийг шаардаж буй явдал бөгөөд аливаа эмчилгээг зохих стандартын дагуу үр дүнтэй хийгээгүйн улмаас үүдэн гарах аливаа эрсдэл нь улс төрийн намын эрүүлжих үйл явцын үнэ цэнийг бууруулж, үр дүнгүй болгодогтой адил зүйл гэдгийг эл зарчмаас харж үйл ажиллагаандаа удирдлага болгох нь зүйн.

ЗАРЧИМ 8. Улс төрийн намуудад тэгш хандах

Улс төрийн нам байгуулахыг зорьж буй хувь хүн, бүлгүүд бүгд хуулийн өмнө тэгш эрхтэй. Улс төрийн намаар эвлэлдэн нэгдэхийг хүссэн хувь хүн, бүлэг нь энэ үйл ажиллагаанд давуу байдлаар хандаж, ямар нэгэн сөрөг

нөлөө үзүүлэх ёсгүй. Ялангуяа улс төрийн намуудын талаарх төрийн зохицуулалт нь хувь хүн, бүлгийг хүйс, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, үндэсний цөөнх, өмч хөрөнгө, нийгмийн статус гэх мэт аливаа үндэслэлээр нь ялгаварлан гадуурхаж хэрхэвч болохгүй гэсэн үг. Улс төрийн намуудыг улс төрийн мөрийн хөтөлбөр, гишүүнчлэлээр нь ялгаварлан гадуурхаж үл болох бөгөөд зарим төрлийн ялгааг объектив үндэслэлтэйгээр зөвтгөж болох юм. Тухайлбал, намууд "нам" байх статусаас тодорхой үр өгөөж хүртэхээсээ өмнө тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхийг шаардах явдлыг хүлээн зөвшөөрч болно. Мөн томоохон намуудад хангалттай шийтгэл, таслан зогсоох нөлөө үзүүлсээр байхад шинэ эсвэл жижиг намуудад үндэслэлгүй дарамт учруулахгүйн тулд дүрэм журмын хэрэгжилтийн чанд хатуу байдал, зөрчил ногдуулах шийтгэлийг талуудын хэмжээ, нөөцөд тохируулахыг зөвшөөрч бас болно. Төрийн албан хаагчид ч мөн улс төрийн намуудтай адил тэгш харьцаж, улс төрийн намыг байгуулах, бүртгэх, үйл ажиллагаанд шударгаар хандах ёстой. Албан хаагчид аль нэг улс төрийн намд давуу эрх олгож, заримыг нь хохироох зорилготойгоор аливаа арга хэмжээ авахаас татгалзна. Эдгээр нь намуудын гишүүнчлэлийн тоо, нийгэмд үзүүлж буй нөлөөллийнх нь хувьд ижил тэгш байр сууринаас хандах суурь үндэс болно. Парламентад аль хэдийн суудалтай болон парламентад огт суудалгүй намуудаас илүү өндөр түвшний төрийн дэмжлэг авч болох ч тайлагналын процессоос илэрсэн зөрчлөөс үүдэлтэйгээр илүү хатуу хариуцлага хүлээх явдал гарч болзошгүйг ямагт анхаарах нь зүйн. Улс төрийн бүх намуудад эрх баригчдын ялгаварлан гадуурхалт, тэгш бус харьцаанаас ангид сонгуульд оролцох боломжийг бүх талаар олгох нь улс төрийн намуудад төвийг сахисан үзэл хандлага төлөвшиж тогтсон байхыг илтгэнэ.

ЗАРЧИМ 9. Намын дотрох эрх тэгш байдал ба дотоод ардчилал

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө гэдэг нь явцуу утгаараа аль нэг эвлэлдэн нэгдэж байгаа эсхүл хэн нэгэн гишүүнд харьяалагдаж буй тодорхой тооны хүмүүс хэнтэй эвлэлдэн нэгдэх, хэнийг гишүүнээр элсүүлэхээ сонгох эрхийг олгодог үйл явц гэж ойлгож болно. Иймээс улс төрийн нам өөрийн суурь зарчим, итгэл үнэмшил, үнэт зүйлээ хуваалцадгүй хүмүүсийг гишүүн, нэр дэвшигчээр хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэсэн үг. Эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжигч тал нь ялгаварлан гадуурхахыг хориглодог учраас сонгох эрх чөлөө нь хязгааргүй зүйл огт биш. Түүнээс гадна хувь хүний шинж чанарт үндэслэсэн холбоо байгуулах, гишүүнээр элсэхтэй холбоотой аливаа нэг ялгавартай хандлагыг бий болгодог. Эл ялгаа нь арьсны өнгө, угсаатны гарал үүсэл, эсвэл хувь хүний хувийн амьдралд хамаарах тохиолдлууд, тухайлбал, хүйсийн ба бэлгийн чиг баримжаагаар харьцах ялгаа байгаа тохиолдолд үүнийг "хүндтэй шалтгаан" хэмээн үзэх ёстой. Улс төрийн амьдралд тэгш оролцох боломжийг хангах, бүтцийн түүхэн тэгш бус байдлыг арилгах зорилгоор улс төрийн нам доторх эмэгтэйчүүд, хүмүүсийн бодит тэгш байдлыг хангахад чиглэсэн түр зуурын тусгай арга хэмжээ авахыг улс төрийн намууд дотроо тэгш харьцах зарчим бий болгохыг үгүйсгэхгүй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй болон

өмнө нь үндэс угсаа, арьс өнгөөрөө ялгаварлан гадуурхалтад өртөж байсан хэн нэгнийг үзэл бодлоо илэрхийлэхэд хувь нэмрээ оруулахад намын дотоод ардчилал, шударга өрсөлдөөн чухал үүрэг гүйцэтгэнэ.

ЗАРЧИМ 10. Улс төрийн намын сайн удирдлага

Улс төрийн намтай холбоотой хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааных хэрэгжилтийг төрийн эрх бүхий байгууллага, тэр дундаа төрийн байгууллага, шүүх, хууль хяналтын байгууллагуудын аль алинд нь аль нэг талыг баримтлан, хэн нэгний нөлөөллөөс ангид, шударга үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэнэ. Эдгээр эрх бүхий байгууллага нь улс төрийн намууд, тэр дундаа олон нийтийг өөрсдийн үйл ажиллагааны журам, үйл ажиллагааны талаарх ойлгомжтой мэдээллээр хангана. Эрх бүхий байгууллагын эрх мэдлийн хамрах хүрээг хуулиар тодорхой, урьдчилан тодорхойлсон байх бөгөөд тэдгээрт ажиллаж буй ажилтнууд бүгд зохих мэргэшилтэйгээс гадна зохих хяналтад байх ёстой. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, актыг хараат бусаар хянан үзэхэд боломжтой, нээлттэй, ил тод байх учиртай. Төрийн байгууллагын ажилтнууд үүрэг даалгавраа хичээнгүйлэн гүйцэтгэж, алдаа дутагдлыг засч залруулж, урвуулан ашигласан тохиолдолд хариуцлага тооцох механизмтай байна.

ЗАРЧИМ 11. Хариуцлагатай байх

Улс төрийн намууд сонгуульд оролцож ялалт байгуулсны дараа бусад холбоодод байхгүй хуулийн тодорхой эрх ямба эдэлнэ. Ялангуяа улс төрийн санхүүжилт, сонгуулийн кампанит ажлын үеэр хэвлэл мэдээллийн эх сурвалжийг ашиглах боломжийн хүрээнд улс төрийн намууд давуу эрхтэй байж болох цорын ганц салбар биш. Бусад холбоодод эрх ямба олгоогүй, олон нийтийн ярианд эсвэл сонгуулийн үр дүнд гүйцэтгэх үүрэг зэрэгтэй холбоотойгоор улс төрийн намуудад тодорхой үүрэг хариуцлага хүлээлгэх нь зүйтэй. Эдгээр нь тайлагналын шаардлага, санхүүгийн зохицуулалтын ил тод байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийг тусгайлан төлбөртэйгээр ашиглахыг хязгаарлаж буй хэрэг мөн. Цаашлаад бүлгүүдийн хувьд иргэдийн оролцоог тэгш хамруулах боломжийг хангах зохицуулалтын хэлбэрүүд байж болно. Тухайн тохиолдол бүрт оногдуулах нэмэгдэл үүрэг нь улс төрийн намуудын тусгай эрх ямбатай шууд хамааралтай, тэнцвэртэй байдал зэрэг нь улс төрийн нам байгуулах, сонгуульд оролцохтой холбогдсон аливаа эрх, үүргийг дагаж мөрдөх суурь үндэслэл болж байна. Улс төрийн намууд өөрсдөөдөө олгосон эрх ямбаа хүртэхдээ олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, тэр дундаа эмэгтэйчүүд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн төлөөлөлтэй холбоотой үүрэг хариуцлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах шаардлагатайг харьцуулсан судалгаанд хамрагдсан хорин найман улсын үндсэн хуульд тодорхой тусгагдсан байна.

ДУГНЭЛТ


Улс төрийн намууд өмгөөллийн болон улс төрийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад холбоодоос ялгарах нэг зүйл байдаг нь нэр дэвшигчдийг танилцуулах явдал юм. Ингэхдээ албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хууль дүрмийг чандлан сахидаг, хатуу сахилга баттай этгээдийг нэр дэвшүүлж чадаж гэмээ нь улс төрийн сонгуульд ялалт байгуулж, ард түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн засгийн газар байгуулж бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжтой. Харин хууль бус, хүчирхийллийн замаар ард иргэдийг эвлэлдэн нэгтгэх, тэдний үзэл бодлыг хааж боогдуулах механизмыг бий болгох замаар онцгой эрх ямба эдлэх санаархал өвөртлөх ёсгүй. Чингэх аваас нийгмийн харилцаа ганхаж, ардчилсан хууль дээдлэх ёс ч гажуудан замхрах эрсдэлтэй болохыг тус харьцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын үндсэн хуулийн суурь зарчим төвлөрч байна.

Судалгаанд хөндөгдсөн дараагийн чухал санаа бол улс төрийн намууд нь хүний сонгох, сонгогдох үндсэн эрхийг хэрэгжүүлэх суурь орчин болохын хувьд үндсэн хуулийн суурь зарчмыг дээдэлж, шударга шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэхээс ямагт татгалзаж, түүнээс зайлсхийхийг тунхагласан явдал байлаа. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад улс төрийн намын нийгэм дэх байр суурь, хууль ёсны байдал суларсаар байгаа ч улс төрийн оролцоо, бусад холбогдох эрхийг хэрэгжүүлэхэд хамгийн өргөн хэрэглэгддэг хэрэгсэл хэвээр байгаад зогсохгүй одоог хүртэл түүнийг орон зайг орлох хууль ёсны өөр хувилбар гарч ирээгүй байгаа нь үнэн. Улс төрийн намууд улс төрийн мэтгэлцээнд нийгмийн янз бүрийн бүлгүүд, тэр дундаа цөөнхийн төлөөллийг хангахад тэргүүн эгнээнд оролцох үүрэг нь хэвээр байсаар л байна. Улс төрийн олон ургалч үзлийг эрхэмлэн дээдлэх нийгмийн нэн чухал байр суурийг бүрдүүлсээр байгаа учраас мэдээлэлтэй, оролцоотой иргэдийг бий болгоход идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой. Тэрхүү үүргээ ч үнэнч шударгаар хариуцлагатай биелүүлэхийг өнөөгийн олон ургалч байр суурьтай ардчилсан иргэд шаардаж басхүү шүүмжлэлт байр сууринаас хандаж засч сайжруулахын төлөө үзэл бодлоо уралдуулж дуу хоолойгоо ч хүргэж байна. Энэ бол улс төрийн намууд нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнуудын хоорондын уялдаа холбоог хангах зохион байгуулалтын хариуцлагатай шударга, ил тод механизмыг бүрдүүлж, улс төрийн мөрийн хөтөлбөртөө ч түүнийг эрэмбэлэх нийгмийн болоод иргэдийн практик шаардаж байна.

Улс төрийн намууд ардчиллыг бэхжүүлэхэд дараах гурван чухал үүргийг гүйцэтгэж ардчиллын хөгжилд хувь нэмэр оруулах учиртай. Нэгд, иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх үндсэн эрхээ хэрэгжүүлэхэд тэдэнтэй хамтран ажиллах, үйл ажиллагааг зохицуулахыг ямагт дэмждэг байх. Хоёрт, төрийн албаны тогтвортой байдлыг хангах замаар парламент болон засгийн газрын түвшин дэх институц хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, үр дүнтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Гуравт, сонгогчдод шударга өрсөлдөөнт сонголт хийх боломжтой улс төрийн мөрийн хөтөлбөрийг боловсруулж сонгуульд

нэр дэвшүүлэх, дэмжих, төрд хамтын хариуцлага хүлээх замаар иргэдийн байгууллагыг албан тушаалтантай холбох гүүр болох үүргийг шударга хариуцлагатайгаар гүйцэтгэх ёстой. Ялангуяа парламентын засаглалтай улс орнуудад улс төрийн намууд, тэдгээрийн удирдагчид – парламентад суудалтай болон суудалгүй намуудтай эвсэл байгуулах замаар хоорондоо эвсэх, үгсэн хуйвалдахаас зайлсхийх нь ардчиллыг зохих ёсоор дэмжихэд улс төрийн намуудын хүлээх үүрэг учраас тэрхүү үүргээсээ няцах, ухрах эрхгүйгээр тууштай байх явдал чухал сорилт болж байна. Чингэхийн тулд улс төрийн намууд дараах гурван чухал шалгуурыг давах ёстойг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй санагдана.

Орчин үеийн ардчилсан орнуудад улс төрийн намуудын удирдлага зохион байгуулалт, намын дотоод үйл ажиллагааг гурван үндсэн хэмжүүрээр хэмжихэд харилцан адилгүй байр суурь ажиглагдах боломжтойг эл харцуулсан судалгаанд хамрагдсан улс орнуудын үндсэн хуульд тусгасан улс төрийн намын талаарх зохицуулалт чиглэгдэхийн сацуу дараах холбоос бүхий шалгуураар авч үзнэ:



Энэ шалгуурын төгсгөлд намууд ард түмний саналын төлөөх өрсөлдөн тэмцэхийн тулд улстөрчид багаар болон өөрийн албан ёсны зохион байгуулалттай дэмжигчдийн бүлэглэл үүсгэхийг хичээдэг. Магадгүй энэ нь шийдвэр гаргах төвшинд өөрсдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал хэдий ч эл хандлага хэтэрвэл дэмжигчид нь дургүйцэж өөр намыг дэмжихэд хүргэж болзошгүй.

Ардчилал бол олон намын чөлөөт, шударга өрсөлдөөнөөс хамаардаг ч гэлээ, аливаа өрсөлдөөн нь улс төрийн намуудын дотоод зохион байгуулалтаас ангид байна гэсэн ойлголттой холбоотойг улс төр судлаач Э.Е.Шаттшнайдер «Ардчилал нь намуудаас биш, намуудын дундаас бий болох» (Schattschneider E.E, 1942, хууд. 60) ёстой хэмээн онцолсон байдаг. Үүнээс үзэхүл, намууд нь сонгуульд оролцож ялалт байгуулснаар төрийг удирдах замаар өөрийн намын бодлогоо хэрэгжүүлэх, нөлөөллөө нэмэгдүүлэхэд хамтран ажилладаг иргэдийн нэгдэл гэж ойлгож болохоор байна. Улс төрийн намын амин сүнс болсон гишүүд шийдвэрээ зохих ёсоор гаргадаг, дарга, нэр дэвшигчид нь гишүүдийнхээ төлөөлөгчөөр ажиллах явцдаа сэтгэл дундуур байгаа бол тэдгээрийг чөлөөт, шударга өрсөлдөөнөөр солих чадвартай намын дотоод ардчилсан хандлага, эрүүл саруул сэтгэлгээтэй байхыг шаардаж буй хэрэг мөн.

Хоёр дахь шалгуур нь улс төрийн намуудын төртэй харилцах харилцаа тэдгээрийн байр суурьтай холбогдоно. Тодруулбал, улс төрийн намууд нь дотоод болон гадаад

үйл ажиллагаандаа аль болохоор бие даасан байдлыг хангасан байр сууринаас хандах нь тухайн намын үзэл баримтлалтай салшгүй холбоотой. Ардчиллын үйл явцад чухал ач холбогдолтой гол нөөц бол хуулиар олгогдсон үүргээ хариуцлагатайгаар биелүүлж, ард түмний өмнө өгсөн амлалтаа өөрийн төрийн эрх барих хугацаандаа шударгаар хэрэгжүүлж үр дүнтэй ажиллах ёстой. Энэ нь улс төрийн намуудыг хагас төрийн агентлаг (quasi agent) лугаа ажиллах, цаашлаад олон нийтийн өмнө хагас нийтийн байгууллага (quasi public agent)-ын зохион байгуулалттайгаар хүний суурь эрх, эрх чөлөөг хамгаалдаг, ардчилсан чиг баримжааг эрхэмлэн дээдэлж иргэний болон улсын төрийн эрхийн олон улсын пакт (22-р зүйл)-д заасан заалтыг ягштал дагаж мөрддөг (OSCE, 1990)¹ үзэл сурталаас ангид институцийн хэмжээнд ажиллахыг өнөөгийн нийгмийн харилцаа шаардаж байна. Чухам үүнийг намынаа үзэл баримтлалд шингээж, намын гишүүдийн ёс суртахуунд нэвчсэн төлөвшүүлэх явдал аль ч улс төрийн намын удирдлагын ухамсарлан ойлгож гүйцэлдүүлэх нийгэм-улс төрийн үүрэг болно.

Гурав дахь шалгуур нь улс төрийн намуудын өрсөлдөөнийг зохицуулахад чиглэгдсэн зохицуулалтын арга барил юм. Нэг ёсондоо талуудын өөрсдийнхөө ашиг сонирхлыг үр дүнтэй гэж бодсон ямар ч хэлбэрээр хэрэгжүүлэх эрхэд хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэдийн хувьд өөрсдийн итгэл үнэмшилээрээ сонгосон намаа дэмжих, дэмжихгүй байх эрхэд нь хөндлөнгөөс оролцохгүй байх явдал юм. Улс төрийн намууд өөрсдийн гишүүд, дэмжигчдээ ямар ч тохиолдолд намаа дэмжиж сонгуульд ялалт байгуулахад дэмжлэг үзүүлэх ёстой хэмээн албадан шаардах ёсгүй. Гагцхүү “чөлөөт, шударга” сонгуулийг явуулахыг эрмэлзэхийн хамт сонгуульд ялалт байгуулсан, байгуулаагүй намын гишүүд, дэмжигчдийнхээ эсрэг тэдний үзэл бодлоо илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхийг хязгаарлахгүйгээр эрх чөлөөт иргэний мөн чанар, үнэт зүйлсэд нь халдах учиргүй. Нэг үгээр бол шударга ёсыг дээдэлж “эрх тэгш тоглох тоглоомын талбар”-т хөндлөнгөөс оролцохоос ямагт зайлсхийж, тэдний орон зайг үлдээх ёстой.

Дээрх гурван шалгуураас улс төрийн намуудад дараах хоёр загвар нийтлэг үйлчилж байгааг харьцуулсан судалгаанаас харагдсан гэж болно. Тухайлбал, улс төрийн намуудын эрх зүйн зохицуулалт нь дээр дурдсан гурван шалгуурыг багтаасанаараа өргөн хүрээг хамарсан авч, нарийн төвөгтэй асуудал болох нь ажиглагдсан. Учир нь хувь хүн, бүлгүүдийн чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийн салшгүй илэрхийлэл нь улс төрийн намыг хамгаалах явдал юм. Гэхдээ сонгуулийн үйл явц, ардчилсан засаглал хийгээд улс төрийн намуудын амин чухал үүрэг бол үр дүнтэй, төлөөллийг хангасан шударга ардчилсан засаглалыг бэхжүүлэх нь ямар улс орны аль ч улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх чухал зохицуулалт байх нь нийтлэг шаардлага. Энэ нь тухайн улс оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй сонгуулийн тогтолцоо, бэхжиж хөгжсөн ардчиллын загвар нь улс төрийн намуудын

эрх зүйн болон бодит байдал зэргээс ихээхэн хамааралтай. Үүнийг дараах хоёр загвар илэрхийлэх боломжтой хэмээн үзэж байна.

Нэгд, улс төрийн намын бие даасан байдал (эвлэлдэн нэгдэх нь эрх чөлөөний үндсэн элемент) болон чөлөөт өрсөлдөөн зэрэг нь нэг талаас намын дотоод ардчилал, тэгш байдал, шударга өрсөлдөөнийг шаарддаг зарчмуудын хооронд зөрчилдөөн бий болгох нь гарцаагүй. Гэхдээ тэдгээрийн хоорондын тэнцвэрт байдал нь системээс хамаарч өөр өөр байж болох талтай. Улс төрийн намуудын үйл ажиллагаа, зохицуулалтын хэм хэмжээ нь дээрх гурван шалгуураар өөр өөрөөр хэмжигдэж болох ч гэлээ, зөрчилдсөн тохиолдолд хоорондоо ялгагдах боломжтой. Тухайлбал, либерал буюу чөлөөт зах зээлийн загвар нь ерөнхийдөө улс төрийн намуудын дотоод, гадаад үйл ажиллагаандаа эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг чухалчилдаг. Нэг ёсондоо эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний зарчмын дагуу улс төрийн намууд нь өөрийн дотоод зохион байгуулалт, намын дарга, нэр дэвшигчийг сонгохдоо чөлөөт өрсөлдөөн, олон ургалч үзлийг баримтлахыг чухалчлах ёстой гэсэн үг. Гадны нөлөөнд автах аас сэргийлж чадсан зохицуулалтуудыг намын дүрмээрээ хатуу хориглосон байх явдал юм.

Хоёрт, тэгш эрхт ардчилсан загвар нь юуны түрүүнд намын дотоод ардчилал, эрх тэгш байдал, шударга өрсөлдөөний зарчимд суурилдагаараа онцлогтой. Энэ загварын амин сүнс нь намуудад улс төрийн оролцоог хангасан, сонгууль, албан тушаалын хуваарилалтад шударга өрсөлдөөнийг чандлан баримталж ажиллах чиг үүргээсээ ухарч няцахгүй байх явдал юм. Учир нь улс төрийн намууд сонгуулийн үр дүнгээр ялалт байгуулсан тохиолдолд улс орны төрийн эрх барих чиг үүргийг гүйцэтгэдэг учраас дотоод зохион байгуулалтдаа тэгш байдлыг хангасан, ардчиллын суурь зарчмуудыг дээдэлж, шударга, хариуцлагатай байхыг шаардана. Энэ бол сонгуулийн өрсөлдөөнд тэгш боломжийг ямагт хангаж, нам доторх цөөнхийн бүлгийн үүрэг ролийг нэмэгдүүлэхэд эерэг байр сууринаас хандаж байхыг сануулж буй хэрэг.

Эдгээр загварууд нь тухайн улс төрийн намын үзэл баримтлалын тасралтгүй үргэлжлэх суурь зарчмаар аливаа туйлшралаас ангид байх идеал онолын нэг хэлбэр гэж болно. Угтаа нэг нь нөгөөгийнхөө дутууг нөхөх эсвэл тэдгээрийн хоорондох ижил төсөөтэй шинж чанаруудыг хооронд нь хослуулах хэлбэрээр бодит байдалд ашиглаж болох юм. Дурдсан хоёр загваруудын хооронд үүсэх зарим нэг хурцадмал байдлыг хэрхэн шийдвэрлэх, тэдгээрийн тэнцвэрт байдлыг хэрхэн хангах нь олон хүчин зүйлээс шалтгаалж болно. Гол хүчин зүйл нь улс төрийн нам гэж юу болох, түүний эрх зүйн статус, бие даасан байдал ямар байх ёстойг тодорхойлдог үндсэн хуулийн суурь зарчимд суурилсан де юре ба де факто ардчиллын ойлголт гэж болно. Сонгуулийн чөлөөт зах зээлийн либерал онол болох ардчиллын процедурын үзэл баримтлалд үндэслэсэн тогтолцоо нь улс төрийн намуудын дотоод бие даасан байдлыг хувь хүмүүсийн нэгдэл, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөтэй уялдуулан нийгэм дэх олон талт байдлыг тусгасан улс төрийн олон ургалч үзлийг бий болгоход

1 * According to the OSCE Copenhagen Document (1990), “in order to strengthen respect for, and enjoyment of, human rights and fundamental freedoms, to develop human contacts and to resolve issues of a related humanitarian character, the participating State agree on the following: (5.4) a between the State and political parties; in particular, political parties will not be merged with the State.”

чухал ач холбогдолтой. Энэ нь улс төрийн намуудын статус, дотоод зохион байгуулалт, эрх тэгш байдал, үндсэн хуулиар олгосон эрх, үүргийн хатуу зохицуулалтад нийцүүлсэн дүрэм журамтай байхыг шаардаж байна. Чингэхдээ тухайн нийгэмд давамгайлж буй нөхцөл байдлыг бодитоор мэдэрч ухаалаг, оновчтой бодлого, хөтөлбөр боловсруулах явдал улс төрийн намуудад тулгарч байна. Улс төрийн намууд хуучин уламжлалт байр сууринаас асуудалд хандах гэхээсээ илүүтэй ардчиллын суурь зарчмуудтай нийцсэн норматив хэм хэмжээг дагасан намын дүрэм, дотооддоо дагаж мөрдөх нарийн журмаар зохицуулалтыг авч хэрэгжүүлэхийг дээрх судалгаанд хамрагдсан зарим улсуудын үндсэн хуулийн заалтууд илэрхийлэгдэж байна.

Эцэст дүгнэхэд, улс төрийн намын тухай үндсэн хуулийн болон бусад хуулиудын үзэл баримтлал, үйл ажиллагаа нь тэдгээрийн үндэслэсэн загвараас ихээхэн хамааралтай байна. Намын дотоод ардчилал, эрх тэгш байдал, шударга өрсөлдөөн зэрэг үндсэн ойлголтуудад үндэслэсэн эвлэлдэн нэгдэх эрх, чөлөөт өрсөлдөөнд суурилсан хууль ёсны либерал загварын чиг хандлагаар тодорхойлогдож байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орон либерал загвараас улс төрийн намуудын зохицуулалтыг нэмэгдүүлэх, дотоод ардчилал, эрх тэгш байдал, илүү хүчтэй хариуцлагын механизмыг үндсэн хуулийн суурь зарчмууд, үзэл баримтлалтай уялдуулан намын дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг чухалчлах болсон. Энэ нь дэлхийн нийтэд улс төрийн намыг шинээр эмхлэн байгуулах, алдаа дутагдлаа засч сайжруулах, намын гишүүдийн ёс зүйтэй, хариуцлагатай, шударга байдлыг илүүд үзэх болсонтой холбоотой. байна. Улс төрийн намууд бол ардчилсан нийгэмд олон нийтийн оролцоог хангах хэрэгсэл болдогийн хувьд улс төрийн салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг хүмүүсийн нэгдэл юм. Энэ утгаараа янз бүрийн үнэт зүйлс, зарчмуудын зохистой тэнцвэрийг бий болгох замаар сайтар боловсруулсан, нарийн зохицуулалттай хууль тогтоомжийг гаргаж, түүнийгээ үндсэн хуулийн язгуур эрх ашигтай нийцүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь ямар ч тохиолдолд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний ерөнхий зарчимд саад тодгор учруулах ёсгүй хэмээн дүгнэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Eldersveld S. (1982). *Political Parties in American Society*. NY, USA.
- Katz, R. (1980). *Theory of Parties and Electoral Systems*. Baltimore.: Johns Hopkins University Press.
- Ковлер А.И. (1997). *Кризис демократии? (Демократия на рубеже*

XI века). М., РФ.

- Төгөлдөр Я, Одмаа Б, Мягмарсүрэн Д, ба бусад. (2021). *Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал. Санал зөвлөмж*. Уб., Монгол Улс: ННФ. ШУТИС.
- Richard Gunther and Larry Diamond. (2001). *Types and Functions of Parties. Political Parties and Democracy*. (L. D. Gunther, Ed.) Baltimore, USA: Johns Hopkins University Press.
- Richard S.Katz, Peter Mair. (1995). *Changing Modes of Party Organization and Party Democracy: The Emergence of the Cartel Party in Party Politics*.
- Болдбаатар Ж, Цанжид А. (1991). Улс төрийн намаас нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг. *"Бодрол, бясалгал" сэтгүүл*, № 8, 35-36.
- National Endowment for Democracy. (1999). *Улс төрийн намуудын санхүүжилт: Харьцуулсан судалгааны тойм. //National Democratic Institute for International Affairs (NDI). The Public Funding of Political Parties: An International Comparative Study*. Johannesburg, South Africa: Jet liner Visual Communications.
- Хатанболд О, Хишигдаваа А, Жаргал Ц, ба бусад. (2019). *Өнөөгийн Монголын улс төрийн соёл: төлөв байдал, чиг хандлага*. ОНСБС-ны тайлан. Философийн хүрээлэн., ШУА, Улс төр, эрх зүйн салбар. Уб: УТЭЗС, Философийн хүрээлэн, "Тод бичиг" ХХК.
- Цэрэннадмид А. (2001). *Хүн ёс, хүн төрх, зан суртахуун (Хүн ёсны онол, практикийн асуудал)*. Уб: ФСЭХ, ШУА. «Бэмби сан» ХХК.
- Долгорсүрэн М., Жаргал Ц. (2020). *Өнөөгийн улс төрийн соёлын үйл явц дахь эрх зүйн соёлын төлөв байдал*. ред. Хатанболд О., Баасансүрэн Д. *Монгол дахь улс төрийн соёл: уламжлал, орчин үе. Хамтын бүтээл* (хууд. 248). Уб, Монгол Улс: Философийн хүрээлэн., ШУА, «Соёмбо принтинг» ХХК.
- Энхсайхан М. (2020). *Социализмаас капитализм руу (Эдийн засгийн реформ)*. ред. Цэнддоо Б. Уб, Монгол Улс: «Нэпко паблишн» ХХК.
- Хатанболд О. (2019). *Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог. Эрдмийн бүтээлийн эмхэтгэл-I*. Уб: «Соёмбо принтинг» ХХК.
- Herbert Kitschelt, Steven I.Wilkinson. (2007). *Patrons Clients and Policies*. London, UK: Cambridge University Press.
- Энхболд Д., Хатанболд О. (2019). *Монголын улс төрийн соёлын төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлох нь. Экспертийн судалгаа*. Философийн хүрээлэн, ШУА, Улс төр, эрх зүйн салбар. Уб: "Тод бичиг" ХХК.
- АТГ. (2023). *Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа-2022. Судалгааны тайлангийн эмхэтгэл*. Уб, Монгол Улс: Авлигатай тэмцэх газар.
- Schattschneider E.E. (1942). *Party Government*. New York: Holt, Rinehart, and Winston.
- OSCE. (1990). (C. Document, Producer) Retrieved from <https://www.osce.org/odihr/elections/14304>.
- (n.d.).

Э.ГЭРЭЛТ-ОД:

ӨНГӨРСӨН 30 ЖИЛИЙГ МАРТЪЯ. НАМУУД ШИНЭ СОЁЛООР ТӨЛӨВШИЖ, АМЬД БАЙХ ҮЕ ЭХЭЛЛЭЭ



МУБИС-ийн багш, улс төр судлаач, доктор Э.Гэрэлт-Одыг урьж улс төрийн нам тойрсон өргөн сэдвээр ярилцлаа.

ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛЫН АМИН ЧУХАЛ ИНСТИТУЦ БОЛСОН НАМЫГ ЯАЖ ТӨЛӨВШҮҮЛЭХ ВЭ ГЭДЭГ АСУУДАЛ ДЭЛХИЙ ДАЯАР ЯРИГДСААР БАЙНА

-Монгол Улс олон намын тогтолцоонд шилжсэн 30 гаруй жилийн хугацаанд намын төлөвшил болоод хууль эрх зүйн зохицуулалт талаасаа ямар зам туулж өдийг хүрэв. Яг бодитоор бол дотоод ардчилалтай, ил тод нээлттэй, хариуцлагатай байх санаачилга одоо л хуульд тусгалаа олж байна шүү дээ?

-Манай улс 1990 оны тавдугаар сард анх удаа Улс төрийн намуудын тухай хуультай болсон. Одоогоос 35 жилийн өмнөх энэ хуулийг судлаачид шинэ тогтолцоо руу шилжих үед олон намын тогтолцоог хуульчилсан шилжилтийн үеийн хууль гэж нэрлэдэг. Тухайн үед олон шинэлэг зохицуулалт орсны дотор нам санхүүгээ өөрсдөө хариуцах заалт байсан. Мөн зохион байгуулалтын хувьд хуучин тогтолцоонд байсан аж ахуйн нэгж байгууллагуудад байсан намын бүтцийг халж, үйл ажиллагаа нь илүү нээлттэй байх заалтыг оруулж өгсөн. Гэхдээ өнгөрсөн түүхийг харахад намын хууль төлөвшлийг дэмжихүйц үр дүнтэй зохицуулалт байж чадаагүй. Учир нь намд санхүүжилт нэмэгдэхийн хэрээр хөрөнгө, орлого хаалттай болсон. Мөн намд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай болсон. Ингээд 1996 онд намыг УИХ дахь суудлаар төрөөс санхүүжилт олгох болсон. 2005 онд Улс төрийн намын тухай хуулийг дахин шинэчлэн батлахдаа намууд дотоод ардчилалтай, нээлттэй, хариуцлагатай, ил тод байх зарим заалтыг баталсан байдаг. Гэсэн ч өнөөдрийг хүртэл нам төлөвшихгүй байсан учраас юун дээр алдсан бэ гэдгээ цэгнэх хэрэгтэй болсон. Өөрөөр хэлбэл, өнөөдрийг хүртэл хөрөнгө, орлого нээлттэй байсангүй, хэрэгжүүлэх, хяналт тавих боломжгүй байжээ.

Улс төрийн нам бол ардчиллын хамгийн чухал амин сүнс, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэгч. Тиймээс дэлхий даяар намыг хэрхэн төлөвшүүлэх вэ гэдэг асуудал яригдсаар л байгаа. Найдвартай олсон нэг шийдэл нь төрөөс улс төрийн намд хэсэгчилсэн санхүүжилт олгох замаар хариуцлагатай, ил тод болгоё гэдэг хандлага 1960-аад оноос хойш хэрэгжиж байна. Өнөөдрийн байдлаар 120-иод улс ямар нэг байдлаар улс төрийн намуудыг төсвөөс санхүүжүүлэх загвар руу шилжихээд байгаа. Гэхдээ л яавал намуудыг ил тод, хариуцлагатай, дотоод ардчилалтай болгох вэ. Нам өөрөө олон нийтийн байгууллага хэр нь яагаад гишүүдээсээ санхүүжилт авах ёстой юм, яагаад төсвийн санхүүжилтийг их өгч болдоггүй юм зэргээр туршлага хуримтлагдсаар л байна. Харин Монгол Улсын хувьд энэ талын зохицуулалтууд хангалтгүй байж ирсэн. Тиймээс 2023 оны долоодугаар сард Улсын Их Хурал Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа Европын орнуудын сайн туршлага, зохицуулалтыг шингээж хэрэгжүүлэх механизмд нь онцгой анхаарсан. Тухайлбал, манайхан намд гишүүнээр элссэн л бол үүрэг хүлээхгүй явсаар 30 жил өнгөрлөө. Харин шинэчилсэн хуулиар намын гишүүн бол заавал татвараа төлөх үүрэг хүлээж байгаа. Энэ нь намын санхүүжилт авах хөшүүрэг болох тайлан тооцоонд нь тусгагддаг байх шинэ зохицуулалт оруулж ирсэн. Хариуцлага, хяналтыг сая л хуулиар нээж өглөө шүү дээ. Одоо бол нам тасралтгүй үйл ажиллагаа явуулах, амьд байх үүрэгтэй болж байна. Ингэж улс төрийн намын хөрөнгө орлого ил тод, нээлттэй, хариуцлагатай, дотоод ардчилалтай байх санаачилга хуульд тусгалаа олоход МАН, АН, ХҮН нам болоод бусад намууд улс төрийн манлайлал үзүүлсэн гэдгийг онцлох ёстой. Харин одоо дараагийн алхам болох хууль хэрэгжих нь дахиад л улс төрийн намуудын манлайллаас шалтгаална.

-Энэ шинэчлэлийг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачид ярьж хэлж шаардлаа. Намын санхүүжилт гэхээр л авлига, албан тушаал, эрх мэдэл яригддаг. Батлагдахгүй байх саад нь юун дээр гацаад байв?

-Хамгийн гол зүйл бол улс төрийн намуудын хүсэл зориг л байсан. Олон улсын хандлагуудыг хүлээн зөвшөөрөх, Улс төрийн намын хуулийг батлах хэрэгцээ шаардлагыг бүрэн ойлгох хүсэл зориг 2023 онд л бүрдлээ шүү дээ.

Улс төрийн намыг Үндсэн хуулийн институт гэдэг утгаараа Үндсэн хуульд заасан зохицуулалтуудаа амилуулах хэрэгцээ шаардлага байсан. Та бүхэн санаж байгаа байх 2019 онд Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа намтай холбоотой гурван заалтыг шинээр оруулж өгсөн. Нэгдүгээрт, нийтэд үйлчлэх бодлогын нам байх ёстой. Хоёрдугаарт, нам сонгогчдын нэгээс дээш хувийн дэмжлэгийг авах ёстой. Гуравдугаарт, намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж шинээр тусгасан. Үндсэн хуульд заасан эдгээр зохицуулалтуудыг амилуулахын тулд 2020 онд улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө намыг хуулийг шинэчлэхийг тусгаж байсан. Мөн 2021 онд Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчид Улс төрийн намын хуулийг шинэчлэхээ амласан байдаг. Тэр ч утгаараа улс төрийн намууд болон улстөрчдийн хүсэл зориг нэгдэж өнөөдрийн энэ өөрчлөлтийг хийлээ.

Таны асууснаар намд авлига, албан тушаал, эрх мэдэлтэй холбоотой асуудал байсан уу гэвэл, тийм. Үүнийг шийдэхгүй бол болохгүй, намуудыг санхүүжилтээ ил тод болго, хууль эрх зүйн орчноо сайжруул гэдэг зөвлөмжийг олон улсын байгууллагууд, тэр дундаа Авлигын төсөөллийн индексийг гаргадаг Трансперенси интернэшнл байгууллагаас байнга өгч байсан. Бусад олон улсын байгууллагуудаас ч бодлогын, нээлттэй нам болгох тал дээр байнга шахаж, дэмжиж ирсэн.

Мөн иргэдийн намд итгэх итгэл суларсаар байгааг бид мэдэж байгаа. Энэ мэт олон талын хүч дэмжлэг, шаардлагаар Улс төрийн намын хуулийг шинэчлэн баталсан.

НАМ ТӨРИЙН, ОЛОН НИЙТИЙН БАС БУСАД НАМУУДЫНХАА ХЯНАЛТАД ОРЖ ИРЭХ ЦОО ШИНЭ СОЁЛ БИЙ БОЛНО

-Ямар ч байсан хуультай боллоо. Өнгөн дээрээ намууд бүх зүйл нь нээлттэй боллоо л гээд байгаа. Гэтэл яг хууль хэрэгжих процесс буюу ил тод нээлттэй, дотоод ардчилалтай, хариуцлагатай болоход улс төрийн намууд бэлэн үү. Хуулийн амин сүнснийг бүрэн дүүрэн ойлгож хэрэгжүүлэх хүсэл зориг хэр байгаа гэж харж байна вэ?

-Өмнө нь улс төрийн намууд дотоод ардчилалтай байна гэж заасан боловч яаж, хянаж хэрэгжүүлэх хуулийн зохицуулалт байгаагүй. Улс төрийн намуудыг Улсын Дээд шүүх бүртгээд орхичихдог, хэнд ч тайлангаа өгдөггүй. Санхүүгийн үйл ажиллагаагаа олон нийтэд ил болгоно

гэсэн атлаа хэн ч хянаж, хариуцлага тооцдоггүй байлаа. Харин одоо улс төрийн намын үйл ажиллагааг санхүүгээр нь дамжуулж хянах, төрөөс хэсэгчилсэн дэмжлэг олгох, зогсоох гэх мэтчилэн бүх харилцааг Сонгуулийн ерөнхий хороонд өгсөн. Нам тухайн оны долоодугаар сард хагас жилийн үйл ажиллагааны санхүүгээ, дараа оны хоёрдугаар сард багтааж жилийн эцсийнхээ санхүүгээ тайлагнах үүрэг хүлээж байгаа. Хувийн болон төрийн санхүүжилтийн хамаарал болоод, гишүүдийн татвар, хандив үйл ажиллагаатай хэрхэн нийцэж буйг аудит хянана. Тайланг нам болон Сонгуулийн ерөнхий хороо нийтэд ил тод болгоно. Ийм механизмыг бий болгож өгснөөрөө нам нийтийн, төрийн бас бусад намуудынхаа хяналтад орж ирэх цоо шинэ соёл бий болно. Улс төрийн намуудын санхүүгийн үйл ажиллагаа алдаа дутагдалтай байх юм бол түүнийг нь хэн илрүүлэх, хэрхэн хариуцлага тооцохыг бүхэлд нь зохицуулсан. Хуулийг амжилттай хэрэгжүүлж чадах юм бол энэ бүх харилцаа бүрэн нээлттэй болох учиртай.

Монголд өнгөрсөн 30 жилд санхүүгийн үйл ажиллагаа нь ил тод бус байсан цорын ганц институт нь улс төрийн нам. Төрийн бус байгууллагуудаас эхлээд бусад бүх хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа ил тод, нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангаж ирсэн.

Тиймээс улс төрийн намуудын толгойг илж болохгүй. Намууд хүсвэл гэдэг өнцгөөр хандахгүй. Нэгэнт үүрэг хүлээж байгаа учраас өөрчлөгдөх ёстой. Хүндрэл үүснэ. Гэхдээ улс төрийн намууд олон нийтийн байгууллага гэдгээ ухамсарлаж бэлэн байх, хуулийг хэрэгжүүлэх цаг нь ирсэн. Ингэж байж улс төрийн нам гэдэг байгууллага амьд байж чадна.

Өнгөрсөн 30 жилийнх шиг зөвхөн сонгуулийн үед амилаад бусад үед чимээгүй болдог байж болохгүй. Сонгуулиас сонгуулийн хооронд олон нийт рүү ажилладаг, бодлого боловсруулдаг, иргэдийн улс төрийн боловсролыг дэмждэг, гишүүдээ идэвхжүүлэх ажлуудыг тогтмол хийж байх ёстой. Ингэж чадвал намд итгэх итгэл нэмэгдэнэ, сонгуулиар дэмжлэг авна, улмаар төрөөс дэмжлэг олгоно.

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ БУУРУУЛАХЫН ТУЛД ТӨРӨӨС САНХҮҮЖИЛТ ОЛГОЖ БАЙГААГ НАМУУД ОЙЛГОХ ЁСТОЙ

-Сонгогчдын нэг хувийн дэмжлэг авсан нам болгон санхүүжилт авах уу. Ер нь яг ямар шалгуур хангаж байж татвар төлөгчдийн мөнгөнөөс санхүүжилт авах вэ?

-Улс төрийн намын хуулиар сонгогчдын нэг хувийн дэмжлэгийг авснаар санхүүжилт авах эрх нь нээгдэж байгаа. Гэхдээ нэгээс дээш хувийн дэмжлэг авсан бүх намууд төсвөөс санхүүжилт авна гэсэн үг биш. Хувийн орлогыг төсвийн санхүүжилттэй уяж тэнцвэртэй байх зарчмыг баримтлах ёстой. ЕАБХАБ гишүүн орнуудын намын эрх зүйд баримтлах удирдамжид намууд төрийн санхүүжилт авахын тулд найман шалгуур хангаж байхыг шаарддаг. Нэгдүгээрт, намын хувийн хандивыг хязгаарлах ёстой буюу хязгааргүй хандив авч болохгүй. Хоёрдугаарт, хувийн болон улсын төсвийн санхүүжилт тэнцвэртэй байх ёстой гэж үздэг. Манай батлагдсан хуулиар намуудын хувийн орлого болон гишүүний татвар, сонгуульт гишүүний татвар, иргэний

хандив, аж ахуйн нэгжийн хандивын нийт дүнгээс төрийн санхүүжилт хоёр дахин их байж болно. Түүнээс өндөр байж болохгүй. Энэ юу гэсэн үг вэ гэхээр намууд гишүүдтэйгээ ажилла, олон нийтээс санхүүжилт авч байж төсвийн дэмжлэг нэмэгдэх юм. Амьгүй байгаад л байх юм бол төрийн дэмжлэг хязгаарлагдана гэсэн утгыг оруулж өгсөн. Мөн эрх бүхий нам төсвийн шууд бус санхүүжилт авах эрхтэй. Энэ нь намууд жилд нэг удаа хурал цуглаан зохион байгуулахад байраар хангах, олон нийтийн радио телевизээр улиралд 30 минутын мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх үнэгүй цаг олгохоор заасан. Энэ бол шинэ зохицуулалт.

Гурав дахь зарчим нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь шударга байх ёстой. Өмнө нь төсвөөс намд санхүүжилт олгохдоо давуу байдлыг дэмжсэн шинжтэй байсан шүү дээ. Сонгогчдын дэмжлэгээр авдаг байсан мөнгийг дөрвөн жилд нэг удаа суудлын мөнгийг жил бүр олгодог байсан бол одоо сонгогчдын санал, суудлын мөнгийг жил бүр олгохоор тусгасан нь намуудыг илүү амжилтаар нь шударга үнэлж байгаа дэвшил юм. Дөрөвдүгээрт, сонгуулийн зардлыг хязгаарлах ёстой гэдэг. Манайх сонгуулийн хуулиар зардлын дээд хязгаарыг тавьж өгдөг ч цаашид сонгуулийн өртөг зардлыг бууруулахын тулд төрөөс намуудад санхүүгийн дэмжлэг олгож байгаа гэдгийг намууд ойлгох ёстой. Сонгогчдын итгэл хүлээж, дэмжлэг авч байгаа намуудын зардлыг төр хуваалцаж байна шүү дээ. Энэ зарчмыг ойлгох ёстой.

Тавдугаарт, санхүүжилт ил тод байх ёстой. Сүүлийн арав гаруй жил байнга ярьсан ч яг одоо л хэрэгжүүлэх цаг ирлээ. Улс төрийн намын тухай шинэ хууль аль хэдийн 2024 оны эхнээс хэрэгжиж эхэлсэн. Намууд санхүүгийн тайлангаа цахим хуудастаа тавьчихсан байгаа. Сонгуулийн ерөнхий хороонд өгсөн тайлан нь 10 жилээр хадгалагдах үүрэг хүлээсэн. Өөрөөр хэлбэл, намуудын санхүүгийн тайлан олон нийтийн өмнө ил тод байх бүрэн боломж нээгдлээ гэсэн үг. Дараагийнх нь намууд санхүүжилттэй холбоотой хууль зөрчвөл төсвийн санхүүжилтийг царцаах, улмаар идэвхгүй хэлбэрт шилжүүлнэ.

Өнгөрсөн түүхээ харвал манай улс 1996 оноос хойш улс төрийн намд төрөөс санхүүжилт олгохдоо УИХ-ын нэг суудлыг сая төгрөгөөр бодож дэмжлэг олгож байсан бол 2002 оноос суудлын мөнгийг 10 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн. 2005 оны намын хуулийг УИХ-ын сонгуулиар сонгогчдын хүчинтэй санал тутамд 1000 төгрөгийг дөрвөн жилд нэг удаа, суудлын мөнгийг жил бүр олгодог болсон. Үүнээс өөрөөр төрөөс санхүүгийн дэмжлэг олгох нь хориотой байсан. Гэтэл улс төрийн намууд орон нутгийн хуралд сонгогдсоныхоо төлөө тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг авдаг болсон. Үүнийг намын хуулиар өмнө ч зөвшөөрөөгүй, одоо ч зөвшөөрөөгүй. Яагаад гэвэл нам бол нэгдмэл, амьд байгууллага байх ёстой. Орон нутгийн салбар нэгж нь тусдаа зорилготой, тусдаа санхүүгийн дэмжлэг авч үйл ажиллагаа явуулах боломжгүй. Учир нь нам орлогын нэг л данстай байх ёстой. Энэ нь санхүүгийн тайланг хагас болон бүтэн жилээр өгөхдөө нэгтгэж боловсруулахад илүү амар болгох зорилготой. Нөгөө талаас гишүүд, сонгуульт гишүүний татвар дээр нь бусад хандивуудыг төв байгууллага нь хянахад илүү хялбар болно. Мөн нам технологийн дэвшлийг ашиглаад салбар, нэгжүүдэд дэд данс хэрэглэснээр нам

орлого, зарцуулалтаа хянах хялбар болох юм.

-Нам алдаагаа засахгүй бол идэвхгүй болгох эрх нь сонгуулийн хороонд байна гэсэн үг үү. Тэгэхээр сонгуулийн байгууллага намуудын санхүүгийн тайланг хянаж хэдэн төгрөг өгөхийг шийдвэрлэнэ, идэвхгүй болгох санал өгнө гээд ихээхэн эрх мэдэлтэй болж хувирав уу ?

-Сонгуулийн ерөнхий хороо Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээж байгаа. Намууд хуулийн шаардлага хангахгүй, хуульд заасан үндэслэл бүрдсэн бол Дээд шүүхэд намыг идэвхгүй болгох албан бичиг илгээх эрхтэй. Сонгуулийн байгууллагын саналыг үндэслэж Дээд шүүх тухайн намыг идэвхгүй болгох үүрэг хүлээнэ. Гэхдээ энэ бол намыг идэвхгүй болгох гурван заалтын зөвхөн нэг нь гэдгийг ойлгох хэрэгтэй. Санхүүтэй холбоотойгоос гадна хуульд заасан хугацаанд хурлаа хуралдуулаагүй, УИХ-ын сонгуульд хоёр удаа оролцоогүй бол намыг идэвхгүй болгох үндэслэл болдог.

Хуулийн хэрэгжилтийг хангахад Үндэсний аудит, Сангийн яам, Жендэрийн үндэсний хороо гээд олон байгууллагын оролцоо бий. Тэдний нэг нь л сонгуулийн байгууллага гэсэн үг.

НАМУУД ХУВИЙН САНХҮҮЖИЛТЭЭ ЦУГЛУУЛААГҮЙ БАЙЖ ТӨРӨӨС 100 ХУВЬ АВНА ГЭЖ ОРИЛЖ БОЛОХГҮЙ

-Та улс төрийн намын санхүүжилтийг нэлээн өргөн хүрээнд, гүн гүнзгий судалж, өнөөгийн биеллээ олоод буй ил тод байх санаачилгын төлөө эцсийг нь хүртэл явсны хувьд шинэ зохицуулалт намуудын орлогыг хумьж, хохиролтой байна уу. Эсвэл төрийн санхүүжилтийг жил бүр олгосноор намуудын данс илүү зузаарах уу гэдэг харьцааг хэрхэн дүгнэж байна вэ?

-Намуудын санхүүгийн тайлан тооцоо ил болно. Үүнийг судлах ёстой. харамсалтай нь бидэнд намын санхүүжилттэй холбоотой өмнөх 30 гаруй жилийн албан ёсны мэдээлэл огт үүсээгүй. Нам хэдэн төгрөгийн хөрөнгөтэй, хэдэн гишүүнээсээ татвар авдаг, хэр хэмжээний үнэлгээтэй үл хөдлөх хөрөнгөтэй, хаанаас ямар хандив авч хэдэн төгрөг эргэлдүүлж улс төрийн үйл ажиллагаа явуулж байсныг огт мэдэхгүй. Харин багцаа төсөөлөл байсан нь өнгөрсөн хугацаанд улсын төсвөөс хуулийн хүрээнд олгож байсан дэмжлэг. Тэр нь суудлын мөнгийг 1996-2002 онуудад 1 саяар, 2003 оноос 10 сая төгрөгөөр, мөн 2005-2023 он хүртэл УИХ-ын ээлжит сонгуулийн дараа хүчинтэй санал тутамдаа нэг саналыг 1000 төгрөгөөр тооцож нэг удаа дэмжлэг авсан. Гэтэл тэр нь нийт санхүүжилтийнхээ хэдэн хувь гэдгийг мэдэх боломжгүй байсан. Одоо бол бүх зүйл шилэн болж байна. Жишээлбэл, төсвийн дэмжлэг тэнцвэртэй байхын тулд дөрвөн төрлийн орлогоос нь хоёр дахин их байна. Түүнээс хэтэрч болохгүй гэж заасан нь харьцангуй боломжийн зохицуулалт. Герман улс хандиваар олсон орлогынх нь нэг евро тутамд 46 цент-ийг улсын төсвийн дэмжлэг олгодог. Өөрөөр хэлбэл, хувийн орлогынх нь тал хувьд нь л төрөөс дэмжлэг гэсэн үг. Манайх бол хоёр дахин гэж заасан нь бусад оронтой харьцуулахад харьцангуй сайн бодлого. Энд нэг зүйлийг хэлэхэд, улс төрийн намууд орон нутагт

сонгогдсоныхоо төлөө хэдэн төгрөгийн санхүүжилт авдаг байсан талаарх тайлан мэдээ байхгүй учраас шинээр олгох санхүүжилт, хуучин намуудын авч байсан санхүүжилтийг харьцуулах боломжгүй байгаа нь шууд дүгнэлт хийхэд учир дутагдалтай. Шинэ хуулиар улс төрийн намууд долоон төрбум орчим төгрөгийн дэмжлэгийг авах юм билээ.

-Дээд шүүхэд 37 нам бүртгэлтэй байгаагаас долоон нам эвсэл төсвийн санхүүжилт авах эрх үүслээ гэдэг мэдээллийг сонгуулийн хороо өгсөн. Хэдийгээр төсвийн дэмжлэг авах эрх нь үүссэн ч тайлан тооцооноос болоод санхүүжилт хасагдах эрсдэл бий юу?

-Бүх нам тайлангаа өгсөн байх ёстой. Харин эхний ээлжид сонгуулийн үр дүнгээр нэгээс дээш хувийн дэмжлэг авсан намууд санхүүжилт авах эрх үүсэж байгаа. Энэ жилийн хувьд төрийн санхүүжилт авах эрх үүссэн долоон намын тайланг хянаад хуульд заасан дөрвөн үндэслэлээр орлогоо хэрхэн бүрдүүлсэнтэй нь уялдуулна.

Түүнээс долоон нам долуулаа санхүүжилт авна гэсэн үг ч биш. Хэрэв гишүүд, сонгуульт гишүүнээс татвар аваагүй, иргэн, аж ахуйн нэгжээс хуулийн хүрээнд хандив цуглуулаагүй бол хэдийгээр төрийн санхүүжилт авах эрх нээгдсэн ч дэмжлэг авч чадахгүй болох эрсдэл бий. Дээр хэлсэнчлэн намын өөрийнх нь санхүүжилт болон төсвийн дэмжлэг тэнцвэртэй байх ёстой. Гэтэл хувийн санхүүжилтээ цуглуулаагүй мөртөө төрийн дэмжлэгийг 100 хувь авна гэж шаардаад байж болохгүй.

Улс төрийн намууд төрөөс мөнгө авах ёстой гэж бодож байж магадгүй. Гэхдээ хуульд олон улсын стандартад нийцсэн шалгуур шаардлага байгааг ойлгох хэрэгтэй.

СОНГУУЛИЙН ЗАРДАЛ ӨСӨӨД БАЙГАА УЧРААС НАМЫГ ХАНДИВЛАГЧДЫН ХАМААРАЛД ОРОХ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХЫН ТУЛД ТӨРӨӨС ЗАРДЛЫГ ХУВААЛЦАЖ БАЙГАА. ОРОНД НЬ ИЛ ТОД БАЙХЫГ ШААРДАНА

-Улс төрийн намууд, улстөрчид бизнесийн байгууллагаас маш их санхүүжилт авч байна. Нэг компаниас бараг бүгд шахуу хандив авч байгаа нь хууль журам батлахдаа нөлөөнд өртөх вий гэсэн болгоомжлол төрүүлдэг. Үүнийг ер нь хэрхэн шийдвэрлэх ёстой вэ?

-Хандивын асуудал Улс төрийн намын болон Сонгуулийн тухай гээд хоёр хуулиар тусад нь зохицуулагдаж байгаа. Улс төрийн намд, сонгуулийн үеийн кампанит ажлын үеэр аж ахуйн нэгжээс хандивыг хориглосон хуулийн заалт байхгүй. Харин хандивын дээд хязгаарыг тавьж өгсөн зохицуулалт бий. Тэгэхээр бүгд авах эрхтэй гэсэн үг. Яг үнэндээ авсныг нь буруутгаж болохгүй. Харин илүү нээлттэй болсон учраас харах, хянах боломж бүрдэж байгаа. Цаашид яах вэ гэдгээ ярих ёстой. Зарим улс намд аж ахуйн нэгж хандив өгөхийг хориглох хэрэгтэй гэж үздэг бол сонгуулийн болон намын хуулиа нэгтгэж санхүүгийн үйл ажиллагаа нь нэгдсэн хуулиар зохицуулдаг ч орнууд бий. Монгол Улс яах вэ гэдгээ бодох хэрэгтэй.

Ер нь төрөөс санхүүгийн дэмжлэг өгөөд байгаагийн цаад шалтгаан нь улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгох зорилготой шүү дээ. Эхнээсээ үр дүнгээ өгч байна. Гэхдээ аж ахуйн нэгжийн хандивыг хориглох уу гэдгийг ч ярих ёстой. Одоохондоо хориглоогүй байгаа ч судлаачийнхаа хувьд хардаг өнцөг бол улс төрийн зардлыг хэрхэн хямдруулахаа бодохоос аргагүй. Сонгууль маш өндөр зардлаар явж байна. Тэр битгий хэл сонгуулийн үеэр зарцуулах зардлын дээд хэмжээг хэтэрхий өндрөөр тогтоож байна. Инфляцаас эхлээд сонгуулийн тогтолцоог бүсчилсэн нь үүнд шууд нөлөөлж байна шүү дээ. Тойрог томсож, олон хүн өрсөлдөхийн хэрээр сонгуулийг хэрхэн шударга болгох вэ гэдгийг бодох шаардлагатай. Сонгуулийн зардал буурах л юм бол өрсөлдөөнийг шударга болгох боломж бүрдэнэ. Харин эсрэгээрээ зардал нэмэгдээд байх юм бол тэгш бус өрсөлдөөн тэлсээр л байна.

Тиймээс сонгуулийн зардлыг бууруулах, цаашид улс төрийн нам яавал бага зардлаар ажиллаж болох вэ гэдгийг байнга харах ёстой. Дараагийн асуудал нь улс төрийн намуудад төрөөс санхүүжилт олгохдоо хэр зохистой хэмжээнд дэмжиж байна вэ гэдгээ дахиад бодох шаардлагатай.

Бидний өнөөгийн сонгосон парламентын систем улс төрийн намгүйгээр цааш явах боломжгүй. Парламентын тогтолцоо нам гэдэг институцээр дамжиж хэрэгждэг. Тэгэхээр намд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд ил тод байдлыг хангах ёстой. Намыг ил тод, дотоод ардчилалтай, хариуцлагатай болгохын тулд төрөөс санхүүгийн дэмжлэг олгох учиртай. Хүмүүс яагаад намд татвар төлөгчийн мөнгийг өгөх ёстой гэж бухимддаг юм. Тэртээ тэргүй улс төрийн намгүйгээр цааш явах боломжгүй системтэй учраас иргэдийн итгэлийг илүү нэмэгдүүлэхийн тулд дэмжиж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй. Сонгуулийн зардал өсөөд байгаа учраас намыг хандивлагчдын хамааралд орох эрсдэлийг бууруулахын тулд төрөөс зардлыг хуваалцаж байгаа юм. Оронд нь ил тод байхыг шаардаж буй юм.

ХУУЛЬД ОРСОН ЦОО ШИНЭ ЗОХИЦУУЛАЛТ БОЛ НАМ ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ҮҮРЭГТЭЙ ГЭЖ ЗААСАН

-Намууд сонгогчдын боловсролд анхаарахыг хуулиар үүрэгжүүлж өгсөн. Санхүүжилтийнхээ тодорхой хувийг намын гишүүдийг идэвхжүүлэх, сонгогчдод боловсрол олгоход зарцуулах хөшүүргийг хэрхэн хэрэгжүүлэх вэ. Эргээд бас тайлагнах үүрэг хүлээж байгаа шүү дээ?

-Улс төрийн намын хуульд орсон цоо шинэ зохицуулалт бол нам иргэдийн улс төрийн боловсрол, идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих үүрэгтэй гэж заасан. Төсвөөс авч буй санхүүжилтийнхээ 15-аас доошгүй хувийг зарцуулах ёстой. Үүнийг олон улсад зорилтод санхүүжилт гэж нэрлэдэг л дээ.

Мөн төрөөс олгож буй санхүүгийн дэмжлэгээс эмэгтэйчүүд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмадуудынхаа оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зардлынхаа 20-оос доошгүй хувийг, судалгаа шинжилгээндээ 15-аас доошгүй хувийг зарцуулаарай гэж заасан. Ингэхээр хамгийн

багадаа төрөөс авч буй санхүүжилтийнхээ 50-аас доошгүй хувийг олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулах ёстой болж байна. Энэ бол татвар төлөгчдийн хөрөнгөөр иргэдийн улс төрийн намд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, намын дотоод ардчиллыг дэмжих хамгийн том хөшүүрэг болно гэж харж байгаа.

Ер нь намуудыг дотоод ардчилалтай бай гээд орхиж болдоггүй юм байна. 2005 оны Улс төрийн намын тухай хуульд нам дотоод ардчилалтай байна гээд заачихсан. Харин яаж хянах, хэрэгжүүлэх чиглэлийн ямар ч механизм байгаагүй. Одоо бол улс төрийн намууд иргэд рүү, гишүүд рүү ажиллана. Тэр бүхэн нь ил тод байна. Дээр нь шийдвэр гаргах бүтцийн бүх түвшиндээ хүйсийн тэнцвэрт оролцоог нэмэгдүүлэх ёстой. Түүнд нь тулгуурлаж санхүүжилт олгож байгаа. Намын дотоод үйл ажиллагаа ардчилсан, нээлттэй, хурлын протокол, бүтцийн байгууллагуудынхаа бүрэлдэхүүнийг сонгуулийн хороонд өгдөг байх ёстой гээд бүгдийг тодорхой заачихсан.

Үндсэндээ нам гэдэг байгууллагыг зөнд нь орхиж, хаяж болохгүй институт учраас олон нийтийн өмнө ил болгоод байгаа юм. Учир нь бидний өмнөөс эрх мэдэл эдэлж, баялгийг хуваарилдаг онцгой институт гэдгийг мартаж болохгүй.

-Намын бүх санхүү мөнгө, үл хөдлөх хөрөнгө ил тод болох нь. Гэтэл нөгөө талд намд гишүүнээр элссэн иргэн болгон заавал татвараа төлж байж эргээд нам нь төрөөс дэмжлэг авна гэж ойлгох нь зөв үү. Намд элссэн иргэн илүү хариуцлагатай болохоос гадна гишүүд дэмжигчдийнхээ тоог зохиомлоор хэлдэг байдал цэгцрэх үү?

-Нам гэдэг бол эвлэлдэн нэгдэж улс төрийн хүсэл зорилгоо биежүүлэх зорилготой иргэдийн нэгдэл. Та хэний ч шахалтгүйгээр сайн дураараа улс төрийн хүсэл зорилгоо биежүүлэхийн тулд эвлэлдэн нэгдсэн тул үүнийхээ төлөө шийдвэр гаргах түвшинд оролцох ёстой. Шийдвэр гаргах эрхээ эдлэхийн тулд татвараа төлөх үүрэгтэй гэдэг бол дотоод ардчиллын хөшүүрэг байхгүй юу. Гэтэл яг бодит байдал дээр намууд нэг л их олон мянган гишүүнтэй гэдэг тоо хэлээд байдаг. Гишүүдээсээ татвар уу авдаг уу гэхээр 10 хувь нь л өгдөг байх гэдэг. Зарим нам нь нэг ч татвар авдаггүй. Яахав, сонгуулийн үеэр хэрэг болно гэж хариулдаг. Энэ нь намын мөн чанарыг эвдээд байгаа юм. Нам бол гишүүдийнхээ оролцоонд тулгуурлах ёстой. Тиймээс шинэ хуулиар дэмжигч гишүүн, гишүүн, сонгуульт гишүүн гэдэг ойлголтыг оруулж ирсэн. Дэмжигч гишүүн татвар төлөхгүй, дэмждэг байж болно, намын үйл ажиллагаанд сайн дураараа оролцоно. Гишүүн бол заавал татвар төлж байж намын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Өөрөөр хэлбэл, намын гишүүдийн эрхийг хуулиар хамгаалж өгсөн. Өмнө нь тодорхой нэг амбицтай, улс төрийн сонирхолтой, карьер хөөе гэж байгаа хүмүүс өмнүүр нь ороод дураараа шийдвэр гаргадаг байсан байж магадгүй. Одоо бол нам гишүүдээ үйлчилнэ. Харин гишүүдийнхээ оролцоог хангах ёстойг нам, гишүүн хоёрт хоёуланд нь үүрэг болгосон нь дотоод ардчиллыг хангах маш том хөшүүрэг. Хэрэв гишүүний татвараа төлөхгүй бол оролцохыг хүсэхгүй байнаа л гэсэн үг. Тиймээс гишүүн биш дэмжигч рүү шилжүүлээ шүү гэдэг

л сонголт гарч ирнэ. Цаашид намын гишүүдийн тоо буурах байх, татвараа төлдөг гишүүд л үлдэнэ.

Ирээдүйд намын гишүүдийг хянах боломж бүрдэнэ. Гишүүний татварыг дүрмээрээ тодорхойлчихно. Түүгээр нь намын орлогыг бүрэн харж болно. Өмнө нь мөрдөж байснаар бол намын гишүүний 1000-1200 төгрөгийн татвараа цуглуулахад л хангалттай орлого цуглуулах бүрэн боломжтой. Гэтэл энэ хөшүүргийг хэрэглэхгүй явж ирсэн. Энэ бүхний эцсийн зорилго бол намыг амьд, дотоод ардчилалтай байлгах юм.

Шинэ хуулийн дагуу намуудын хөрөнгө орлого ил болно. Угаас Үндсэн хуульд намуудын хөрөнгө орлого олон нийтэд ил тод байх ёстой гэж заасан. Тэгэхээр Үндсэн хуулийн энэ заалт амилах боломж бүрдэж байна. Улс төрийн намууд хэдэн төгрөгийг ямар замаар олж эргэлдүүлж байгааг мэддэг болно гэсэн үг. Үүний тулд төрийн дэмжлэгийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж байгаа. Хуулиар улс төрийн намын сонгуулиар авсан хүчинтэй санал тутмыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувиар үржүүлж жил бүр олгоно. Энэ жил бол нэг дэмжлэгт 3300 төгрөгөөр бодож олгохоор болсон. Ирэх жил хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэж байгаа учраас дагаад өөрчлөгдөнө. Дээр нь авсан суудлаар нь буюу амжилтыг нь үнэлж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний санхүүжилт олгож байна. Дараагийнх нь сонгуульд квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч тутамд суудлын мөнгийг нэг удаа олгоно гэсэн хуулийн заалттай. Энэ бол маш чухал зохицуулалт. Улс төрийн нам олон нийтийн байгууллага байх ёстой. Нийгмийн төлөөллүүдийг хангадаг байх, түүнийгээ дэмжсэн бодлого хэрэгжүүлдэг байх ёстой гэдэг хөшүүрэг болж байна.

-Намуудын хувьд цоо шинэ боломж, сорилт гэж харж болохоор. Хуулийг хэрэгжүүлэхэд улс төрийн намуудыг сургах шаардлагатай юу. Намууд энэ өөрчлөлтөд бэлэн биш байх магадлалтай шүү дээ?

-Яг одоогоор бол намуудад сургалт хийх шаардлагатай гэж харахгүй байна. Сонгуулийн байгууллага хангалттай мэдээллийг өгсөн байгаа. Одоо бол тайланг цахим системээр авдаг болбол илүү хялбар байж болох юм. Мөн намууд энэ ондоо багтаад дүрэм, хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтаа хуульд нийцүүлж өөрчлөх ёстой. Ингээд 2026 оны нэгдүгээр сарын 1-нээс Улс төрийн намын тухай хууль бүрэн хэрэгжиж эхэлнэ.

Хуулиар намын хөтөлбөр гэж шинэ ойлголт орж ирсэн. Энэ нь нам бүр өөрийн үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд тулгуурлан үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилгыг тодорхойлсон бодлогын баримт бичигтэй байхыг шаардаж байгаа. Намуудад ялгаа алга, бодлого нь тодорхойгүй байна гэж бид ярьдаг байсан бол одоо үнэхээр өөр үзэл бодолтой иргэдийн нэгдэл бол урт хугацаандаа бодлого, үйл ажиллагааг нь тодорхой болгох, сонгуулийн хөтөлбөр нь энэ хөтөлбөртөө уялдаж гардаг бодлогын нам болгохыг шаардаж байгаа юм.

**"Сонгуулийн боловсрол клуб"-ийн
Удирдах зөвлөлийн гишүүн С.УАНГА**

"УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ" ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛИЙН ЦАХИМ ҮЗЭСГЭЛЭН

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДАЛ" цахим үзэсгэлэнг Сонгуулийн ерөнхий хороо, Тунгахуй өгөгдлийн урлан хамтран танилцуулж байна.

Улс төрийн нам нь олон нийтийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, сонгуульд өрсөлдөх, төрийн бодлогод оролцох зорилготой, улс орны нийтлэг эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг сайн дурын нэгдэл юм. Нам нь ардчилсан тогтолцооны зайлшгүй бүрэлдэхүүн болохын хувьд идэвхтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, дотоод ардчилалтай, ил тод, бодлогын институци байх шаардлагатай. Үүний нэг шалгуур нь намын зохион байгуулалт, үйл ажиллагаа, ялангуяа санхүүжилт ил тод, нээлттэй байх явдал.

Намуудын 2024 оны санхүүгийн тайлантай олон нийт анх удаа нээлттэй танилцах боломж бүрдэж, улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдалд томоохон ахиц гарч байна.

Өгөгдлийн дүрслэлийн цахим үзэсгэлэнгээр Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын 2024 оны санхүүгийн тайлангийн өгөгдөл болон Үндэсний аудитын газрын Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам,

эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангийн өгөгдлийг танилцуулж байна.


Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал олон улсад ямар түвшинд байна вэ?

Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал нь дэлхий дахинд ардчиллын чанарыг хэмжих нэгэн чухал шалгуур үзүүлэлт болсон. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-ийн улс төрийн санхүүжилтийн мэдээллийн санд дурдсанаар, дэлхийн 181 улсаас 143 улсад улс төрийн намууд санхүүгээ тогтмол тайлагнах хууль эрх зүйн зохицуулалттай. Үүнээс 116 улсад тайлагнасан мэдээллийг олон нийтэд нээлттэй байхаар зохицуулсан байдаг.

Монгол Улсад улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдал хэрхэн зохицуулагдсан бэ?

Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)-ийн 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр Сонгуулийн ерөнхий хороо нь улс төрийн намуудын санхүүгийн тайланд хяналт тавих эрхийг хэрэгжүүлэх болж, 2023 онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь намуудын санхүүгийн тайланг хянаж, дүгнэлт гаргах, нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэх болсон.

Сонгуулийн ерөнхий хороо нь жил бүрийн 5 дугаар сард багтаан өөрийн цахим хуудсанд намын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны товч тайланг нийтэлнэ. Мөн улс төрийн нам өөрийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны товч тайлан, гишүүн, хандивын мэдээлэл зэргийг ил тод, нээлттэй байлгаж, цахим хуудсандаа тухай бүр шинэчлэн нийтлэх үүрэгтэй.



УЛС ТӨРИЙН НАМУУД 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА БҮРЭН ТАЙЛАГНАСАН УУ?

Улсын дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн 37 намаас 28 нь Сонгуулийн ерөнхий хороонд 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлсэн бол 9 нам тайлан ирүүлээгүй байна. Тайлан ирүүлсэн намуудаас 13 нь тухайн хугацаанд санхүүгийн үйл ажиллагаа явуулаагүй хэмээн "Х" тайлан гаргасан буюу нийт 15 нам тайлант онд санхүүгийн үйл ажиллагаа явуулжээ.

Харин 37 намаас 11 нам өөрийн цахим хуудастай (Харилцаа холбооны зохицуулах хороо болон Сонгуулийн ерөнхий хороонд бүртгэлтэй) бөгөөд тайлан ирүүлсэн 28 намаас 7 нь цахим хуудсандаа санхүүгийн мэдээллээ нээлттэй байршуулсан байна.

Улс төрийн намын тухай хууль (2023)-д зааснаар хоёр жил дараалан санхүүгийн тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлээгүй бол тухайн намыг идэвхгүйд тооцох зохицуулалттай.

"УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИЛ ТОД БАЙДАЛ" өгөгдлийн дүрслэлийн үзэсгэлэн
"TRANSPARENCY OF POLITICAL PARTY FINANCING" data visualization exhibition

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ 2024 FINANCIAL REPORTING OF POLITICAL PARTIES 2024

Сонгуулийн ерөнхий хороонд санхүүгийн тайлан ирүүлсэн: **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН**

Submitted a financial report to the General Election Commission: **CONDUCTED FINANCIAL ACTIVITIES**

Сонгуулийн ерөнхий хороонд санхүүгийн тайлан ирүүлсэн: **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ, "Х" ТАЙЛАН ИРҮҮЛСЭН**

Submitted a financial report to the General Election Commission: **NO FINANCIAL ACTIVITIES WERE CONDUCTED, A "ZERO" FINANCIAL REPORT WAS SUBMITTED**

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЭГҮЙ
NO FINANCIAL REPORT WAS SUBMITTED TO THE GENERAL ELECTION COMMISSION

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Өгөгдлийн дүрслэлийг Тунгашуй өгөгдлийн урланд бүтээв.

Source: General Election Commission of Mongolia
Data visualization was created by Tungaahui Data Studio.

"УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ИЛ ТОД БАЙДАЛ" өгөгдлийн дүрслэлийн үзэсгэлэн
"TRANSPARENCY OF POLITICAL PARTY FINANCING" data visualization exhibition

УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮҮДИЙН ТОО 2024 NUMBER OF POLITICAL PARTY MEMBERS 2024



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Өгөгдлийн дүрслэлийг Тунгашуй өгөгдлийн урланд бүтээв.

Source: General Election Commission of Mongolia
Data visualization was created by Tungaahui Data Studio.




УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЦАР ХҮРЭЭ

Улс төрийн нам Сонгуулийн ерөнхий хороонд санхүүгийн тайлан ирүүлэхдээ үйл ажиллагааны товч тайланг хавсаргах ба санхүүгийн тайлан ирүүлсэн 28 намаас 2024 оны үйл ажиллагааны товч тайланг 23 нам ирүүлжээ. Тайланд дурдсанаар 2024 онд улс төрийн 22 нам нийт 610,450 гишүүнтэй байна.

Улс төрийн намуудын гишүүнчлэлийн бүтцийн онцлог нь хоёр намын давамгайл байдлаар илэрнэ. Монгол Ардын Нам ба Ардчилсан Нам хоёр нийт намын гишүүдийн 85 хувийг бүрдүүлж буй бол бусад 22 нам нийлээд 15 хувийг эзэлж байна. Иргэдийн улс төрийн идэвхтэй гишүүнчлэл цөөн намд төвлөрч буй нь бусад намуудын төлөвшил, үйл ажиллагааны идэвхтэй байдал сул байгаатай холбоотой байж болно. Иймд Улс төрийн намын тухай хуульд зааснаар нам нь дотоод ардчилалтай, улсын хэмжээний бодлого, хөтөлбөр дэшуулж идэвхтэй, нээлттэй үйл ажиллагаа явуулахыг шаарддаг.

▼ УЛС ТӨРИЙН НАМЫН ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

Улс төрийн намын хөрөнгөд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал/тооцоо, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, бусад хөрөнгийг хамааруулдаг.





УЛС ТӨРИЙН НАМЫН ХӨРӨНГИЙН БАЙДАЛ

Санхүүгийн тайлан ирүүлсэн 28 намын 2024 оны эцсээрх хөрөнгийн нийт дүн 34.2 тэрбум төгрөгт хүрчээ. Улс төрийн нам тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд орлого олохоос гадна тодорхой хөрөнгийн баталгаатай байх шаардлагатай.

Санхүүгийн нөөцгүйн улмаас тогтвортой үйл ажиллагаа явуулах, хүний нөөцийн бүрдүүлэлт хийх, бодлого боловсруулах, сонгуулийн кампанит ажил явуулахад хүндрэлтэй байдлыг бий болгож байдаг. Иймд Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу нам идэвхтэй, нээлттэй үйл ажиллагаа явуулах шаардлага бий болсон.

УЛС ТӨРИЙН НАМЫН ОРЛОГО ►

Санхүүгийн тайлан ирүүлсэн 28 намын 15 нь 2024 онд санхүүгийн үйл ажиллагаа явуулсан бөгөөд 2024 оны нийт орлого бүрдүүлэлт нь 16.5 тэрбум төгрөг (сонгуулийн хандив ороогүй) байсан.



УЛС ТӨРИЙН НАМЫН ОРЛОГЫН ЭХ ҮҮСЭВЭ

Улс төрийн намын орлого нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, гишүүний татвар, намд өгсөн хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого болон бусад орлогоос бүрдэж байна.

Тайлан ирүүлж, санхүүгийн үйл ажиллагаа явуулсан 15 намаас ердөө 6 нь орлогынхоо дор хаяж 30 хувийг гишүүний татвараас бүрдүүлсэн байна. Энэ нь ихэнх нам тогтвортой үйл ажиллагаа явуулж, гишүүнчлэлээ идэвхжүүлдэггүйг харуулж байна. Гурван нам огт гишүүний татвар аваагүй байна.

2024 ОНД ЯМАР УЛС ТӨРИЙН НАМ ХАМГИЙН ИХ ХАНДИВ ТӨВЛӨРҮҮЛСЭН БЭ?

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаа явуулсан 15 намын хандив, түүнтэй холбоотой бүртгэлээс үзэхэд 10 нам иргэн болон хуулийн этгээдээс нийт 1.6 тэрбум төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус хандив (сонгуулийн хандив ороогүй) цуглуулжээ. Хандивыг улс төрийн намд иргэн, эсвэл хуулийн этгээд өгөх боломжтой. 2024 онд улс төрийн намын бүрдүүлсэн хандивын дийлэнхийг буюу 66 хувийг иргэний хандив бүрдүүлсэн.

УЛС ТӨРИЙН НАМЫН ХАНДИВ 2024 POLITICAL PARTY DONATION 2024

Мянган төгрөг | In thousand MNT
* Сонгуулийн хандив ороогүй | * Election donations not included




Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Бөгдлийн дүрсгалийг Тунгашуй өгөгдлийн үрэлдэг бүтээв.

Source: General Election Commission of Mongolia
Data visualization was created by Tungashui Data Studio.

УЛС ТӨРИЙН НАМЫН ХАНДИВ 2024 POLITICAL PARTY DONATION 2024

Мянган төгрөг | In thousand MNT
* Сонгуулийн хандив ороогүй | * Election donations not included



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Бөгдлийн дүрсгалийг Тунгашуй өгөгдлийн үрэлдэг бүтээв.

Source: General Election Commission of Mongolia
Data visualization was created by Tungashui Data Studio.

НЭГ ХАНДИВЛАГЧИД НОГДОХ ДУНДАЖ ХАНДИВ ХЭДЭН ТӨГРӨГ БАЙСАН БЭ?

Улс төрийн намын нэг жилд нэг иргэнээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүүгүй (2024 оны байдлаар 7,920,000 төгрөгөөс илүүгүй), нэг хуулийн этгээдээс авах хандивын дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүүгүй (2024 оны байдлаар 33 сая төгрөгөөс илүүгүй) байх хуулийн зохицуулалттай.

2024 оны байдлаар намуудын нэг хандивлагчид ногдох иргэний хандивын дундаж хэмжээ хамгийн ихдээ 3.8 сая төгрөг бол хуулийн этгээдийн хандивын дундаж хэмжээ 12.0 сая төгрөг (сонгуулийн хандив ороогүй) байна.

Улс төрийн намуудад 2024 онд нийт 79 хуулийн этгээд, 852 иргэн хандив өгчээ.

УЛС ТӨРИЙН НАМЫН ЗАРДАЛ ►



Тайлант онд үйл ажиллагаа явуулж, санхүүгийн тайлан ирүүлсэн 15 нам нь үйл ажиллагааны зардалдаа нийт 17.7 тэрбум төгрөг зарцуулж (сонгуулийн зардал ороогүй) тайлагнасан.

▼ СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ БА ЗАРДАЛ

Сонгуулийн ерөнхий хороонд улс төрийн нам санхүүгийн тайлан, үйл ажиллагааны товч тайлангаатайлагнадаг бол Үндэсний аудитын газарт сонгуулийн зардлын тайлангаа танилцуулдаг.

2024 онд явагдсан Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуулийн санхүүжилт болон зардлын тайлангаас харвал:

Сонгуульд нийт 19 нам, 2 эвсэл оролцсоноос Үндэсний аудитын газарт зардлын тайлангаа 16 нам, 2 эвсэл ирүүлсэн.



19 нам, 2 эвслээс 927, бие дааж 42, нийт 969 иргэн нэр дэвшсэнээс Үндэсний аудитын газарт 820 нэр дэвшигч зардлын тайлан ирүүлснээс 681 нэр дэвшигчийн тайланд дансны гүйлгээ хийгдсэн.


Сонгуулийн нийт санхүүжилтийн дүн 106.5 тэрбум төгрөг байсан. Үүнээс нэр дэвшигчдийн бүрдүүлсэн нийт санхүүжилт 93.6 тэрбум төгрөг, нам, эвслийн бүрдүүлсэн нийт санхүүжилт 12.9 тэрбум төгрөг байв.

Сонгуулийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь иргэдийн

хандив буюу нийт санхүүжилтийн 58 хувийг бүрдүүлсэн. Хуулийн этгээдийн хандив ч мөн голлох эх үүсвэрийн нэг бөгөөд нийт санхүүжилтийн 21 хувийг бүрдүүлсэн.

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн өөрсдийн оруулсан хөрөнгө нийт санхүүжилтийн мөн 21 хувийг бүрдүүлжээ.

Зардлын хувьд нэр дэвшигчдийн сонгуулийн нийт зардал 93.6 тэрбум төгрөг, намуудын сонгуулийн нийт зардал 14.9 тэрбум төгрөг байсан. Зардлын дийлэнх (62%) нь сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдсан.





▲ СОНГУУЛИЙН МӨНГӨН ХАНДИВЫН УРСГАЛ

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар иргэн арван сая төгрөг хүртэл, хуулийн этгээд гучин сая төгрөг хүртэл мөнгөн хандив өгөх зохицуулалттай. Сонгуулийн хандив нь бүтцийн хувьд иргэний хандив давамгайлсан байх тохиромжтой буюу сонгууль, улс төрийн намын үйл ажиллагаа бизнесээс аль болох хамаарал бага байх нь зохимжтой гэж үздэг

▼ СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ БА ҮР ДҮН

Сонгуульд зарцуулсан мөнгө болон сонгуулийн ялалт хоорондоо хамааралтай юу? 2024 оны сонгуулиар УИХ-д авсан нэг суудалд дунджаар хэдэн төгрөгийн сонгуулийн зардал зарцуулагдсаныг та бүхэн энэхүү өгөгдлийн дүрслэлээс харж, өөрийн дүгнэлтээ хийнэ үү.



Дэлгэрэнгүйг эндээс
уншина уу.



УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЦАХИМ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙГ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БОЛОВСРУУЛЖ БАЙНА

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, хяналттай, хариуцлагатай болгох замаар намыг “бодлогын институт” болгон төлөвшүүлэх эрхзүйн орчныг бэхжүүлэх зорилготой бөгөөд улс төрийн соёлыг шинэ шатанд гаргах чухал алхам болсон.

Эрх зүйн шинэчлэлийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд улс төрийн нам мэдээллээ ил тод тайлагнах, холбогдох байгууллагууд хяналт тавих, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй өгөгдөл бий болгох, улмаар олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх цогц үйл ажиллагаа шаардлагатай. Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахын тулд манай улс Нээлттэй засгийн түншлэлийн “Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах” сорилтод Ази тивээс

анх удаа нэгдэн, улс төрийн намын мэдээллийн цахим систем нэвтрүүлэх амлалт аваад буй.

Сонгуулийн ерөнхий хороо “Улс төрийн намын санхүүжилтийн бүртгэл, хяналт, тайлагнал, ил тод байдлыг хангах цахим систем хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт боловсруулах” төсөл боловсруулсан нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хүний хөгжлийн төлөөх оролцооны арга замуудыг сайжруулах Оролцоо” төслийн сонгон шалгаруулалтад шалгарч, тус хөтөлбөрийн санхүүжилтээр системийн ажлын даалгаврыг боловсруулж байгаа юм. Ирэх оны 2 дугаар сар хүртэл хэрэгжих уг төслийн хүрээнд системийн ажлын төлөвлөлт, даалгавар боловсруулж байгаа ажлын хэсэг зорилго, үр дүн, үр нөлөөг дараах байдлаар тодорхойлж байна.



Улс төрийн намын санхүүжилт, тайлан бүртгэлийн системийг төлөвлөх төслийн баг



Улс төрийн намын санхүүжилт, тайлан бүртгэлийн системийн ажлын даалгаврыг оролцогч талуудаар хэлэлцүүлэв. 2025.09.16



УЛС ТӨРИЙН НАМЫН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЗОРИЛГО

- **Улс төрийн намын үйл ажиллагааны болон санхүүжилтийн тайлагнал, хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах:** Тайлан, хяналтын процессыг автоматжуулах, өгөгдлийг ашиглан тайланг шалгах, зөрчил дутагдлыг хурдан илрүүлэх боломжтой болгох.
- **Улс төрийн намын мэдээллийн төвлөрсөн сан үүсгэх, нээлттэй өгөгдөл бүрдүүлэх:** Улс төрийн намын үйл ажиллагаа, санхүүжилтын мэдээллийг нэг санд төвлөрүүлэх, бүрэн, чанартай нээлттэй өгөгдөл бий болгох.
- **Улс төрийн намын мэдээллийн ил тод байдлыг хангах:** Иргэд, судлаачид, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг хэрэглэгч талууд улс төрийн намын мэдээлэл, нээлттэй өгөгдөл хялбар хандах, ашиглах боломжийг бүрдүүлэх.
- **Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хангах:** Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын шаардлагыг системээр дамжуулан хангуулах, намыг "бодлогын институт" болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- **Олон улсын амлалт, стандарттай нийцүүлэх:** 2025 онд Нээлттэй засгийн түншлэлд амласан зорилтыг биелүүлэх, ил тод байдал, хариуцлагын стандартыг хангах.



ХҮРЭХ ҮР ДҮН

- **Улс төрийн намын өгөгдөл, мэдээллийн урсгал хялбарчлагдаж, төвлөрөх:** Сонгуулийн ерөнхий хороо улс төрийн намын мэдээллийг хялбараар хүлээн авах, нэгтгэх, шалгах, хяналт тавих,

намуудын тайлагналын процесс хялбаршиж, улс төрийн намын мэдээллийн нэгдсэн сан бий болно.

- **Ил тод байдал хангагдах:** Намын үйл ажиллагаа, санхүүжилтын мэдээлэл ил тод болж, стандартад нийцсэн нээлттэй өгөгдөл бүрдэнэ.
- **Олон нийтийн хяналт, оролцоо нэмэгдэх:** Иргэд, олон нийтийн намын үйл ажиллагаанд тавих хяналтыг нэмэгдүүлж, бодит мэдээлэлд суурилсан сонгуулийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.
- Олон улсын амлалт биелэгдэнэ.



ҮР НӨЛӨӨ

- Намын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага, хяналт сайжирна.
- **Олон нийтийн оролцоо, итгэл нэмэгдэнэ:** Нээлттэй өгөгдөл нь иргэдийн хяналт, оролцоог дэмжиж, улс төрийн тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.
- **Шийдвэр гаргалт илүү оновчтой болно:** Нээлттэй өгөгдөлд тулгуурлан нам, Сонгуулийн ерөнхий хороо, төрийн байгууллагууд өгөгдөлд суурилсан бодлого, шийдвэр гаргах боломж бүрдэнэ. Мөн иргэд өгөгдөлд суурилсан сонгуулийн шийдвэр гаргах боломж бүрдэнэ.
- **Нээлттэй өгөгдлийн соёл төлөвшинэ:** Улс төрийн намын мэдээллийг стандартад нийцсэн нээлттэй өгөгдөл болгосноор нээлттэй өгөгдлийг ашиглах соёл төлөвшихөд хувь нэмэр оруулна. Нээлттэй өгөгдөлд суурилсан судалгаа, шинжилгээний ажлууд нэмэгдэнэ.
- Олон улсын амлалт, стандарттай нийцсэн, нээлттэй засаглалын практик бий болно.

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ- ЧИГ ҮҮРГИЙН ТУХАЙ



Б.Сарантуяа

Эрх зүйч (LL.B.), Улс төр судлалын магистр (M.Sc.)
Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн
Судалгааны хэлтсийн судлаач



ХУРААНГУЙ

Ардчилсан улс орнуудын Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг уламжлалт ёсоор гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх гэсэн гурван хэсэгт (branch) хуваадаг бол зарим тохиолдолд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид бие даасан байгууллагуудын талаар тусгаж, тэдгээрийг хяналт, тэнцлийн тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, төрийн эрх мэдлийн дөрөв дэх салбар хэмээн хүлээн зөвшөөрдөг.¹ Ийм байгууллагууд нь сонгуулийн байгууллага, үндэсний аудитын байгууллага, Үндсэн хуулийн шүүх болон хүний эрхийн комисс зэрэг ардчиллын чанарыг бэхжүүлэхэд чиглэсэн институцийн бүтэц хэлбэрээр илэрч байна. Өөрөөр хэлбэл ардчилсан дэглэмийн үед ардчиллыг хамгаалах чиг үүргийг янз бүрийн институцэд хуваарилдаг.² Эдгээр институциуд нь зохицуулалт хийх болон хяналт тавих чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх бие даасан байгууллагууд хэлбэрээр хөгжиж ардчилсан засаглалын чанарыг сайжруулж шударга, зарчимч байдлыг хангаж, Үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэх зорилготой.³ Дээрх байгууллагууд гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа байгуулагдаж, бүрэлдэхүүний, төсвийн, зохион байгуулалтын хувьд бие даасан, хараат бусаар ажиллахыг ёстой бөгөөд бие даасан, хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь Үндсэн хуульд ардчиллын том сорилт хэмээн гадаад, дотоодын судалгааны бүтээлүүдэд хүлээн зөвшөөрч судалжээ.

Монгол Улсын хувьд ардчилалд шилжсэнээр зохион байгуулагдсан 9 удаагийн парламентын сонгууль, 8 удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийн зохион байгуулалт, эрх мэдлийг тайван замаар шилжүүлэхэд Сонгуулийн төв байгууллага⁴ \Сонгуулийн ерөнхий хороо\ ихээхэн чухал

үүрэгтэй ажиллаж ирсэн. Сонгуулийн төв байгууллага нь ардчилсан улс дахь сонгуулийг шударга, ил тод, хараат бусаар явуулах, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сонгогчдыг бүртгэхээс эхлээд сонгуулийн дүнг зарлах хүртэлх сонгуулийн үйл ажиллагааг хараат бусаар зохион байгуулах үүргийг хүлээж улс орныхоо ирээдүйг тодорхойлох боломжийг олгодог институц юм. Сонгуулийн төв байгууллагын чиг үүргийг бие даасан байдлыг судлах нь нэгдүгээрт, сонгуулийн шинэчлэлтэд нөлөөлөх нийтлэг чиг хандлага, шилдэг туршлагыг тодорхойлох үүднээс, хоёрдугаарт, ардчилсан засаглал дахь сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг тэр дундаа иргэний сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд хамгийн чухал үүрэгтэй байгууллагын загварын тухай ойлголт, онолыг таниулж улмаар манай улсын сонгуулийн төв байгууллагын хөгжлийг үнэлэн тодорхойлоход суурь судалгаа болох зорилготой болно. Тиймд энэхүү өгүүлэлээр Ардчилал Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн (цаашид, АСДҮОУХ гэх)-ийн боловсруулсан сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлын загвар, ойлголт, ангилал, давуу болон сул талыг танилцуулна.

ОРШИЛ

Сонгууль бол ардчилсан улс төрийн үйл явцын тулгын чулуу бөгөөд улс төрийн нам, нэр дэвшигчид сонгогчдын өмнө тэгш нөхцөлд төрийн албан тушаалд өрсөлдөх механизмын суурь болдог. Сонгууль найдвартай байхын тулд өрсөлдөөн шударга байх ёстой бөгөөд үйл явцыг шударгаар удирдан явуулах институц зайлшгүй шаардлагатай. Улс орнуудын хувьд хууль тогтоомждоо сонгуулийн төв байгууллага, сонгуулийн хороо, сонгуулийн зөвлөл, мужийн сонгуулийн хороо, сонгуулийн удирдлагын байгууллага гэх мэтээр тодорхойлон заасан⁵ байх ба ерөнхийдөө нэг чиг-үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг өөр өөрөөр нэрлэн хэвшсэн байна. Энэ нь Сонгуулийн төв байгууллага⁶ (National Election

1 Mark Tushnet, *The New Fourth Branch: Institutions for Protecting Constitutional Democracy*, 1st ed. (Oxford University Press, 2021), I.

2 Mark Tushnet, "Institutions Protecting Democracy: A Preliminary Inquiry," *Law & Ethics of Human Rights* 12, no. 2 (2018): 181–182.

3 Ibid.

4 Улс орнуудын хууль тогтоомжид сонгуулийн төв байгууллага, сонгуулийн хороо, сонгуулийн зөвлөл, мужийн сонгуулийн хороо, сонгуулийн удирдлагын байгууллага гэх мэтээр томъёолон хэрэглэдэг. Манай улсын хувьд 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиараа "3.1. Сонгуулийн төв байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо мөн" хэмээн тодорхойлон заасан тул энэхүү судалгааны ажилд "сонгуулийн төв байгууллага" хэмээх томъёоллоор хэрэглэсэн болно.

5 ACE, "Electoral Management", aceproject.org

6 Сонгуулийн удирдлагын байгууллага, сонгуулийн төв байгууллага гэх хоёр нийтлэг нэршил онолын судалгаанд ашиглагдаж буйгаас "Сонгуулийн төв байгууллага" хэмээх нэршлийг энэхүү судалгааны ажилд ашиглав.

Commission\National Election Body)⁷ буюу сонгуулийн үйл явцыг удирдах эрх бүхий байгууллага юм.

Сонгуулийн үйл явцыг удирдах гэдэгт нэр дэвшүүлэх, санал хураалт явуулах, санал хураалтыг тойрсон дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх замаар сонгуулийн хууль ёсны байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ажилладаг байгууллагыг ойлгоно.⁸ Иймд энэхүү өгүүлээр сонгуулийн байгууллагын тухай ойлголт, ангилал, бүтэц-чиг үүргийн тухай социологийн болон улс төрийн онолыг дэлгэрүүлэн судалж улмаар чиг үүргийн бие даасан байдлын (гурван загвар) тухай өгүүлнэ.

Шарль Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлдээ анхлан төрийн эрх мэдлийг хуваарилах сонгодог онолыг санал болгосон байдаг. Монтескьегийн онолоор “хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь тусдаа, тэнцвэртэй байдаг засгийн газарт улс төрийн эрх чөлөө хамгийн сайн хадгалагддаг. Түүнчлэн сайн боловсруулсан Үндсэн хууль нь улс төрийн эрх чөлөөг хадгалахад нэн чухал бөгөөд энэ нь хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлэх хүрээг тогтоодог”⁹ хэмээсэн. Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд тус тусад нь хуваарилж улмаар Үндсэн хуулийн боловсруулалт алдаа мадаггүй байх цагт Үндсэн хуулиас урган гарсан үндсэн хуульчилсан хуулийн (органик) байгууллагууд ардчиллыг бэхжүүлж, хамгаалах үүргээ биелүүлж чадна. Тухайлбал, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байж, уул эрх мэдлийг хянан шалгах (oversight)¹⁰ чиг үүрэгтэй бие даасан байгууллагууд нь Үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэхэд чухал¹¹ бөгөөд ийм байгууллагуудад Хүний эрхийн үндэсний байгууллага, Төрийн аудитын дээд байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Сонгуулийн төв байгууллага зэрэг орно.¹² Эдгээр бие даасан, хараат бус байгууллагуудын дотор ардчилсан улсын сонгуулийг чөлөөт, шударга зарчмаар явуулж төрийн эрх мэдлийг тайван замаар шилжүүлэх үүргийг “Сонгуулийн төв байгууллага (СЕХ)” хүлээдэг.

Сонгуулийн төв байгууллагын тухай зохицуулалт хууль тогтоомжид тусгалаа олж ардчилалд шилжсэн улс орнууд анхны сонгуулиа зохион байгуулж эхэлснээр энэ сэдэв судалгааны эргэлтэд орж судлаачид болон олон улсын байгууллагууд хэрхэн сонгуулийн төв байгууллагыг байгуулах, бүрэлдэхүүнийг хэрхэн сонгох, бие даасан, хараат бус байдлыг хэрхэн хэмжих зэрэгт анхаарч эхэлсэн. Дээрх сонгуулийн төв байгууллагын үүсэл, хөгжлөөс “сонгуулийн төв байгууллага бол шууд ардчиллын бусад хэрэгслийг удирдах үүрэгтэй байгууллага юм”¹³ хэмээх дүгнэлтэд хүрч байна. Иймд, сонгуулийн төв байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, зарчим нь дараах байдлаар тодорхойлогдож байна.

Үүнд:¹⁴

- a. Сонгуульд оролцох эрх бүхий иргэдийг тодорхойлох;
- b. Сонгуульд оролцогчдын тодорхойлолт, хүсэлтийг хүлээн авч баталгаажуулах;
- c. Санал хураалт явуулах;
- d. Санал тоолох;
- e. Дүн гарах;
- f. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх эсэхийг шийдэх;
- g. Сонгуулийн үйл явцад хяналт тавих;
- h. Улс төрийн намтай холбоотой хяналт хэрэгжүүлэх;
- i. Иргэдийн боловсролыг дэмжих зэрэг болно.

Эдгээр үүргээ хэрэгжүүлэхдээ сонгуулийн төв байгууллагын аль загварт хамаарч буйгаас үл хамааран дараах зарчмыг баримтлан ажиллах ёстой.¹⁵ Үүнд:

- **Бие даасан, хараат бус байдал:** Сонгуулийн төв байгууллагын хараат бус байдлын тухай хоёр ойлголт буй нь 1) бүтцийн хувьд засгийн газраас хараат бус байх, 2) шийдвэр гаргахдаа улс төр, намын нөлөөллөөс ангид байх тухай болно. Тус хоёр ойлголт хоорондоо уялдаа холбоотой бөгөөд тухайн улсад сонгуулийн төв байгууллагын бие даасан байдлыг зохицуулсан хууль зайлшгүй байх ёстой хэмээн үздэг.¹⁶ Бие даасан загварт харьяалагддаг улсад дээрх хоёр ойлголт шууд хангагдах боломжтой, харин засгийн газрын загвартай улсад бие даасан байдлын зарчим хангагдахад төвөгтэй.
- **Шударга байдал:** Сонгууль шударга явагдахад тухайн сонгуулийн төв байгууллага чухал үүрэгтэй оролцоно. Тухайлбал, сонгуулийн хорооны гишүүдийн ёс зүйтэй, шударга, зарчимч байдал нь сонгуулийн үйл ажиллагаа шударга явагдах зарчмыг хангах үндсэн нөхцөл болно.¹⁷
- **Ил тод байдал:** Сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаа болон санхүү нь ил тод байх ёстой.¹⁸ Энэ нь сонгууль шударга явагдах нөхцөлийг хангаж иргэдийн сонгуульд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ. Сонгуулийн төв байгууллагын аль загвартайгаас үл хамаарах сонгуулийн тухай хууль тогтоомжоор ил тод байдлыг хангах зохицуулалтыг (сонгуулийн ажиглалт, санал тоолох, нэгтгэн явцыг шууд дамжуулах, сонгуулийн дүнг зарлах, баталгаажуулахад ил тод мэдээлэл дамжуулах гэх мэт) хийсэн байх ёстой.
- **Үр ашигтай байдал:** Сонгуулийн төв байгууллага аль загварт хамаарч буйгаас үл хамаарч өөрт оногдсон төсөв, санхүү, хөрөнгийг үр ашигтайгаар зарцуулж сонгуулийн үйл ажиллагааны дээрх зарчмуудыг хангах ажиллах ёстой.¹⁹ Өөрөөр хэлбэл, үр ашигтай байдлаа нэмэгдүүлэхийн тулд орчин үеийн техник

7 ACE, “Electoral Management”, aceproject.org

8 Helen Catt, Electoral Management Design, 1st ed. (International IDEA, 2014).

9 Charles de Secondat, Baron de Montesquieu, The Spirit of Laws (Amherst, NY: Prometheus Books, 2002).

10 Mark Tushnet, The New Fourth Branch: Institutions for Protecting Constitutional Democracy, 1st ed. (Oxford University Press, 2021), I.

11 Ibid. I.

12 Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал магистрын диссертаци, 2023, УБ.

13 Transparency International, “Election Management Bodies and Their Composition,” (2013), transparency.org.

14 Ibid.

15 International IDEA, Electoral Management Design, revised ed. (Sweden: International IDEA, 2014).

16 Ibid.

17 Ibid.

18 Ibid.

19 Ibid.

технологийг нэвтрүүлэх, улмаар иргэдийн мэдэх, мэдээлэл эрэх, хайх эрхийг баталгаажуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, өөрийн нөөц төхөөрөмжүүдийн аюулгүй, баталгаатай ажиллагааг хангах замаар иргэдийн сонгуулийн байгууллага, сонгуульд итгэх итгэлийг хадгалах агуулга үүнд хамаарна.

- **Мэргэжлийн ур чадвар:** Сонгуулийн төв байгууллагын удирдлага, гишүүд, ажилчид мэргэжлийн ур чадвартай байх ёстой.²⁰ Үүнд, сонгуулийн төв байгууллага аль загварт хамаарахаас үл хамааран үндсэн эсвэл түр хугацаанд ажил үүрэг гүйцэтгэж буй бүх албан хаагчид хууль тогтоомжийн нэгдмэл ойлголттой, сайтар бэлтгэгдсэн, сургалтад хамрагдсан, ойлголтын зөрүүгүй байх ёстой. Тухайлбал, сонгуулийн төв байгууллагын хороонд гишүүнээр сонгогдож буй этгээд нь тус салбарын талаар өргөн мэдлэг, туршлагатай, хараат бус, мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай байх ёстой.²¹

Дээрх зарчмыг АСДҮОУХ болон Ардчиллын төлөөх Вестминстрийн сангийн судалгаанд сонгуулийн төв байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хэмжих хэмжигдэхүүн (шударга байдал, ил тод байдал, үр ашигтай менежмент, мэргэжлийн чадварлаг байдал) хэмээн үзэж ашигласан байдаг.

I. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Макс Вебер сонгуулийн төв байгууллагуудын талаарх ойлголт болон төрийн удирдлагын чанарын талаар удаан хугацааны туршид сонирхож, судалж ирсэн бөгөөд орчин үеийн төрийн хүнд суртлыг уламжлалт буюу харизматик засаглалын хэлбэрээс ялгаснаар сонгуулийн байгууллагын талаарх үзэл баримтлал, хөгжил эхэлсэн.²² Макс Веберийн үзэл баримтлалаар сонгуулийн байгууллагын талаар оновчтой зохицуулалт хийх шаардлага нь хэн нэгний тушаалыг дагах, ивээн тэтгэгчид найдахаа болихоос эхлэлтэй²³ бөгөөд төрийн байгууллагын бүтээмжийг сайжруулах талаарх үзлээс мөн үүдэлтэй. Дэлхийн II дайны дараа сонгуулийн байгууллага нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг инсититуц болж хөгжсөн бөгөөд сонгуулийн менежментийн байгууллагуудын онцгой төрөл (бие даасан институт) болсноор үзэл баримтлал, ойлголтыг судлах судалгаануудын эхлэл тавигджээ.

Түүхийн хувьд анх ардчилсан сонгуулийг зохион байгуулсан улс орнууд улс төрийн төвийг сахисан байдал, тэдгээрийг зохион байгуулсан төрийн байгууллагуудын үйл

ажиллагааны бие даасан байдлыг бараг анхаарч үздэггүй байсан. Үүнийг Роберт Даль "XX зуунд энэ хандлага нь өөрийн хязгаарын төгсгөлийг харуулж, өөрчлөлт явагдаж эхэлсэн"²⁴ хэмээсэн. Энэ нь Африк, Ази тив колоничлолоос ангижирч, дараа нь Латин Америк, Зүүн Европт ардчиллын давлагаа өрнөж, ардчилсан сонгууль явуулж буй орнуудын тоо аажмаар нэмэгдсэн холбоотой. Олон шинэ ардчилсан орнуудад улс төрийн олон ургалч үзэл, хүчирхэг иргэний нийгэм, бие даасан шүүх засаглал анхан шатандаа хөгжиж эхэлсэн. Энэ хүрээнд төрийн гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс тодорхой тусгаарлагдсан сонгуулийн үйл явцыг удирдах чиг үүрэгтэй бие даасан байгууллагуудыг зориудаар бий болгосон. Энэ нь онолын хувьд ардчилал нь иргэдийн оролцоотой, өрсөлдөх чадвартай институцуудыг бий болгоход анхаарлаа хандуулж байгаа үед Дали, Липсет (1966) нарын эрдэмтэд "сонгуулийн төв байгууллагууд нь ардчиллыг бий болгох чухал институциуд"²⁵ хэмээн үзэж тодорхойлсон. Тухайлбал, АНУ-д 1975 онд Холбооны сонгуулийн хороо байгуулагдсан, Австрали Улсад 1984 оны сүүлээр Сонгуулийн хороогоо бие даасан байгууллага болгон байгуулсан, энэ цаг үед Их Британи Улсад сонгуулийн ерөнхий эрх мэдлийг улс төрийн тогтолцоонд нэвтрүүлэх нь зүйтэй эсэх талаар хэлэлцүүлэг өрнөж байсан. Ийнхүү шинэ болон хуучин ардчилсан орнуудын аль алинд нь чиг үүргийн бие даасан байдлын хувьд бие даасан загвар бүхий сонгуулийн байгууллагыг дэмжсэн үндэслэлүүд гарсан нь ардчиллын ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэхэд энэхүү институцийн бүтэц-чиг үүрэг чухал болохыг онолын болон практикт мэдэрсэн явдал байжээ. Үүнийг Ларри Даймонд "Ардчиллын гурав дахь давлагаа юу? (Is the Third Wave Over?)" бүтээлдээ дараах байдлаар тодорхойлон улс орнууд ардчилалд шилжиж улмаар сонгуулийг төв байгууллагуудын үүсэл хөгжил эхэлсэн хэмээн үзэх боломжтой байна.²⁶

"1974 онд дэлхий дээр ердөө 39 ардчилсан орон байсан. Харин 1996 оны эхээр сонгуулийн ардчиллын шаардлагыг хангасан улс орнуудын тоо 117 болж нэмэгдсэн. Ардчиллын гурав дахь давлагааны хамгийн гайхалтай үзүүлэлт бол дэлхий дээр олон намын өрсөлдөөн байхгүй улс орнууд багахан хувь (20 гаруй хувь) л үлдэж байгаа явдал юм". (Diamond 1996)

Үүнээс сонгуулийн байгууллагуудын үүсэл, хөгжил, хувьсал, үзэл баримтлал нь ардчиллын үйл явцаас салгах аргагүй юм. Ардчилалд шилжих шилжилтүүд бүх тивийг хамарч, олон намын тогтолцоо бүрэлдэхэд улс төрийн оролцогчдын тэгш өрсөлдөөнийг хангах үүднээс сонгуулийн төв байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ойлголт, хамрах хүрээ дэлгэрсэн. 1960 оны сүүлээс эхлэн дэлхий даяарх ардчиллын шилжилт нь тухайлбал, ардчиллын орчин үеийн эхлэл (Хантингтоны "гурав дахь" давлагаа) 1970-аад оны үед Грек, Португал, Испанид өөр өөр нөхцөлд, мөн Өмнөд Европт эхэлсэн ба урт удаан хугацааны дарангуйллын

20 Ibid.

21 Ibid., 4.

22 Toby S. James, Holly Ann Garnett, Leontine Loeber, and Carolien van Ham, "Electoral Management and the Organizational Determinants of Electoral Integrity," International Political Science Review / Revue internationale de science politique 40, no. 3 (2019), 295–312, jstor.org.

23 Ibid.

24 Robert A. Dahl, Political Opposition in Western Democracies, 1st ed. (Yale University Press, 1966).

25 Ibid.

26 Larry Diamond, "Is the Third Wave Over?" Journal of Democracy 7, no. 3 (1996), 20–37.

дэглэмийн дараах дахин ардчилах үйл явц байсан.²⁷ Өмнөд Европын шилжилтийг Европын хамтын нийгэмлэг дэмжиж, Европын бусад орнуудын улс төрийн намуудаас дэмжлэг авч эхэлсэн нь ардчиллын шилжилтийг тод харуулна. Жишээлбэл, ХБНГУ-ын улс төрийн санаас²⁸ Испани дахь улс төрийн нам, эвслийн зохион байгуулалтад тусалж дараагаар нь Латин Америкийн зарим орнуудад ардчилах үйл явцад нь дэмжлэг үзүүлсэн байдаг.²⁹ Латин Америкт өрнөсөн энэ ардчилал нь 1980 он гэхэд Үндсэн хуульт ёс, Ерөнхийлөгчийн тогтолцоог үүсгэж улмаар намууд парламентын сонгуульд бие даан эсвэл эвслээр оролцох, сонгуулийн удирдлагын байгууллагын зохион байгуулалтад шинэчлэл хийгдсэн, орон нутгийн удирдлагуудыг сонгох боломжтой болсон зэрэг шинэчлэлийг авч иржээ.³⁰ Ийнхүү улс орнуудын ардчилах үйл явцыг Фрийдом хаус (Freedom house) байгууллагаас 1973 оноос эхлэн үнэлж эхэлсэн бөгөөд “ардчиллын босгыг давсан”, “хагас-ардчилсан”, “ардчиллын босгыг даваагүй” хэмээх утгаар 1973-2023 оны үзүүлэлтийг харьцуулсан байдлаар хүснэгт 1-д харуулав.³¹ Үүнд:

Хүснэгт 1: Дэлхийн улс орнуудын ардчилах үйл явц (1996, 1997 болон 2000 оны байдлаар)

Он	“Ардчиллын босгыг давсан”	“Хэсэгчилсэн эрх чөлөөтэй”	“Ардчиллын босгыг даваагүй”
1973 он	44 улс	36 улс	68 улс
1983 он	52 улс	54 улс	58 улс
1993 он	72 улс	63 улс	55 улс
2003 он	89 улс	54 улс	49 улс
2013 он	88 улс	59 улс	48 улс
2023 он	83 улс	56 улс	56 улс

(Эх сурвалж: Фрийдом Хаус -Freedom house)

Дээрх хүснэгтээс ардчиллын босгыг давсан улс орнуудын тоо аажим нэмэгдсэнийг, хагас-ардчилалтай, ардчилалгүй улс орнуудын тоо буурсан болохыг харж болно. Ийнхүү улс орнууд ардчилалд шилжсэнээр өөрийн улсын онцлог, улс төрийн нам, намын тогтолцоо, хууль тогтоомж, газар нутаг, соёл уламжлал зэрэгт үндэслэн сонгуулийн тогтолцоо, сонгуулийг зохион байгуулах институцийн зохион байгуулалтыг өөрийн онцлогт тохируулан боловсруулж эхэлсэн. Улмаар судлаачид сонгууль, сонгуулийн байгууллага судлалын хүрээнд судлах гол чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хөгжиж орчин үед иржээ.³² Үүнд:

Хүснэгт 2: Сонгуулийн төв байгууллагын судалгааны чиглэл болон голлох судлаачид

Ангилал	Судалгааны цар хүрээ	Голлох судлаачид
Сонгуулийн удирдлага	Санал өгөх, сонгуулийн бүртгэлийг хөтлөх, сонгуулийг зохион байгуулах ерөнхий үүрэг	- Пивен ба Кловард (1988, 2000); - Массикотт, Блэйс, Ёшинака (2004); - Вольфингер, Розенстоун (1980).
Сонгуулийн төв байгууллагын бие даасан хараат бус байдал	Сонгуулийн менежмент, чөлөөт шударга сонгуулийг хангахад сонгуулийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, бүтэц, чиг үүргийн бие даасан байдлыг хэрхэн хангах	- Пиппа Норрис (2004); - Алексадро Най (2014); - Ричард .В.Судриетт (2014).
Сонгуулийн тухай хууль тогтоомжийн судалгаа	Хуулийн дагуу хэн санал өгөх эрхтэй вэ гэдэг шалгуур	Уггэн ба Манза (2002)
Сонгуулийн хил хязгаарт холбогдох судалгаа	Сонгуулийн тойргийн тоо, хэлбэр, хэмжээ	Хэндли ба Грофман (2008)
Сонгуулийн санхүүжилтийн судалгаа	Улс төрийн намуудыг сонгуульд хэрхэн санхүүжүүлэх, түүний хяналт	Ван Бизен (2004)
Сонгуулийн тогтолцоог тодорхойлох судалгаа	Саналыг хэрхэн суудал болгон хувиргах асуудал	- Дюверже (1951); - Рэй (1967); - Фаррелл (2011); - Ренвик (2010).
Саналын хуудас, санал асуулгад холбогдох судалгаа	Бодлогын асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулах болон/ эсвэл иргэд сонгогдсон төлөөлөгчийг албан тушаалаас нь огцруулах нөхцөл байдал	- Паркинсон (2001); - Квортруп (2005); - Шлозман ба Йохай (2008).
Сонгуулийн шударга ёст холбогдох судалгаа	Сонгуулийн маргааныг шийдвэрлэх	- Орозко-Хенрикес (2010); - Эрнандес-Хуэрта (2017).

(Эх сурвалж: Toby S. James (2019) Comparative Electoral Management)

Дээрх сонгуулийн төв байгууллагад холбогдох судалгааны чиглэлүүдээс сонгуулийн удирдлага, болон сонгуулийн төв байгууллагын удирдлагын бие даасан хараат бус байдлаар холбогдох судалгаагаар дамжуулан сонгуулийн менежмент, чөлөөт шударга сонгуулийг хангахад сонгуулийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, бүтэц, чиг үүргийн бие даасан байдлыг хэрхэн хангах тухай судалдаг байна.

II. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ-ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААРХ ОНОЛЫН ХАНДЛАГА

Сонгуулийн төв байгууллагыг судлах, бүтэц-чиг үүргийн бие даасан байдлын хувьд хэрхэн хөгжиж буйг тодорхойлох, сонгуулийн байгууллагын хараат бус байдлыг үнэлэх нь

27 UNDP, “Electoral Management Bodies as Institutions of Governance,” (2014), eods.eu.

28 Ibid.

29 Rafael López-Pintor, Electoral Management Bodies as Institutions of Governance, 1st ed. (UNDP, Bureau for Development Policy, 2000).

30 Larry Diamond, Juan J. Linz, and Seymour Martin Lipset, Democracy in Developing Countries (4 vols.), 1st ed. (Lynne Rienner, 1988).

31 Freedom House, “Country and Territory Ratings and Statuses, 1973–2024,” n.d., freedomhouse.org.

32 Toby S. James, “Comparative Electoral Management: Performance, Networks, and Instruments,” n.d., tobysjames.com

орчин үеийн ардчиллыг бэхжүүлэхэд туслах сонгуулийн шинэчлэлийн үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тиймд, өгүүллийн энэ хэсэгт сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн харьцуулалтад зайлшгүй шаардлагатай 1) бүтэц-чиг үүргийн онол, 2) сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн тухай онол, хандлагыг танилцуулж улмаар дараагийн хэсэгт бүтэц-чиг үүргийн талаарх судлаачдын хандлагад үндэслэн хөгжсөн сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлыг (загварууд) танилцуулна.

2.1. Бүтэц-чиг үүргийн онолын тухай

Бүтэц-функцийн (The Structure-function theory) онолын социологийн үндсэн үзэл баримтлалыг Э.Дюркгейм боловсруулж, дараа нь Т.Парсонс боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулсан. Энэхүү онол нь нийгэм бол тогтвортой байдал, дэг журмыг хангахын тулд хамтран ажилладаг харилцан уялдаатай, харилцан хамааралтай хэсгүүдийн цогц систем гэж үздэг. Э.Дюркгеймийн бүтцийн функционализмын онол нь түүний "Нийгэм дэх хөдөлмөрийн хуваагдал", "Амиа хорлолт"³³ бүтээлд дурдсанчлан нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан уялдаа холбоо, тэдгээрийн тогтвортой байдлыг хангахад гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэдэг. Дюркгеймийн хэлснээр нийгэм нь бие биеэсээ хамааралтай, тодорхой чиг үүргийг биелүүлэхийн тулд хамтран ажилладаг жижиг нэгжүүдээс бүрддэг ба хэм хэмжээ, үнэт зүйл, хамтын ухамсар зэрэг нийгмийн баримтууд нь нийгмийн бүтцийг бий болгодог. Дюркгеймийн функционализмын онол нь нийгмийн хэсэг бүр тодорхой зорилготой бөгөөд нийгмийн аль нэг хэсэг нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй бол асуудал үүсдэг гэсэн үзэл баримтлалд суурилдаг.³⁴

Түүнчлэн бүтцийн функционализм гэж нэрлэгддэг Парсонсын онол нийгмийн бүтэц нь түүний үйл ажиллагаанаас хамаарч тодорхойлогддог гэсэн санаанд суурилдаг.³⁵ Тэрээр нийгмийн үзэгдлүүдийг хувь хүний утгын үүднээс ойлгох ёстой, харин оролцогчдын бүлгүүдийн дунд хамтын үйл ажиллагааны түвшинд авч үзэх ёстой хэмээдэг. Парсонсын онол нь нийгмийн интеграцчлалын ач холбогдол, нийгэм дэх дэг журам, тогтвортой байдлыг хангахад нийгмийн бүтцийн үүргийг чухалчилдаг.

Үүнээс, Э.Дюркхаймын боловсруулалт болон Т.Парсонсын дэвшүүлсэн бүтэц-функцийн онолыг нэгтгэн "нийгэм бол тогтвортой байдал, дэг журмыг хадгалахын тулд хамтран ажилладаг харилцан уялдаатай, харилцан хамааралтай хэсгүүдээс бүрдсэн цогц систем"³⁶ хэмээн дүгнэдэг. Харин бүтэц-функцийн онол нь нийгмийн бүтцийг бүрдүүлэхэд нийгмийн баримт, хэм хэмжээ, үнэт зүйл, хамтын ухамсар чухал ач холбогдолтой бөгөөд нийгмийн хэсэг бүрийн тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх үүргийг онцлох үүрэгтэй хэмээн үздэг.

Харин улс төрийн шинжлэх ухааны үүднээс бүтэц-чиг үүргийн хандлага нь улс төрийн шинжилгээнд системийн

хандлагыг сайжруулах явдал юм.³⁷

Бүтцийн функциональ хандлага нь улс төрийг ойлгох системийн арга барилаас илүү сайжирсан арга хэмээн судлаачид үздэг. Учир нь системийн арга барил нь хэтэрхий өргөн хүрээтэй бөгөөд бүтэц хэрхэн ажилладгийг тайлбарлаагүй. Харин бүтцийн функциональ хандлагыг анх Радклифф Браун, Малиновский зэрэг нийгмийн антропологичид, дараа нь Талкотт Парсонс, Мертон, Леви зэрэг социологичид боловсруулсан ба эдгээр эрдэмтдийн боловсруулалтад Дэвид Истоны улс төрийн тогтолцооны "Оролт-гаралт" бүхий загвар болон харьцуулсан улс төрийн институциональ хандлага нөлөөлсөн³⁸ байдаг. Бүтцийн функциональ хандлага нь системийн арга барил ба институцийн хандлагыг нэгтгэсэн ба анхаарах асуудал нь институцаас чиг үүрэг рүү шилжсэн явдал юм. Улмаар Габриэль Алмонд, Колеман нар төрийн тогтолцооны дөрвөн шинж чанарыг тодорхойлсон нь 1) бүх улс төрийн тогтолцоо улс төрийн бүтэцтэй; 2) улс төрийн бүх системүүд өөр өөр бүтцийг ашиглан янз бүрийн хэмжээгээр тодорхой үүргийг гүйцэтгэдэг; 3) улс төрийн бүх бүтэц олон талт үйл ажиллагаа явуулдаг; 4) бүх улс төрийн тогтолцоо нь холимог систем (орчин үеийн болон уламжлалт соёлын холимог) хэмээх 4 шинжтэй. Үүнээс бүтцийн функциональ хандлага нь тухайн нийгмийн харилцаанд тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэн оролцож буй институцийн бүтэц, чиг үүргийг чухалчлан авч үзэж нийгэмд тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг.

2.2. Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн тухай

Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүрэг хэмээх томъёоллыг онолын үүднээс задлан тайлбарлавал, Тоби Жеймсийн "Сонгуулийн удирдлагын байгууллага: үйл ажиллагаа, харилцаа, хэмжүүр" харьцуулсан судалгаанд бүтцийн хараат бус байдал гэдэг нь сонгуулийн төв байгууллагууд нь засгийн газрын салбар, ялангуяа гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан байхыг ойлгоно.³⁹ Энэ нь сонгуулийн байгууллага нь өөрийн гэсэн хууль эрх зүйн орчинтой, өөрийн төсөвт хяналт тавих, шийдвэр гаргах эрх мэдэлтэй, улс төрийн оролцогчдын зүй бус нөлөө, хөндлөнгийн оролцоогүй байх ёстой гэсэн үг.⁴⁰ Харин чиг үүргийн хараат бус байдал гэдэг нь сонгуулийн төв байгууллага чиг үүргээ гадны нөлөөлөл, дарамт шахалтгүйгээр гүйцэтгэх чадварыг хэлнэ. Үүнд сонгогчдын болон нэр дэвшигчийн бүртгэлийг хийх, санал авах байрыг бэлтгэх, зохион байгуулах, санал тоолох, санал хураалтад хяналт тавих, сонгуулийн маргааныг шийдвэрлэх зэрэг асуудал багтана.⁴¹ Үүнээс сонгуулийн төв байгууллагууд дээрх бүтэц-чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд улс төр болон бусад гадны хүчний хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдэл, нөөцтэй байх ёстой⁴²

37 Gabriel A. Almond and G. Bingham Powell Jr., "Structural Functional Approach," in *Comparative Politics: A Developmental Approach*, ed. Gabriel A. Almond and G. Bingham Powell Jr. (Little, Brown, 1966), 102–137.

38 Ibid.

39 Toby S. James, "Comparative Electoral Management: Performance, Networks, and Instruments," n.d., tobysjames.com

40 Ibid., 8.

41 Ibid., 8.

42 Toby S. James, "Comparative Electoral Management: Performance, Networks, and Instruments," n.d., tobysjames.com, 7.

33 Émile Durkheim, *Suicide: A Study in Sociology*, 1st ed. (The Free Press, 1951).

34 Émile Durkheim, *The Division of Labor in Society*, 1st ed. (The Free Press, 1933).

35 Talcott Parsons, *The Structure of Social Action*, 1st ed. (The Free Press, 1937).

36 Émile Durkheim, *The Division of Labor in Society*, 1st ed. (The Free Press, 1933), 45.

бөгөөд үүнийг чиг үүргийн бие даасан байдлаар шинжлэн судалдаг. Түүнчлэн судлаач Ван Хэм, Каролиен, Гарнетт нар "бүтцийн болон үйл ажиллагааны бие даасан байдал нь сонгуулийн үйл явцын шударга байдлыг хангах, ардчиллын зарчмуудыг дэмжихэд чухал ач холбогдолтой"⁴³ хэмээн бүтэц-чиг үүргээр дамжуулан судлах судалгааны чиглэл, зарчмыг тодорхойлжээ.

Улс төр судлаач П.Норрис⁴⁴, А.Най⁴⁵, Р.В.Судриетт зэрэг эрдэмтэд сонгуулийн менежмент, чөлөөт, шударга сонгуулийг хангахад сонгуулийн удирдлагын байгууллагуудын гүйцэтгэх үүрэг сэдвээр өргөн хүрээтэй судалгаа хийж⁴⁶ сонгуулийн удирдлагын байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны бие даасан байдлыг дэмжих хууль эрх зүйн орчин, институцийн зохицуулалт, шилдэг туршлагыг судалж бие даасан байдалд тулгарч буй сорилтыг арилгах, гадны нөлөөллийг бууруулах, чөлөөт, шударга сонгуулийн зохион байгуулалтыг хангах үүднээс⁴⁷ сонгуулийн төв байгууллагуудын бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлд бүтэц-чиг үүргийн бие даасан байдлын онолыг судалсан байна. Үүнээс Сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдал нь сонгуулийн үйл явцын нэгдмэл байдал, үр дүнтэй байдлыг хангахад хараат бус байдлын эдгээр хоёр хэлбэр чухал ач холбогдолтой гэх санаатай холбоотой.

АСДҮОУХ-ийн боловсруулсан "Сонгуулийн удирдлагын дизайн" судалгаанд нь сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлыг бие даасан, засгийн газрын болон холимог гэсэн гурван загварт ангилсан.⁴⁸ Эдгээр загварууд тухайн улс орныхоо хууль тогтоомж, засаглал, улс төрийн нөхцөлөөс үүдэн ялгаатай байдлаар зохицуулагдаж хөгжсөн. Тухайлбал, бие даасан загвар бүхий улсууд сонгуулийн төв байгууллагыг Үндсэн хууль эсвэл хууль тогтоомжийн хүрээнд байгуулж баталдаг байгуулдаг.⁴⁹ Засгийн газрын харьяа бүтэцтэй сонгуулийн төв байгууллага нь засгийн газрын шууд удирдлага дор эсвэл хууль зүйн яамны дор зохион байгуулагддаг. Холимог загварт хамаардаг улсууд сонгуулийн удирдлагыг удирддаг хоёр ба түүнээс дээш байгууллагуудын холимог загвар болох бөгөөд хяналтын үүргийг бие даасан байгууллагад, бодлого боловсруулах, санал гаргах үүргийг засгийн газрын харьяа хэсэгтээ өгч үүргийн хувьд хуваагддаг.⁵⁰

Сонгуулийн төв байгууллагыг институцийн хувьд бие даасан эсэх нь бүтцийн, чиг үүргийн, эрх хэмжээний, нөөцийн хувьд бие даасан эсэхээс хамаарна.⁵¹ Эдгээрт,

бүтцийн хараат бус байдал нь үндсэн үүргээ хэрэгжүүлэхдээ бусад байгууллагаас үл хамаарах, өөрийн бие даасан тогтолцоотой уг бүтцийн удирдлага, дотоод нэгжүүд хэрхэн бүрэлдэж, сонгуулийн удирдлагын байгууллага нь гүйцэтгэх засаглал болон төрийн бусад байгууллагатай хэрхэн холбогдож буйгаар тодорхойлогддог.⁵² Харин **чиг үүргийн хараат бус байдал** нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусад байгууллагаас хамааралгүй, чиг үүргээ хуваалцахгүй, шилжүүлэхгүй бөгөөд давхар эдлэхгүй байхыг хэлнэ. **Нөөцийн хувьд бие даасан байх** гэдэгт боловсон хүчин болон эд материал, техник, технологитой, өөрийн төсөв, хөрөнгөтэй улмаар бие даан захирах зарцуулах эрхтэй байх асуудал болно. Эцэст нь **эрх хэмжээний хувьд байгууллага бие даасан байх** гэдэгт шийдвэрээ хуульд нийцэж гарахдаа хэнээс ч хараат бусаар ажиллахыг ойлгоно.⁵³

Түүнчлэн сонгуулийн төв байгууллага нь сонгууль зохион байгуулах, хянах, баталгаажуулах гэсэн гурван багц үйл ажиллагааг хамардаг.

1. **Сонгуулийн бодит үйл явцыг зохион байгуулах**⁵⁴ (сонгуулийн өмнөх бүртгэл, сурталчилгаа, нам, нэр дэвшигчийн бүртгэлээс эхлээд сонгуулийн өдрийн бодит санал хураалт, сонгуулийн дараах санал тоолох хүртэлх) процессыг хамаарсан үйл ажиллагаа.⁵⁵
2. **Сонгуулийн үйл явцын туршид сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавих** (тухайлбал, сонгуулийн өмнөхөн улс төрийн нам/нэр дэвшигчдийн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих, сонгогч болон намын сонгогдох эрхийн талаарх зохицуулалтын хэрэгжилт, сурталчилгааны санхүүжилт, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, санал тоолох, санал хураах журам гэх мэт)-д холбогдсон үйл ажиллагаа.
3. **Сонгуулийн дүнг зарлах замаар сонгуулийн дүнг баталгаажуулах** үйл ажиллагааг хамаарч байна.

Түүнчлэн сонгуулийн төв байгууллагын бүтэц-чиг үүргийн бие даасан байдалд албан ёсны буюу де-юре бие даасан байдал (formal or de jure independence) ба албан бус буюу де-факто бие даасан байдал (informal or de facto independence) хэмээх ойлголт⁵⁶ байна. Албан ёсны бие даасан байдал гэдэгт Үндсэн хууль, эрх зүйн болон бусад баримт бичигт тусгагдсан албан ёсны дүрмийг хэлнэ. Албан бус бие даасан байдал гэдэгт эдгээр дүрмийг практикт хэр зэрэг мөрдөж байгааг хэлнэ.⁵⁷

43 Carolyn van Ham and Holly Ann Garnett, "Building Impartial Electoral Management? Institutional Design, Independence and Electoral Integrity," *International Political Science Review* 40, no. 3 (2019), 313–334.

44 Pippa Norris, Bernard Grofman, and James Adams, *Electoral Engineering: Voting Rules and Political Behavior*, 1st ed. (Cambridge University Press, 2004).

45 Alessandro Nai, *The Electoral Consequences of Third Party Mobilization: The Case of the German Pirate Party*, 1st ed. (ECPR Press, 2014).

46 Richard W. Soudriette and Pippa Norris, *Election Management Bodies: Ensuring Integrity and Independence*, 1st ed. (Oxford University Press, 2014).

47 Toby S. James, "Comparative Electoral Management: Performance, Networks, and Instruments," n.d., tobysjames.com

48 Helen Catt, *Electoral Management Design*, 1st ed. (International IDEA, 2014).

49 Ibid.

50 Mohamed Musbeh, "Managing Elections: Definition and Classification of Elections Management Bodies," n.d., academia.edu

51 International IDEA, *Electoral Management Design*, revised ed. (Sweden: International IDEA, 2014), 4.

52 Ogwen Joseph, "Independence in Electoral Management," *Electoral Processes Primer* 1, n.d., aceproject.org

53 International IDEA, *Electoral Management Design*, revised ed. (Sweden: International IDEA, 2014), 4.

54 Jørgen Elklit and Andrew Reynolds, "Analysing the Impact of Election Administration on Democratic Politics," *Representation* 38, no. 1 (2001): 3–10.

55 Sarah Birch, *Electoral Malpractice*, 1st ed. (Oxford University Press, 2011).

56 Westminster Foundation for Democracy, "A New Framework for Understanding and Assessing Electoral Commission Independence," January 2022, wfd.org

57 Ibid.

III. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ХЭВ ЗАГВАРЧЛАЛЫН ТАЛААРХ ОНОЛЫН ХАНДЛАГА

Сонгуулийн төв байгууллагын үндсэн зарчим, ангилал, бүтэц-чиг үүрэг, үйл ажиллагааг хөндөж боловсруулагдсан АСДҮОУХ-ийн "Сонгуулийн байгууллагын загвар" судалгаа, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хөгжлийн бодлогын хорооны "Сонгуулийн удирдлагын байгууллагууд нь засаглалын институт" судалгаа, Харвардын Их Сургуулийн "Мэргэжлийн сонгуулийн удирдлагыг төлөвшүүлэх" тайлан, Хуулиар ардчилал тогтоох Венецийн Комиссын "Сонгуулийн хэрэглэгдэхүүн: сайн туршлага" зөвлөмж баримт бичгүүд байна. Эдгээр олон улсын зөвлөмж, стандарт, судалгаанд сонгуулийн төв байгууллагыг ангилах гурван үндсэн шалгуур ашиглагддаг.⁵⁸ Үүнд:

1. Чиг үүргийн бие даасан байдал (бие даасан, засгийн газрын болон холимог сонгуулийн төв байгууллага хэмээн 3 хэсэгт ангилна).
2. Газарзүйн харьяалал (төвлөрсөн ба төвлөрсөн бус сонгуулийн төв байгууллага хэмээн ангилна).
3. Байнгын болон түр зуурын зохион байгуулалтад ордог гэх шинжээр сонгуулийн төв байгууллагын ангилдаг.

Эдгээр гурван үндсэн шалгуураас гадна "Олон улсын сонгуулийн төв байгууллага" хэмээн нэрлэгддэг хязгаарлагдмал төрлийн сонгуулийн удирдлагын байгууллага байх ба зөвхөн шилжилтийн үеийн сонгуулийн удирдлагын үйл явцтай холбоотой ангилал үүнд хамаарна.⁵⁹ Дээрх шалгуураас эхний буюу **чиг үүргийн бие даасан байдалд** үндэслэн улс орнуудын сонгуулийн төв байгууллагыг **"бие даасан, засгийн газрын, холимог"** хэмээх гурван загварт ангилдаг бөгөөд судалгааны энэ хэсэгт улс орнуудыг хэрхэн чиг үүргийн бие даасан байдлын ангиллаар ангилан, судлах тухай ойлголт, нөлөөлөх хүчин зүйлс, үндсэн шинж тэмдгүүдийг танилцуулж харьцуулсан судалгаагаар сонгон авсан Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид, БНСУ гэх), Бүгд Найрамдах Эстони Улс (цаашид, БНЭУ гэх)-ын сонгуулийн төв байгууллагыг судална.

Үндсэн шалгуурыг 1) газарзүйн байрлалын ангилал болох төвлөрсөн ба төвлөрсөн бус сонгуулийн төв байгууллагын тухай, 2) харьяаллын хугацаа буюу байнгын болон түр сонгуулийн төв байгууллагын тухай, 3) чиг үүргийн бие даасан байдал буюу бие даасан, засгийн газрын болон холимог сонгуулийн төв байгууллагын тухай гэх дарааллаар танилцуулна.

1. Газар зүйн харьяаллын буюу Төвлөрсөн ба төвлөрсөн бус сонгуулийн төв байгууллагын тухай /Centralized or Decentralized Election Management Bodies/⁶⁰

Эрх мэдлийн төвлөрөл, хуваарилалт нь сонгуулийн хуулиар дамжин тодорхойлогддог сонгуулийн төв

байгууллагуудын харьяаллыг тодорхойлох гол хүчин зүйл мөн бөгөөд энэ нь төрийн хэлбэр, улс төрийн тогтолцооноос ихээхэн хамаардаг. Сонгуулийн эрх зүйн зохицуулалтаар тухайн үндэсний сонгуулийн төв байгууллага болон харьяа, бүс нутаг, орон нутгийн сонгуулийн төв байгууллагад олгогдсон чиг үүрэг, эрх мэдлийн ялгаатай байдлыг харах боломжтой. Сонгуулийн төв байгууллагын газар зүйн байршлаар зохион байгуулагдсан салбаруудын (үндэсний, орон нутгийн) эрх мэдэл, чиг үүргийн босоо хуваарилалт нь үндэсний сонгуулийн төв байгууллага болон аймаг, бүс нутгийн эсвэл орон нутгийн сонгуулийн төв байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэгдсэн байх ёстой. Зарим улсын хувьд газарзүйн байрлал, газар нутгийн хэмжээнээс хамааран нэг сонгуулийн төв байгууллагатай байдаг бол зарим улс үндэсний, бүс нутаг, орон нутгийн түвшинд, эсвэл шат бүрт өөр өөр эрх мэдэл, чиг үүрэгтэй сонгуулийн удирдлагын байгууллагыг үүсгэсэн (Литва Улс, Словак Улс, Коста Рика Улс, Гана Улс, Филиппин Улс) байдаг.⁶¹

Төвлөрсөн бус зохион байгуулалтад сонгуулийн үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэхэд орон нутгийн эрх баригчдад түшиглэсэн төрийн болон холимог байгууллагуудтай зохицуулалт хамаарна. Ийм төрлийн төвлөрсөн бус удирдлага нь ажиглалт, бодлого боловсруулах асуудал эрхэлсэн сонгуулийн төв байгууллагын хэсэг, тухайн орон нутгийн сонгуулийн нэгжийн удирдлага хамаардаг.

Тухайлбал, хамгийн их төвлөрсөн бус сонгуулийн төв байгууллагуудын тохиолдлуудыг үндэсний болон холбооны дүүрэг, муж улсын түвшинд өөр өөр сонгуулийн төв байгууллагууд өөр өөр сонгуулийн тогтолцоог ашиглаж, ялгаатай сонгуулийн эрх зүйн тогтолцоог ажиллуулж болох холбооны улс орнуудаас (АНУ, Австрали Улс, Канад Улс, ОХУ, Энэтхэг Улс, Швейцар Улс) харж болно.⁶²

2. Байнгын болон түр зуурын зохион байгуулалт /Permanent and Temporary Election Management Bodies/⁶³

Сонгуулийн төв байгууллагыг байнгын болон түр гэж ангилах нь сонгуулийн байгууллагын зохион байгуулалтын хугацаанд үндэслэсэн ойлголт байна. Энэхүү ангилал нь сонгуулийн үйл явцын янз бүрийн үе шатыг явуулахад шаардагдах чиг үүрэг, хариуцлага, бүрэн эрхтэй холбоотой. Тухайлбал, сонгуулийн журам боловсруулах, сонгогчийн бүртгэл хийх, улс төрийн нам, нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн боловсон хүчнийг сонгон шалгаруулах, сургах, сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаанд хяналт тавих, санал авах, тоолох үйл ажиллагаа, сонгуулийн маргааныг шийдвэрлэх, сонгуулийн үр дүнд аудит хийх, үр дүнг зарлах болон архивлах гэх мэт чиг үүрэг, хариуцлагатай холбоотойгоор байнгын эсвэл түр хугацааны гэх ангилал бий болсон.⁶⁴ Нэг сонгуулийн үйл явц дууссаны дараа дараагийн шатны ажил эхлэх нь зүй ёсных тул сонгуулийн

58 Rafael López-Pintor, Electoral Management Bodies as Institutions of Governance, 1st ed. (UNDP, Bureau for Development Policy, 2000), 21–30.

59 Ibid.

60 Ibid.

61 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

62 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 18.

63 Rafael López-Pintor, Electoral Management Bodies as Institutions of Governance, 1st ed. (UNDP, Bureau for Development Policy, 2000), 21–30.

64 Ibid.

бүх үйл явцыг сонгуулийн мөчлөг гэж тодорхойлдог. Тухайн улсад байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллага тохиромжтой юу, эсвэл түр зуурын шинжтэй байгууллага тохиромжтой эсэхийг тодорхойлоход анхаарах гол хүчин зүйл нь сонгуулийн мөчлөгийн үеийн ажлын ачаалал болон санхүүгийн чадавхын асуудал байна. Сонгуулийн төв байгууллага байнгын ажиллагаатай байх үед шаардагдах зардлыг, сонгууль, санал хураалтын үйл ажиллагаа бүрт сонгуулийн төв байгууллага байгуулахад шаардагдах зардалтай харьцуулах шаардлагатай ба улс орнууд ихэвчлэн байнгын ажиллагаатай загварыг сонгодог.

Сонгуулийн мөчлөг хэт богино, ойр ойрхон зохион байгуулагддаг мөн тухайн байгууллагад холбогдох үйл ажиллагаа (сонгогчдыг бүртгэх, сонгуулийн үеийн болон намын санхүүгийн хяналт зэрэг) богино хугацаанд байнга зохицуулагдсан, түүнчлэн хууль тогтоомжоороо сонгогчийн боловсролыг тасралтгүй дэмждэг улсын хувьд байнгын ажиллагаатай сонгуулийн төв байгууллагаатай ажилладаг.⁶⁵

Түр хугацааны зохион байгуулалттай сонгуулийн төв байгууллага нь зөвхөн сонгуулийн үеэр байдаг тул сонгуультай холбоотой архивыг хөтлөх, хадгалах, урт хугацааны сан үүсгэх зэрэгт асуудал үүсдэг. Ийм төрлийн зохион байгуулалт нь чиг үүргийн бие даасан байдлын засгийн газрын болон холимог загваруудын аль нэгийг дагаж тогтдог. Өөрөөр хэлбэл, засгийн газрын эсвэл холимог загварын аль нэгт хамаарсан үед сонгуулийг удирдан зохион байгуулж буй төрийн албан хаагчид нь сонгууль явуулахаас өмнө өөр чиглэлд алба хашиж зөвхөн сонгуулийн үеэр сонгуулийн удирдлагын байгууллагад шилжүүлж ажилладаг.⁶⁶

3. Чиг үүргийн бие даасан байдал буюу бие даасан, засгийн газрын болон холимог загвар /Independent, Governmental and Mixed Election Management Bodies/⁶⁷

Сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдал нь гурван загварт хуваагдана. Нэгдүгээрт, Засгийн газрын загвар буюу сонгуультай холбоотой бодлого болон хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага нь засгийн газрын удирдлагад харьяалагддаг.⁶⁸ Хоёрдугаарт, бие даасан загвар буюу сонгуулийн бодлого болон хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага нь гүйцэтгэх эрх мэдэлд харьяалагдахгүй, хариуцлага хүлээдэггүй загвар болно.⁶⁹ Гуравдугаарт, холимог загвар буюу сонгуулийн бодлогыг засгийн газрын харьяа байгууллага хэрэгжүүлэх боловч хяналттай холбоотой харилцааг бие даасан институт хэрэгжүүлдэг холимог бүтэцтэй загвар⁷⁰ байна. Дэлхийн улс орнуудын сонгуулийн төв байгууллагыг чиг үүргийн бие даасан байдлаар нь дээрх гурван загварт хувааж улмаар

загвар тус бүрийн онцлог, шинжээс үүдэн тухайн улсын сонгуулийн төв байгууллагыг бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж чадаж буй эсэхийг тодорхойлох боломжтой байна. Иймд, гурван загварын талаар авч үзье.

а. Бие даасан загвар

Сонгуулийн төв байгууллагуудын бие даасан загвар гэдэг нь сонгуулийн төв байгууллага сонгуулийг удирдах шууд үүрэг, эрх мэдэлтэй, өөрийн төсөвтэй, захиран зарцуулдаг төрийн гүйцэтгэх засаглалаас бие даасан байдлыг хэлнэ.⁷¹ Энэхүү бие даасан загварт хамаарах сонгуулийн төв байгууллага нь зохион байгуулалт болон бүрэн эрхийн хугацаандаа гүйцэтгэх засаглалаас хараат бус гишүүдээс бүрдэнэ.⁷² Түүнчлэн төрийн аль ч яам, агентлагийн өмнө хариуцлага хүлээхгүй, харин хууль тогтоох байгууллага, шүүх эрх мэдэл, төрийн тэргүүнд тайлагнах зохицуулалттай. Энэ загварт хамаарах улсын сонгуулийн төв байгууллага нь санхүү, төсөвт хамаарах асуудлын хувьд Үндсэн хуулийн бусад байгууллагууд тухайлбал, шүүх, хууль тогтоох байгууллагын өмнө хариуцлага хүлээж болно. Зарим бие даасан сонгуулийн төв байгууллага нь үүрэг, хариуцлагын хуваарилалтаас шалтгаалан хоёр дэд институт буюу байгууллагад хуваагддаг бөгөөд аль аль нь бие даасан, гүйцэтгэх засаглалаас хараат бус байдаг тул бие даасан сонгуулийн төв байгууллага нэрлэдэг. Энэ загварт сонгуулийн удирдлагын хоёр дэд байгууллагын механизм нь төрийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцааны ижил санааг хэрэгжүүлдэг. Дэд байгууллагуудын нэг нь сонгуулийн үйл явцтай холбоотой хууль тогтоомж, шийдвэр гаргах чиг үүрэг, эрх мэдэлтэй байх магадлалтай бол нөгөө нь сонгуулийн үйл ажиллагааг явуулах, хэрэгжүүлэх асуудлыг хариуцах үүрэгтэй байна.⁷³ Бие даасан загвартай улс орнууд сонгуулийн төв байгууллагын эрх зүйн үндсийг Үндсэн хууль эсвэл салбар хуулиар тогтоодог. Тухайлбал, БНСУ, Турк, Энэтхэг, Индонез, БНЭУ, Канад, Австрали, Австри, Польш, Гүрж, Шинэ Зеланд, Монгол зэрэг дэлхийн 138 улс бие даасан загварыг ашигладаг.⁷⁴

б. Засгийн газрын загвар

Засгийн газрын харьяа сонгуулийн төв байгууллагууд нь яам (ихэвчлэн Хууль зүйн яам) эсвэл орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан гүйцэтгэх засаглалд харьяалагддаг институт сонгуулийг хэрэгжүүлж, удирдан зохион байгуулахыг хэлнэ.⁷⁵ Ийм загварт, төрийн сонгуулийн эрх бүхий байгууллагын гишүүд, албан тушаалтнуудыг төрийн албан тушаалтан хэмээн үзэж тэдгээрийн төсөв нь яам, орон нутгийн засаг захиргааны нийт төсвийн хуваарилалтад багтсан байдаг. Энэ загварт төрийн сонгуулийн удирдлагын байгууллагын чиг үүрэг, санхүүгийн асуудал нь гүйцэтгэх

65 Ibid.

66 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

67 Rafael López-Pintor, Electoral Management Bodies as Institutions of Governance, 1st ed. (UNDP, Bureau for Development Policy, 2000), 21–30.

68 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

69 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

70 Ibid.

71 Ibid.

72 Ibid.

73 Ibid.

74 International IDEA, Electoral Management Bodies (EMBs): Functions, Autonomy, and Legitimacy. https://www.idea.int/data-tools/data/question-region?question_id=9388&countries=all&database_theme=308 (last visited Apr. 20, 2025).

75 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

засаглалын өмнө хариуцлага хүлээдэг.⁷⁶ 2023 оны байдлаар АСДҮОУХ-ийн сонгуулийн удирдлагын дизайны мэдээллийн санд⁷⁷ засгийн газрын загварыг ашигладаг ХБНГУ, АНУ, Сингапур Улс, Англи, Вьетнам, Итали, Денмарк, Норвег, Грек зэрэг 44 улс байна.

в.Холимог загвар

Холимог хэлбэрийн сонгуулийн төв байгууллагуудад сонгуулийг зохион байгуулах, удирдан явуулахын тулд хоёр ба түүнээс дээш сонгуулийн төв байгууллага хамтран ажилладаг хэлбэрийг хэлнэ.⁷⁸ Холимог сонгуулийн удирдлагын байгууллагууд ихэвчлэн давхар эсвэл олон салаалсан бүтэцтэй байдаг бөгөөд бүтэц тус бүрд оногдсон чиг үүрэг, хариуцлагын дагуу хуваагддаг.⁷⁹

Холимог загварыг 1) бодлого боловсруулах, хууль тогтоох, хяналт тавих, 2) сонгууль явуулах, удирдах үүргийг гүйцэтгэх хэмээх хоёр хэсэгт хувааж болно.⁸⁰ Үүнээс

бодлого боловсруулах, хууль тогтоох, хяналт тавих чиглэлд ажиллахдаа төрийн гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус бие даасан сонгуулийн удирдлагын байгууллага хэлбэрээр буюу бие даасан загвартай ижил байдлаар ажилладаг. Харин сонгууль явуулах, удирдах үүргийг гүйцэтгэхдээ төрийн гүйцэтгэх засаглалын хүрээнд ажиллаж нэг эсхүл хэд хэдэн байгууллагын хүрээнд хамаарсан тохиолдолд холимог загвартай хэмээн тооцогддог. 2023 оны байдлаар АСДҮОУХ-ийн сонгуулийн удирдлагын дизайны мэдээллийн санд холимог загвартай хэмээх бүртгэгдсэн⁸¹ Испани, Япон, Нидерланд, Франц, Унгар, Аргентин зэрэг 28 улс байна. Тухайн улсын сонгуулийн төв байгууллага чиг үүргийн бие даасан байдлын хувьд аль загварт хамаарах болохыг 1) бүтэц зохион байгуулалт, 2) үйл ажиллагааны чиглэл, 3) үйл ажиллагаагаа тайлагнах этгээд, 4) эрх мэдэл, 5) бүрэлдэхүүн, 6) бүрэн эрхийн хугацаа, 7) төсвийн хуваарилалт хэмээх элементээр тодорхойлдог. Хүснэгт 3-т АСДҮОУХ-ийн боловсруулсан загвар бүрт хамаарах элементийг харуулж тайлбарлав.

Хүснэгт 3: Сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлын ангилал

Загвар	Бие даасан загвар	Засгийн газрын загвар	Холимог загвар	
			Бие даасан бүрэлдэхүүнтэй	Засгийн газрын бүрэлдэхүүнтэй
Зохион байгуулалтын бүтэц	Гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус	Төрийн болон орон нутгийн засаг захиргааны хэлтэс дотор эсвэл удирдлагад хамаарна.	Гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байна.	Төрийн болон орон нутгийн засаг захиргааны хэлтэс дотор эсвэл түүний удирдлагын бүтэцэд хамаардаг.
Үйл ажиллагааны чиглэл	Үйл ажиллагааны хэрэгжилтийг өөрөө бүрэн хариуцдаг	Хэрэгжилтийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хариуцна.	Хэрэгжилтийг хянах, зарим тохиолдолд бодлогоо тодорхойлох бие даасан эрхтэй.	Гүйцэтгэх эрх мэдлээс хэрэгжилт, удирдлага болон хяналтыг хариуцна.
Үйл ажиллагаагаа тайлагнах	Үйл ажиллагаагаа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад тайлагнадаггүй. Шүүхэд хариуцагч болж оролцоно. Сонгуулийн үр дүнг Ерөнхийлөгч эсвэл Парламентад өргөн барина.	Үйл ажиллагаагаа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад бүрэн тайлагнана.	Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад тайлагнадаггүй бөгөөд хууль тогтоох байгууллага, шүүх эрх мэдэл, төрийн тэргүүнд сонгуулийн дүнг өргөн барина.	Үйл ажиллагаагаа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад бүрэн тайлагнана.
Эрх мэдэл	Сонгуулийг бие даан зохион байгуулах, зарим тохиолдолд улс төрийн намыг бүртгэх	Хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаасаа хамаарч хязгаарлагдмал эрх мэдэлтэй.	Ихэнхдээ сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг хуулийн дагуу бие даан зохион байгуулах эрхтэй.	Хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаасаа хамаарч хязгаарлагдмал эрх мэдэлтэй
Бүрэлдэхүүн	Гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус гишүүдээс бүрдэнэ.	Сайд эсвэл гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах албан хаагч удирдана.	Гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус гишүүдээс бүрдэнэ.	Сайд эсвэл төрийн албан хаагч удирдана. Сонгуулийн төв байгууллагыг "гишүүд" байхгүй. Нарийн бичгийн дарга нарын газартай.
Бүрэн эрхийн хугацаа	Бүрэн эрхийн хугацаа дахь үйл ажиллагааны баталгааг хуульчилсан гэхдээ бүрэн эрхийн хугацаанаас өмнө дуусгавар болох боломжтой.	Хугацаа тогтоодоггүй	Бүрэн эрхийн хугацаа дахь үйл ажиллагааны баталгааг хуульчилсан гэхдээ бүрэн эрхийн хугацаанаас өмнө дуусгавар болох боломжтой.	Бүрэн эрхийн хугацаанд хамаарах баталгаа тогтоодоггүй
Төсвийн хуваарилалт	Төсөвлөгдсөн төсөвтэй бөгөөд Засгийн газрын хяналтаас үл хамаарч захиран зарцуулна.	Засгийн газар эсвэл орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд хамааран төсвийг батална.	Хуваарилагдсан төсөвтэй байна.	Засгийн газар эсвэл орон нутгийн төсвийн бүрэлдэхүүнд хамааран төсвийг батална.

76 Ibid.

77 International IDEA, Electoral Management Bodies (EMBs): Functions, Autonomy, and Legitimacy. https://www.idea.int/data-tools/data/question-region?question_id=9388&countries=all&database_theme=308 (last visited Apr. 20, 2025).

78 Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006), 17.

79 Ibid.

80 Ibid.

81 International IDEA, Electoral Management Bodies (EMBs): Functions, Autonomy, and Legitimacy. https://www.idea.int/data-tools/data/question-region?question_id=9388&countries=all&database_theme=308 (last visited Apr. 20, 2025).

АСДҮОУХ-ээс боловсруулсан дэлхийн 213 улсын хууль тогтоомж, өгөгдөлд хийсэн судалгааны дүнд сонгуулийн төв байгууллагын чиг үүргийн бие даасан байдлын "бие даасан загвар" хамгийн түгээмэл буюу 134 (64.79%) улсад ашиглагдаж байна. Хүснэгт 4-ийг харна уу.

Хүснэгт 4: Сонгуулийн төв байгууллагын загвар, дэлхийн төвшинд

Агуулга	Үнэлгээ
Холимог	28 (13.15%)
Бие даасан	138 (64.79%)
Засгийн газрын	44 (20.66%)
Сонгуульгүй улс	3 (1.41%)
Нийт дүн	213

(Эх сурвалж: International IDEA, Electoral Management Design)

Дээрх үзүүлэлтийг бүс нутгийн түвшинд авч үзвэл тив бүрт "бие даасан" загвараар сонгуулийн төв байгууллагаа байгуулах нь ихээхэн элбэг байна. Тухайлбал, Ази тивийн 47 улсын 74.47 хувь нь "бие даасан загвар"-аар сонгон сонгуулийн төв байгууллагаа зохион байгуулжээ. Үүнд, Монгол Улс мөн хамаарна.

Хүснэгт 5: Сонгуулийн төв байгууллагын загвар, бүс нутгийн төвшинд

Агуулга	Африк	Америк	Ази	Европ	Далайн улс
Холимог	11 (20.75%)	4 (10.53%)	4 (8.51%)	8 (17.78%)	1 (6.25%)
Бие даасан	41 (77.36%)	28 (73.68%)	35 (74.47%)	20 (44.44%)	10 (62.50%)
Засгийн газрын	1 (1.89%)	6 (15.79%)	5 (10.64%)	17 (37.78%)	5 (31.25%)
Сонгуульгүй улс	0	0	3 (6.38%)	0	0
Нийт дүн	53 улс	38 улс	47 улс	45 улс	16 улс

(Эх сурвалж: International IDEA, Electoral Management Design)

Дэлхийн 213 улсыг хамарсан судалгааны өгөгдөлд хийсэн үр дүн болон бүс нутгийн хэмжээнд ангилан авч үзсэн үзүүлэлтэд "бие даасан загвар" ихээхэн өндөр сонголттой байх тул эдгээр загваруудыг давуу болон сул талыг зайлшгүй судалж улс орнуудыг сонголтын шалтгааныг тодруулах хэрэгтэй. Иймд Хүснэгт 6-д загваруудын сул болон давуу талыг⁸² оруулав.

Хүснэгт 6: Сонгуулийн төв байгууллагын загваруудын давуу болон сул тал

	Давуу тал	Сул тал
Бие даасан загвар	- Сонгуулийн байгууллагын чадавч, арга барил болон ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. - Сонгуулийн үйл ажиллагааг бие даан, уялдаа холбоо сайтайгаар зохион байгуулах боломжтой. - Санхүүжилт болон сонгуулийн үйл ажиллагааны хэрэгжилтэд өөрөө хяналт тавьдаг. - Сонгуулийн үйл ажиллагааны нэгдсэн хяналтыг хэрэгжүүлдэг. - Улс төрийн хувьд хараат бус байж сонгуулийг шударга зохион байгуулах итгэлийг бий болгодог.	- Улс төрийн болон сонгуулийн системийн шийдвэр гаргагчаас хэт бие даасан байдаг. - Хангалттай төсөв бүрдүүлэхэд шаардлагатай улс төрийн нөлөө бага. - Гишүүдийн халаа, сэлгээ нь байгууллагын чадахыг бууруулах магадлалтай. - Төрийн албанд шаардлагатай (тохирохуйц) туршлага болон чадвар дутагдах магадлалтай. - Бие даасан байгууллага тул засгийн газраас төсөв бүрдүүлэх боломжгүй тул их өртөгтэй.

82 International IDEA, Electoral Management Design, revised ed. (Sweden: International IDEA, 2014).


Засгийн газар	- Байгууллагын бүтэц нь тогтвортой байна. - Төрийн алба дахь туршлагатай мэдлэгтэй хүмүүсээс бүрдэнэ. - Сонгуулийг зохион байгуулахад төрийн байгууллагатай хамтран ажиллахад саадгүй, хялбар байна. - Засгийн газрын хэлтэс болон төрийн бусад байгууллагатай хамтрах буюу нөөц боломжоо хамтран ашигласнаар зардал хэмнэгдэнэ. - Засгийн газар дотор сонгуулийн төв байгууллага эрх мэдэл болон нөлөөтэй байна.	- Засгийн газарт харьяалагддаг тул улс төрийн хараат бус байдалд нь олон нийт эргэлздэг. - Санхүүжилтийн хуваарилалт болон сонгуулийн бодлогын талаар засгийн газар, орон нутгийн засаг захиргаа шийдвэр гаргах эрх мэдэлтэй. - Сонгуулиар мэргэшсэн хүний нөөц дутмаг. - Засгийн газрын бүрэлдэхүүнд хамаарах нь өөрөө сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад тохиромжтой бус.
Холимог загвар	- Бие даасан нэгжийн гишүүдэд итгэх итгэл нь сонгуулийн хууль ёсны байдлыг нэмэгдүүлж чадна. Хэрэгжүүлэгч нэгж нь тогтвортой байдлаар хангагдсан байна. - Гадны бие даасан, туршлагатай боловсон хүчний нөөцтэй байна. - Хэрэгжүүлэгч нэгж нь сонгуулийн үйл ажиллагаа явуулахад төрийн бусад байгууллагатай хамтран ажиллахад тохиромжтой байдлаар хангагдсан. - Бие даасан нэгж нь бодлого болон санхүүжилтээ хянадаг. Хэрэгжүүлэгч нэгж нь засгийн газрын бүтэцэд харьяалагдах тул зардал хэмнэнэ.	- Сонгуулийн үйл ажиллагааг засгийн газрын бүтэцэд хамаарах нэгж нь зохион байгуулах тул иргэдийн итгэл сул байх талтай. - Бие даасан нэгжийн гишүүний халгаа, сэлгээ нь байгууллагын туршлага, тогтвортой байдлыг алдагдуулах магадлалтай. - Бие даасан нэгж нь улс төрийн нөлөөлөл бага учир хангалттай хэмжээний төсөв бүрдүүлэхэд хүндрэлтэй. Хэрэгжүүлэгч нэгжийн төсвийн хуваарилалт зэрэг нь төв болон орон нутгийн засаг захиргааны шийдвэрээс хамаардаг. - Бие даасан нэгж нь улс төрийн чадвар дутмаг байх магадлалтай. Хэрэгжүүлэгч нэгжийн төрийн албаны хэв маяг нь сонгуулийн үйл ажиллагааны болон хяналтыг зохион байгуулахад тохиромжгүй байх магадлалтай.

(Эх сурвалж: International IDEA, Electoral Management Design)

Загваруудын давуу болон сул талыг дүгнэхэд, бие даасан загвар нь хараат бусаар ажиллах нөхцөлийг өөртөө бүрдүүлсэн байдаг тул иргэдийн итгэлийн ихээхэн хүлээдэг, төсвийн хувьд бие даан захиран зарцуулах эрх мэдэлтэй байх тул гишүүн болон ажилчдын хувьд хараат бусаар ажиллах орчин бүрдсэн байна.

Засгийн газрын загварт байгууллагын бүтэц, чиглэл тогтвортой, хүн хүчний нөөц хангалттай, хамтын ажиллагаа их тул төсвийг хэмнэх боломжтой гэх мэт давуу талтай ч улс төрийн хараат бус байдал, шударга сонгууль явагдаж буй эсэх нь олон нийтэд эргэлзээтэй, сонгуулийн салбарт мэргэшсэн боловсон хүчин дутмаг, засгийн газрын бүрэлдэхүүнд орж хууль тогтоох байгууллагын сонгуулийг зохион байгуулахад дахин шинэ засгийн газар бүрэлдэхэд сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагаа, залгамж халаа тогтвортой үлдэх эсэх (засгийн газрын тэргүүн аль нам, хүчнээс байгаагаас шалтгаалан байгууллагын удирдлага байнга солигдох) нь эргэлзээтэй.

Схем 1. Сонгуулийн удирдлагын гурван загвар



(Эх сурвалж: International IDEA, Electoral Management Design)

Холимог загвар нь бүтцийн хувьд хэрэгжүүлэх болон төлөвлөж, боловсруулах хоёр хэсэгт хуваагдах тул нэгж бүр өөрийн хариуцсан ажлыг гүйцэтгэх байдлаар үр бүтээмжтэй ажиллах давуу талтай. Харин сонгуулийн үйл ажиллагааг засгийн газрын загвартай адил засгийн газрын бүтэц доторх нэгж зохион байгуулах тул иргэдийн сонгуульд итгэх итгэл сул, ажилчид нь байнга солигдож тогтвортой байдал алдагдах боломжтой сул талтай байна.

Дээрх схем 1-т⁸³ сонгуулийн төв байгууллагын гурван загвар, түүний дотоод ангиллыг харуулав. Үүнд, бие даасан загварын хувьд сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааг бусад байгууллага, төрийн институцийн оролцоо, чиглэлгүй бие даан зохион байгуулж маргаан үүссэн тохиолдолд өөрөө эсвэл сонгуулийн асуудал хариуцсан шүүхээр шийдвэрлүүлж байна. Холимог загвар нь бие даасан болон засгийн газрын бүтцийн нэгжид хамаарах хоёр хэсэгт хуваагдаж зохион байгуулалтыг хийхдээ түр зуурын шинжтэй сонгуулийн байгууллага үүсгэх, эсвэл хууль зүйн яамны харьяанд сонгуулийг зохион байгуулж байна. Засгийн газрын загварт шууд удирдлагын харьяа нэгж, бүтэц нь зохион байгуулалтын хариуцан хийх эсвэл хууль зүйн\дотоод хэргийн яам хариуцан ажилладаг байна.

IV. ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүлэл сонгуулийн төв байгууллагыг төрийн эрх мэдэл хуваарилалтын "дөрөвдөхсөлбөр" хэмээх институцийн байр сууринаас нь авч үзэж, бүтцийн болон чиг үүргийн хараат бус байдлыг сонгуулийн төв байгууллагын загвартай уялдуулан онол, ойлголтын түвшинд судаллаа. Социологийн бүтэц-функцийн онолоор (Дюркгейм, Парсонс) сонгуулийн төв байгууллага нь улс төрийн системийн тогтвортой байдал, дүрмийн мөрдөлтийг хангах "нэгдэл-дэс дарааллын" үүргийг гүйцэтгэдэг дэд систем бол; харин харьцуулсан улс төрийн институцийн хандлагаар энэ дэд системийн загвар, эрх хэмжээ, нөөц, хариуцлагын ойлголт нь сонгуулийн шударга ёс, хууль ёсны байдлыг тогтоодог гол хувьсагч байна. Ардчиллын гурав дахь давлагаа явагдсанаар сонгуулийн төв байгууллагын институцлал "боловсон бүтэц" рүү шилжиж, АСДҮОУХ-ийн ангиллаар дэлхий нийтэд бие даасан загвар давамгайл байдалтай (213 улсаас 138 буюу 64.79%), бүс

нутгийн хувьд ч ялангуяа Азид (74.47%) түгээмэл байна. Энэхүү түгээмэл байдал нь бие даасан загвар "автоматаар оновчтой" гэсэн үг бус; харин хуулиар баталгаажсан бүтэц ба практикт хэрэгжин тогтсон чиг үүргийн баталгааг хангасан үед л сонгуулийн хууль ёсны байдал, олон нийтийн итгэл тогтвортой хадгалагддаг болохын илэрхийлэл байна. Өгүүлэлд сонгуулийн удирдлагын байгууллагын гурван суурь загвар (бие даасан, засгийн газрын, холимог) болон хоёр огтлол ангилал (төвлөрсөн/төвлөрсөн бус; байнгын/түр)-ыг зэрэг авч үзэхдээ, сонгуулийн гурван багц үйл ажиллагаа (зохион байгуулах, хянах, баталгаажуулах)-г ямар институц, ямар эрх мэдлээр гүйцэтгэж буй тохиолдолд хараат бус, мэргэшсэн үйл ажиллагаа явагдах боломжтойг харьцуулан судлалаа. Үүнд:

Бие даасан загвар нь нэгдсэн удирдлага, мэргэшил, төсвийн зарцуулалт, хяналт зэргээр легитимийг (хууль ёсны байдлыг) шууд дэмждэг. Бие даасан загвар нь сонгуулийн байгууллагад нэгдсэн удирдлага, мэргэшсэн хүний нөөц, төсвийн өөрийн хяналттай ажиллах боломжийг олгож, хууль ёсны байдал ба олон нийтийн итгэлийг шууд дэмждэг ч өндөр зардал, тогтвортой бус нөөцийн эрсдэлтэй байна.

Засгийн газрын загвар нь төрийн эд хөрөнгө, дэд бүтэц, нөөц дээр тулгуурлаж сонгуулийг зардал багатай, үр ашигтай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлдэг ч улс төрийн нөлөөлөлд өртөмтгий, хараат бус байдал нь эргэлзээтэй байна.

Холимог загвар нь бодлого ба хяналтыг бие даасан байгууллагад, хэрэгжилтийг гүйцэтгэх эрх мэдэлд хуваарилснаар уян хатан зохион байгуулалт бий болгож чаддаг ч уялдаа-хариуцлагын зааг бүдгэрч, төсөв болон институцийн тогтвортой байдлын сорилт үүсдэг байна.

Сонгуулийн удирдлагын байгууллагууд шударга ёс, ил тод байдал, үр ашиг, мэргэжлийн чадвар гэсэн дөрвөн хэмжүүрийг хараат бус байдлын хэмжигдэхүүн болгон ашигласан нь байгууллагын хараат бус байдлыг хангах оновчтой сонголт бөгөөд "зарчим" бус гүйцэтгэлийн үзүүлэлт болохын хувьд дараах үнэлгээний матрицаар бодитой хэмжигдэж буйг харах боломжтой хэмээн үзэж байна. Үүнд:

1. Эрх зүйн суурь (Үндсэн хууль/органик хууль зохицуулалт бий эсэх);
2. Томилгоо-эргүүлэн татах хяналтын зохицуулалт (хэн, яаж, хэдийд);

83 International IDEA, Electoral Management Design, revised ed. (Sweden: International IDEA, 2014).

3. Эрх хэмжээний тодорхой, давхцалгүй байдал (чиг үүргийн давхцалгүй байдал);
4. Төсвийн бие даасан байдал (хуваарилалт, захиран зарцуулалт, аудит);
5. Хүний нөөцийн мэргэшил, тогтвортой байдал (байнгын хөгжил, сургалт);
6. Ил тод байдал ба нээлттэй дата (ажиглалт, санал тоолох шууд дамжуулалт, мэдээлэл түгээлт);
7. Технологийн засаглал (аюулгүй байдал, шалгалт, аудитын хяналт);
8. Маргаан шийдвэрлэлтийн хараат бус байдал (шүүх/сахилга, зөрчлийн асуудал);
9. Босоо зохион байгуулалтын уялдаа (төв-орон нутгийн эрх мэдлийн тэнцэл);
10. Сонгуулийн мөчлөгийн тасралтгүй менежмент (сонгогчийн боловсрол, архив, үнэлгээ) зэргийг анхааран үзэх нь зохимжтой байна.

Монгол Улсад хувьд Сонгуулийн төв байгууллага нь ардчиллын шилжилт хийснээс хойш 30 гаруй жилийн хугацаанд эрх мэдлийн тайван шилжилтийн суурь институц байж иржээ. Цаашид Сонгуулийн төв байгууллагын хөгжлийг суурь судалгааны хүрээнд дүгнэхэд: (i) бүтцийн хараат бус байдлыг эрх зүйн түвшинд илүү баталгаажуулах, (ii) чиг үүргийн онцгой эрхийг (зохион байгуулалт-хяналт-баталгаажуулалт) давхардуулахгүйгээр хуульчлах, (iii) төсвийн бие даасан байдлыг байгууллагын дундаж хугацааны төлөвлөлттэй уялдуулан тасралтгүй хөгжүүлэх, (iv) байнга, тасралтгүйгээр боловсрон хүчин, мэргэжилтнийг сургаж хүний нөөцийг чадавхжуулах, (v) ил тод байдлын дэд бүтцийг (нээлттэй дата, процессын шууд дамжуулалт, хараат бус аудит) хангаж ажиллах зэрэг нь нэн чухал байна. Сонгуулийн удирдлагын гурван загвараас "аль загвар хамгийн зөв бэ?" гэсэн асуултад нийтлэг, нэг мөр хариулт байхгүй. Гэвч өгүүллийн турш гарсан онол, ойлголт, улс орнуудын сонгуулийн төв байгууллагын загвар, практикаас харьцуулан дүгнэхэд:

- Сонгуулийн төв байгууллага ямар загвар (бие даасан, засгийн газрын, холимог) сонгосноос үл хамааран, түүний үйл ажиллагаа зөвхөн хууль ёсны, олон нийтийн итгэлийг хүлээсэн байж чадах эсэх нь хараат бус байдал болон хариуцлагын хоёр тулгуурыг хэрхэн зэрэг хангаж буйгаас шалтгаална.
- Хараат бус байдлыг зөвхөн хууль тогтоомжид зааж өгөх нь хангалтгүй бөгөөд үүнийг бодит байдалд хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн бие даасан байдал, тогтвортой хүний нөөц, найдвартай технологи, ил тод тайлагнал зэрэг бодит баталгаануудыг тэнцвэртэйгээр бүрдүүлэх шаардлагатай нь судалгаагаар ажиглагдаж байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

- A. Эрх зүйн эх сурвалж
1. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2006 он.
- B. Эрдэм шинжилгээний бүтээл
2. Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Сонгуулийн төв байгууллагын бүрэлдэхүүний хараат бус байдал магистрын диссертаци, 2023, УБ.

Гадаад хэл дээрх эх сурвалж

- A. Англи хэл дээр

1. ACE, "Electoral Management," aceproject.org
2. Alan Wall and Andrew Ellis, Electoral Management Design: The International IDEA Handbook, 7th ed. (Stockholm: International IDEA, 2006).
3. Alessandro Nai, The Electoral Consequences of Third-Party Mobilization: The Case of the German Pirate Party, 1st ed. (ECPR Press, 2014).
4. Carolyn van Ham and Holly Ann Garnett, "Building Impartial Electoral Management? Institutional Design, Independence and Electoral Integrity," International Political Science Review 40, no. 3 (2019).
5. Charles de Secondat, Baron de Montesquieu, The Spirit of Laws (Amherst, NY: Prometheus Books, 2002).
6. Émile Durkheim, Suicide: A Study in Sociology, 1st ed. (The Free Press, 1951).
7. Émile Durkheim, The Division of Labor in Society, 1st ed. (The Free Press, 1933).
8. Freedom House, "Country and Territory Ratings and Statuses, 1973–2024," n.d., freedomhouse.org.
9. Gabriel A. Almond and G. Bingham Powell Jr., "Structural Functional Approach," in Comparative Politics: A Developmental Approach, ed. Gabriel A. Almond and G. Bingham Powell Jr. (Little, Brown, 1966).
10. Helen Catt, Electoral Management Design, 1st ed. (International IDEA, 2014).
11. International IDEA, Electoral Management Design, revised ed. (Sweden: International IDEA, 2014).
12. Jørgen Elklit and Andrew Reynolds, "Analysing the Impact of Election Administration on Democratic Politics," Representation 38, no. 1 (2001).
13. Larry Diamond, "Is the Third Wave Over?" Journal of Democracy 7, no. 3 (1996).
14. Larry Diamond, Juan J. Linz, and Seymour Martin Lipset, Democracy in Developing Countries (4 vols.), 1st ed. (Lynne Rienner, 1988).
15. Mark Tushnet, "Institutions Protecting Democracy: A Preliminary Inquiry," Law & Ethics of Human Rights 12, no. 2 (2018).
16. Mark Tushnet, The New Fourth Branch: Institutions for Protecting Constitutional Democracy, 1st ed. (Oxford University Press, 2021), I.
17. Mohamed Musbeh, "Managing Elections: Definition and Classification of Elections Management Bodies," n.d., academia.edu
18. Ogweno Joseph, "Independence in Electoral Management," Electoral Processes Primer 1, n.d., aceproject.org
19. Pippa Norris, Bernard Grofman, and James Adams, Electoral Engineering: Voting Rules and Political Behavior, 1st ed. (Cambridge University Press, 2004).
20. Rafael López-Pintor, Electoral Management Bodies as Institutions of Governance, 1st ed. (UNDP, Bureau for Development Policy, 2000).
21. Richard W. Soudriette and Pippa Norris, Election Management Bodies: Ensuring Integrity and Independence, 1st ed. (Oxford University Press, 2014).
22. Robert A. Dahl, Political Opposition in Western Democracies, 1st ed. (Yale University Press, 1966).
23. Sarah Birch, Electoral Malpractice, 1st ed. (Oxford University Press, 2011).
24. Talcott Parsons, The Structure of Social Action, 1st ed. (The Free Press, 1937).
25. Toby S. James, "Comparative Electoral Management: Performance, Networks, and Instruments," n.d., tobysjames.com
26. Toby S. James, Holly Ann Garnett, Leontine Loeber, and Carolien van Ham, "Electoral Management and the Organizational Determinants of Electoral Integrity," International Political Science Review / Revue internationale de science politique 40, no. 3 (2019), 295–312, jstor.org.
27. Transparency International, "Election Management Bodies and Their Composition," (2013), transparency.
28. UNDP, "Electoral Management Bodies as Institutions of Governance," (2014), eods.eu.
29. Westminster Foundation for Democracy, "A New Framework for Understanding and Assessing Electoral Commission Independence," January 2022, wfd.org

“СОНГУУЛЬ-2024” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Легалдата” ХХК, “Тунгаахуй” өгөгдлийн урлантай хамтран их, дээд сургуулийн оюутан, судлаач, мэргэжлийн албан хаагчдын дунд “СОНГУУЛЬ-2024” эрдэм шинжилгээний уралдааныг 2024 оны 12 дугаар сард зарласан. Уралдаанд оюутан, судлаач, өмгөөлөгч, сэтгүүлч зэрэг 110 гаруй иргэн оролцсоноос зохион байгуулагчид 13 илтгэлийг хоёрдугаар шатанд хэлэлцүүлэх шаардлага хангасан гэж үзсэн юм.

Хоёрдугаар шатны хэлэлцүүлэгт оролцогчид Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор жөндөрийн тэгш эрхийг дэмжсэн болон бусад хуулийн зохицуулалтын үр нөлөөг тодорхой дүгнэх, Сонгуулийн процессын эрх зүйд тулгамдаж буй асуудлыг бодит тоон мэдээлэлд тулгуурлан хөндөж, сайжруулах санал боловсруулах хоёр үндсэн сэдвийн хүрээнд илтгэлээ хэлэлцүүлсэн юм.

Уралдаанд эхний гурван байрт шалгарсан илтгэлийг “Сонгуулийн боловсрол” онол, арга зүйн сэтгүүлд нийтэлж байна.

Энэ удаад Дэд байрт шалгарсан илтгэлийг Уншигч Танд хүргэж байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ НЬ

(СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД)



Судлаач **Х.Норовсүрэн**

ОРШИЛ:

Монгол Улс 1990 онд нэг намтай авторитар улс төрийн тогтолцооноос олон намтай, хүний эрхийг хүндэтгэсэн, чөлөөт ардчилсан сонгуультай, нээлттэй улс төрийн тогтолцоог сонгоод даруй 30 гаруй жил болжээ. Шинэ Үндсэн хуулийг 1992 онд баталснаас хойш жил 9 дэх удаагаа зохион байгуулсан бөгөөд энэ удаагийн сонгууль нь урьд урьдны жилүүдээс ялгаатай нь 2023 оны Монгол улсын үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу 126 гишүүн бүхий, холимог тогтолцоогоор зохион байгуулагдаж 19 нам, 2 эвсэл, 42 бие даагч иргэн буюу нийт 1341 нэр дэвшигч өрсөлдсөн. Энэ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн түүхэнд хамгийн

олон нам, эвсэл, нэр дэвшигч оролцсон сонгууль болжээ. Тодруулбал, 19 нам, хоёр эвслээс сонгуулийн тойрогт 927, жагсаалтаар 372, бие дааж 42 нэр дэвшигч бүртгүүлсэн бөгөөд нийт нэр дэвшигчдийн 61.3 хувь буюу 821 нь эрэгтэй, 520 буюу 38.7 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байв. Өөрөөр хэлбэл түүхэндээ хамгийн олон эмэгтэй гишүүд сонгогдсон сонгууль болсон бөгөөд олон улсын байгууллагууд ч энэ үзүүлэлтийг Монгол улсыг жөндөрийн тэгш байдлаар үлгэрлэсэн¹ гэж үнэлж байв.

1 Tapan Mishra: Mongolia is a Role Model for Gender Equality and Women's Empowerment (2024) <https://montsame.mn/en/read/349623>

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн ээлжит сонгуулийг зохион байгуулахад аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороо, сум, дүүргийн 339 сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комисс болон 47 салбар комисс, 2198 хэсгийн хороонд нийт 21943 төрийн албан хаагч, мэдээллийн технологийн 2763 албан хаагч, онцгой нөхцөл байдалд сонгогчдын санал авах ажилд онцгой байдлын 530 гаруй албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын 1000 гаруй ажилтан ажиллаж, сонгуулийг ажиглахаар гадаадын 21 байгууллагын 40 гаруй орны 259 ажиглагч, мөн дотоодын 30 орчим мянган ажиглагч сонгуулийн үйл явцад хяналт тавин ажиллалаа².

Нөгөөтэйгүүр урьд нь манай улсын сонгуулийн тогтолцоо тогтмол өөрчлөгдөж байсантай холбоотойгоор сонгуулийн тогтолцоонд итгэх сонгогчдын итгэл буурч, сонгуульд оролцох сонирхол багасаж байсан. Тодруулбал Монгол улс УИХ сонгуулийн тогтолцоогоо урьд нь (үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө) 7 удаа өөрчилсөн бөгөөд үүнээс 5-г нь хуулийг шинэчлэн найруулах, 2-г нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өөрчилсөн байдаг. Ингэхдээ нэг мандаттай жижиг тойргийг 4 удаа, олон мандаттай томосгососон тойргийг 3 удаа, холимог тогтолцоог 1 удаа ашиглаж байжээ³. Харин Монгол Улсын иргэдээсээ санал авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд Монгол Улсын сонгуулийн түүхэнд гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийн сонгуулийн идэвх, оролцоо нэмэгдэж саналаа өгөхөөр бүртгүүлсэн нийт сонгогчийн 73.2 хувь нь сонгуульд оролцсон байна⁴.

Ийнхүү үндсэн хуульдаа сонгуулийн тогтолцоог хуульчилснаар УИХ сонгуульд ялсан нам сонгуулийн тогтолцоог өөрчлөх боломжийг хааж, сонгуулийн тогтолцоог илүү тогтвортой болгох алхам болсон бөгөөд энэ удаагийн сонгуульд 5 нам, эвсэл болон нийгмийн олон бүлгийн төлөөлөл бүхий парламент бий болжээ.

ЗОРИЛГО:

Хэдийгээр үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд олон сайн үр дүн гарсан хэдий ч сонгуулийн явцад засаж, сайжруулах шаардлагатай хэд хэдэн асуудал тулгарсан. Иймд энэхүү өгүүлэлд УИХ сонгуулийн явцад гарсан сонгуулийн тухай хууль зөрчсөн эсэх хэрэг маргаанд Сонгуулийн төв байгууллага оролцох боломжтой эсэх, хэрхэн оролцох, сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн сайжруулах зэрэг асуудлыг хөндөх бөгөөд онолын, дотоодын хууль тогтоомжийн болон гадаад улсуудын хууль тогтоомжийг харьцуулан судлах аргаар дээрх асуултуудад санал, дүгнэлт өгөх зорилготой.

ҮНДЭСЛЭЛ:

ОНОЛЫН СУДАЛГАА

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21-р зүйлийн 1-т "Everyone has the right to take part in the government of his country, directly or through freely chosen representatives."⁵ буюу "Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө дамжуулан оролцох эрхтэй." гэж заасан.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын тайлбарласнаар "Хэдийгээр Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21 дүгээр зүйлд ардчилал гэдэг үг үсэг ороогүй ч ардчиллын зарим үндсэн зарчмуудыг тодорхойлсон байдаг төдийгүй бүх нийтийн, нууц санал хураалт бүхий, тогтмол цаг хугацааны давтамжтай сонгууль явуулах шаардлагыг агуулдаг" гэж заасан⁶.

Эндээс сонгуулийн суурь зарчмууд урган гарна. Үүнд:

1. Сонгууль бүх нийтийн байх зарчим: Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.
2. Тэгш эрхийн зарчим: Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй, санал бүр ижил жинтэй байх тухай ойлголт юм. Сонгогчийн гарал үүсэл, шашин шүтлэг бусад хүчин зүйлсээс үл хамааран сонгогчдын санал адилхан тоологдох ёстой.
3. Шууд оролцох эрхийн зарчим: Сонгогч саналаа ямар нэгэн төлөөлөлгүйгээр зөвхөн өөрөө биечлэн өгнө. Харин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр саналын хуудсыг бөглөж чадахгүй бол сонгуулийн хуульд заасны дагуу өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.
4. Саналаа нууцаар гаргах зарчим: Сонгогч хэнд саналаа өгөхийг өөрөөс нь өөр хэн ч мэдэх ёсгүй. Саналын нууцлалыг сонгууль зохион байгуулж буй сонгуулийн байгууллага хариуцаж, нууцлалыг хангадаг.
5. Чөлөөтэй сонгох зарчим: Сонгогч сонгуульд оролцож саналаа өгөх эсэхээ, сонгох, сонгогдох эсэхээ өөрөө шийдвэрлэнэ. Сонгуульд нэр дэвших, сонгох эрхийг албадан эдлүүлэх ёсгүй. Сонгогчийн сонголтод хөндлөнгөөс нөлөөлөх, дарамт шахалт учруулахыг хуулиар хориглодог⁷.

Олон улсын түвшинд иргэний сонгох эрхийг наймаалцах, түүнд шан харамж өгөх зэргийг voter/ballot fraud⁸ буюу сонгуулийн луйвар гэж нэрлэдэг бөгөөд сонгуулийн хууль тогтоомж нь иргэнийг айдас, түгшүүр, аливаа хэлбэрээр

2 Сонгуулийн ерөнхий хороо "Талархал" <https://m-election.mn/wp/talarhal/>

3 Э.Гэрэлт-Од, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Судалгааны тайлангийн төсөл" (2021) хуудас 126.

4 Монгол улсын их хурал, "Ес дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Их Хурал /2024-2028 он/" <https://www.parliament.mn/nn/62973/>

5 Universal Declaration of Human Rights (1948)

6 Office of the United Nations High Commissioner for Human Rights, Universal Declaration of Human Rights at 70: 30 Articles on 30 Articles - Article 21

7 Сонгуулийн ерөнхий хороо, Сонгуулийн боловсрол мэдээ, мэдээллийн товхимол (2022)

8 FBI, "Election crimes" <https://www.fbi.gov/investigate/public-corruption/election-crimes>

саналыг нь худалдаж авах зэрэг нөлөөллөөс ангид байдлаар чөлөөтэй сонголтоо хийх боломжоор хангах зорилготой байдаг⁹. Энэ нь шударга сонгууль, түүний эрх зүй, ёс суртахууны үндсийг санаатайгаар эвдэн бусниулах замаар засгийн эрх мэдлийг авахын төлөө зохион байгуулалттай гэмт хэрэг мөн гэж зарим үндсэн хуулийн судлаачид цохон тэмдэглэсэн байдаг¹⁰.

Харин сонгуулийн хууль зөрчсөн зөрчлийг улс орон бүр харилцан адилгүй байдлаар авч үздэг бөгөөд ардчилал өндөр хөгжсөн Франц, Герман, Англи зэрэг улсуудын хувьд сонгуулийн хэрэг маргааныг ердийн захиргааны журмаар тусгай процессоор шийдвэрлэдэг. Эсрэгээрээ ардчилал хөгжиж буй улс орнуудын хувьд сонгуулийн хороо болон ердийн шүүхээр хэргийг шийдвэрлэдэг аж¹¹.

ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН СУДАЛГАА

Монгол улсын үндсэн хуульд цөөн тооны институциудыг хуульчилсан бөгөөд эдгээр байгууллагууд нь үндсэн хуулийн биелэлтийг хангах онцгой чиг үүрэгтэй юм. Үүний нэг нь сонгуулийн төв байгууллага бөгөөд Монгол улсын үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2.2-т тус байгууллагын шийдвэр нь үндсэн хуулийн цэцийн хяналтын объект байхаар тусгагдсан¹². Энэхүү үндсэн хуулийн байгууллага нь хэд хэдэн тусгай хуулиудаар холбогдох харилцааг зохицуулсан бөгөөд үүний нэг нь 2019 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хууль юм.

Энэ хуулийн нэгэн онцлог зохицуулалт бол сонгуулийн сурталчилгааны хэлбэр, цаг хугацааг нарийвчлан зааж өгсөн явдал юм. Тодруулбал Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа, 39.2-т сурталчилгаа хийх хэлбэрийг тус тус хуульчилсан. Ингэхдээ хуулийн 39.2-т 8 төрлийн сонгуулийн сурталчилгааны хэлбэрийг зөвшөөрсөн ба үүнээс бусад хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх нь хуулийн 48.5, 75.2-т заасан нэр дэвшигчийг хасах үр дагаврыг үүсгэдэг¹³.

Өнөөгийн манай улсын УИХ сонгуулийн хууль эрх зүйн зохицуулалтад сонгуулийн төв байгууллага нь аливаа хэлбэрээр сонгуулийн хууль, тогтоомж зөрчсөн асуудалд үнэлэлт, дүгнэлт хийдэггүй бөгөөд холбогдох байгууллагууд нь ч сонгуулийн төв байгууллагад мэдээлэл өгөх үүрэг байдаггүй. Тодруулбал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд зөрчлийн харьяаллыг хуульчилсан байх бөгөөд сонгуулийн төв байгууллага нь зөвхөн Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улс төрийн намын тухай хуульд заасан зөрчлийг шалган

шийдвэрлэхээр заасан¹⁴.

Харин Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т заасан Сонгуулийн тухай хууль зөрчих зөрчлүүдийг татварын улсын байцаагч, ШӨХТГ-ын улсын байцаагч, Монголбанкны хянан шалгагч, улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч, тагнуул, цагдаагийн байгууллага харьяалан шалгах аар зохицуулагдсан. Энэхүү зохицуулалтын талаар зарим судлаачид " ... сонгуулийн хууль зөрчсөн нам, эвсэл, нэр дэвшигчдэд хариуцлага тооцох талаар хуульд заасан ч бодит байдалд хэрэгжихгүй байна" гэж үзсэн¹⁵.

Судлаач миний хувьд ч сонгуулийн хууль тогтоомж бодит байдал дээр бүрэн гүйцэд хэрэгжихгүй байна гэж үзэж байна. Тухайлбал, 2024 оны ээлжит УИХ сонгуулийн явцад хэд хэдэн нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хууль бус сурталчилгаа байсан байж болзошгүй байна. Харамсалтай нь тухайн нөхцөл байдалтай холбогдуулан аливаа хэлбэрээр зөрчлийн хэрэг үүсгэж, нэр дэвшигчийг хасах зэрэг хариуцлага хүлээлгээгүй юм.

Жишээ 1.

УИХ сонгуульд Сонгинохайрхан дүүрэгт нэр дэвшигч Ч.Н нь сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө өөрийн үйл ажиллагааны тайланг хэвлүүлж тараасан нь олон нийтэд ил болсон¹⁶.

Жишээ 2.

УИХ сонгуулийн сурталчилгааны сүүлийн өдөр иргэн С болон бусад фэйсбүүк хаягаас "А нам ялвал хүн бүрийн 10 хүртлэх сая төгрөгийн хэрэглээний зээлийг тэглэнэ." гэсэн пост оруулж, иргэд рүү энэ мэдээллийг түгээж дуудлага хийсэн бөгөөд энэ талаарх мэдээлэл мөн олон нийтэд ил болсон¹⁷.

Дээрх үйлдлүүд нь угтаа сонгуулийн сурталчилгааны бус хугацаанд сурталчилгаа хийсэн, мөрийн хөтөлбөрт тусгаадаггүй амлалт өгсөн агуулгатай байх тул аль аль нь нэр дэвшигчийг хасах хүртэлх хариуцлага ногдуулах хуулийн зохицуулалттай. Гэвч эдгээр асуудлаар гомдол гаргасан эсэхийг сонгуулийн төв байгууллагад мэдээлэл хүргэх үүрэг тухайн зөрчлийг шалган шийдвэрлэж буй байгууллагуудад байхгүй, тухайн байгууллагууд нь сонгуулийн хэрэг маргаан шийдвэрлэх чиглэлээр дагнан мэргэшээгүй, мөн сонгуулийн

9 IDEA "International Electoral Standards Guidelines for reviewing the legal framework of elections" (2002) p.57 <https://www.idea.int/sites/default/files/publications/international-electoral-standards-guidelines-for-reviewing-the-legal-framework-of-elections.pdf>

10 Б.Чимид "Сонгуулийн булхайг Үндсэн хуулиар хаацайлж болохгүй" <https://itoim.mn/article/V5eCA/25400>

11 European commission for democracy through law (2013) p.138 https://www.eod.eu/library/VC.Electoral%20Law_EN.pdf

12 Монгол улсын үндсэн хууль (1992)

13 Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хууль (2019)

14 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8.6.63 дахь заалт (2017)

15 Политологи XVIII Эрдэм шинжилгээний бичиг No18(534) Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр "Монгол улсын сонгуулийн хуулийн өөрчлөлт: хэрэгжилт, боловсронгуй болгох асуудалд" (2020) 114-р тал <https://journal.num.edu.mn/ps/article/view/2460/2177>

16 "Намууд Ч.Номинг Сонгуулийн тухай хууль зөрчсөн гэв" (2024) <https://news.mn/r/2722937/>

17 Сайнаа Сайнаа "Ардчилсан нам ялвал хүн бүрийн 10 хүртлэх сая төгрөгийн хэрэглээний зээлийг тэглэнэ." (2024 оны 6 сарын 26) https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid026YDvMYETvZ4JYn5NHT4WuFzst57PQskSAmXBmBZqw9wgKaMfV78sFK6ZBj7N3Jl&id=100032800370697

төв байгууллага зөрчил байж болзошгүй хэргээр хяналт шалгалт хийх, мэдээлэл гаргуулах, тодруулга авах зэрэг эрхгүй, сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиг үүрэггүй байгаа нь эдгээр зөрчил гарах суурь шалтгаан болж байна гэж харж байна.

Нөгөөтэйгүүр УИХ сонгуулийн хувьд орон нутгийн сонгуулиас ялгаатай нь нэгэнт УИХ гишүүнээр сонгогдсон иргэнийг сонгуулийн хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр эгүүлэн татах хуулийн процесс бараг боломжгүй. Өөрөөр хэлбэл иргэдийн төлөөлөгчөөс ялгаатай нь УИХ гишүүн нь гишүүний тангаргаа өргөмөгц бүрэн эрх, халдашгүй байдалтай болдог тул хуульд заасан цөөн үндэслэлээр түүнийг эгүүлэх татах нөхцөл боломж бүрддэг. Энэ нь сонгуулийн хуулийн биелэлтийг хангахгүй байх, түүнийг зөрчих асуудлыг өөгшүүлэх хүчин зүйл болж байна.

ГАДААД УЛСУУДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН СУДАЛГАА

1. Их Британи улсын жишээ

Онолын хэсэгт дурдсанчлан манай улсын хувьд Их Британи улстай ижил төстэй арга хэлбэрээр сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэдэг байх тул тус улсыг харьцуулсан судалгааны объект болгон сонгож авлаа. Их Британи улс Political Parties Elections and Referendums Act (PPERA) буюу Улс төрийн намуудын сонгууль, бүх нийтийн санал асуулгын тухай хуулийг 2000 онд баталж, хуулийн 146-р хэсэгт "Investigation powers of Commission" буюу Хорооны шалгалтын бүрэн эрхийг хуульчилсан. Ингэхдээ сонгуулийн хороо нь шаардлагатай баримт материал гаргуулах, түүнд тайлбар авах, тухайн мэдээлэл бүхий материалыг хуулбарлан авах, баримт бичиг болон бусад цаасан, цахим материалуудад үзлэг шалгалт хийх, үндэслэлгүйгээр хуульд заасан шаардлагад нийцээгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд түүнийг нийцүүлэх арга хэмжээ авах зэрэг бүрэн эрхтэй байна¹⁸. Цаашлаад хавсралт 19 Б-д зааснаар хорооноос тухайн этгээдийг хууль зөрчсөн гэж үзсэн бол түүний талаарх мэдээллийг гаргуулах талаарх захирамжийг шүүхээс гаргадаг байна.

Ийнхүү тус улсын сонгуулийн хороо нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг бөгөөд ингэснээрээ иргэд сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүжилтэд санаа зоволтгүй чөлөөтэй сонгох эрхээ эдлэх боломжтой болдог байна. Түүнчлэн цагдаагийн зүгээс зарим мөрдөн шалгах ажиллагааг хийдэг бөгөөд голцуу гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдэд зохих арга хэмжээг авах үүднээс сонгуулийн хороо хамтарч ажилладаг. Мөн тус хороо нь нотлох баримт цуглуулахдаа иргэдээс сайн дураар нь мэдээлэл өгөхийг асуух, гэрч, сэжигтэнтэй ярилцлага хийх зэрэг олон арга хэлбэр ашигладаг аж¹⁹.

Түүнчлэн зөвхөн сонгуулийн хорооны үйл ажиллагаанаас

гадна Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас (OSCE) сонгуулийн маргааныг шийдвэрлэх, хэрэг маргаан шийдвэрлэхэд оролцож буй бусад албан тушаалтнуудыг чадавхижуулах чиглэлээр ерөнхий удирдамж (Generic Guidelines for Election Dispute Resolution)-ийг гаргасан бөгөөд үүний С хэсэгт Accessibility and transparency буюу Хүртээмжтэй, ил тод байдал хэсэгт

"13. Гомдол гаргах журам нь ил тод, ойлгомжтой байх ёстой.

14. Сонгуультай холбоотой үүрэг хүлээсэн хүмүүсийг тухайн улсын сонгуулийн хууль, олон улсын жишигт нийцүүлэн сонгуулийн маргааны дүрэм, журмын дагуу сургах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

15. Гомдол гаргах журам нь шаардлагагүй саад бэрхшээл, ялангуяа шүүхэд нэхэмжлэл гаргах зардалтай холбоотой зардлаас чөлөөлөгдсөн байх ёстой."²⁰ гэж заасан байдаг.

2. Бүгд Найрамдах Солонгос улсын жишээ

Харьцуулсан судалгаа хийх дараагийн улсаар Азидаа ардчиллын үзүүлэлтээр тэргүүлдэг БНСУ-ын сонгуулийн хороог сонгож авлаа. Их Британи улстай адил БНСУ-ын сонгуулийн хороо ч бас сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчил гаргах, сонгуулийн тэгш байдалд аюул учруулахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлдэг. Ингэхдээ сонирхолтой нь Сонгуулийн хяналтын алба гэх сонгуулийн хууль зөрчсөн үйл ажиллагаанд хяналт тавих сайн дурынхан болон бусад иргэд, бүлгүүдийг оролцуулдаг бөгөөд томоохон хотуудад сонгуулийг саадгүй явуулах зорилгоор энэхүү албыг байгуулдаг. Мөн сонгуулийн хороо нь цахим хэлбэрээр ч сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг онцлогтой байна. Цаашлаад хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс сонгуулийн хороо нь сонгуулийн хууль зөрчигчдөд сануулах, залруулга хийх, торгууль ногдуулах зэрэг арга хэмжээг ч авдаг бөгөөд сонгуулийн хорооноос авсан арга хэмжээг биелүүлэхгүй байгаа тохиолдолд тэднийг албан ёсоор шийтгүүлэх хүсэлтийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлдэг байна.

Ингэхдээ тус улсын сонгуулийн хороо нь ил тод, нээлттэй, бодлогод суурилсан байдлаар сонгуулийг явуулах талаар ихээхэн нөлөөллийн арга хэмжээ хийдэг бөгөөд улс төрийн бодлого үйл ажиллагаагаа танилцуулах, хэлэлцүүлэг хийх замаар сонгогчдод нэр дэвшигч нарыг харьцуулах, тэдгээрийн улс төрийн үзэл баримтлалыг таниулах боломжоор хангадаг. Түүгээр ч зогсохгүй тус улсын сонгуулийн хороо нь Азийн сонгуулийн байгууллагуудын холбоонд элсэж, 2008 онд дэд даргаар сонгогдож тус холбооны ерөнхий ассамблейг 2011 онд зохион байгуулж, гадаад улсуудтай туршлага солилцох арга хэмжээ хийдэг байна. Цаашлаад хуульд өөрчлөлт оруулах санал ч боловсруулах эрхтэй байдаг аж²¹.

18 Political Parties Elections and Referendums Act (2000) <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/contents>

19 UK electoral commission "How investigations work" <https://www.electoralcommission.org.uk/political-registration-and-regulation/our-enforcement-work/investigations/how-investigations-work>

20 OSCE "Resolving Election Disputes in the OSCE Area: Towards a Standard Election Dispute Monitoring System" (2000) p.10-11 https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf?fbclid=IwZXh0bGhZWOCTAAAR3OysOxRRkQauPHMOFpH7z42uZ_5wkGmNyFAKjuDS3bkAylZGsmN6cmUz8_aem_wp3uK2262BkALEw-I13MfQ

21 National election commission of the Republic of Korea "NEC duties and overview" <https://www.nec.go.kr/site/eng/01/101010400000020070611.jsp>

ДҮГНЭЛТ:

Манай улсын хувьд өнгөрөгч оныг хүртэл сонгуулийн тогтолцоог нэг мөр болгоогүй байсан тул голцуу аль сонгуулийн тогтолцоо, хэдэн гишүүнтэй байх зэргийн талаар олон судалгаа хийгдсэн боловч сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, хуулийн хэрэгжилтийг хэрхэн сайжруулах зэрэг талаарх судалгаанууд харьцангуй цөөн байлаа.

126 гишүүнтэй холимог тогтолцоогоор анх удаа сонгууль явуулсны үр дүнд сонгуулийн тогтолцооны хувьд тогтвортой болох, сонгогчдын ирц нэмэгдэх зэрэг сайн талууд байсан боловч сонгуулийн хууль тогтоомж олон нийтийн нүдэн дээр зөрчигдөж, энэ талаар сонгуулийн төв байгууллага тодорхой арга хэмжээ авах бүрэн эрхгүй байв.

Харин гадаадын улс орнуудаас манайхтай ижил байдлаар сонгуулийн маргаанаа шийдвэрлэдэг процесстэй Их Британи болон ардчиллын үзүүлэлтээр Азидаа тэргүүлэгч БНСУ-г харьцуулан авч үзэхэд аль аль нь сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиг үүргийг сонгуулийн хороо нь хэрэгжүүлдэг бөгөөд сонгуулийн хууль зөрчсөн эсэхэд аливаа этгээдийн гомдол, саналгүйгээр ч бие даан хяналт тавих эрх хэмжээтэй байна. Цаашлаад холбогдох төрийн байгууллагуудыг сонгуулийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чиглэлээр сургаж мэргэшүүлэх, олон нийтийг сонгуулийн хяналтын механизмын нэг хэсэг болгох, цахим орчинд ч сонгуулийн хууль тогтоомж дагаж мөрдөх нөхцөл боломжийг бүрдүүлжээ.

Энэхүү судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Дээрх улсуудын жишгээр сонгуулийн төв байгууллага нь сонгуулийн хуулийн биелэлтийг хангаж иргэд шударга, чөлөөт сонгуульд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх үүрэг ногдуулах.
2. Сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хууль зөрчсөн байж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг өөрийн санаачлагаар шалгах, холбогдох мэдээллийг гаргуулах эрх олгох.
3. Зөрчил, гэмт хэрэг шалган шийдвэрлэж буй эрх бүхий этгээдүүд нь тухайн гомдол, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээллийг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх үүрэг ногдуулах.
4. Сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг цахим орчинд ч хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх.
5. Иргэд, иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн зөрчлийн мэдээлэл бүрийг бүртгэж авах.
6. Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудад сонгуулийн хууль тогтоомжийг таниулах, цаашлаад зөрчил гаргаж байгаа эсэхэд хяналт тавиулах байдлаар хамтран ажиллаж иргэдийг шударга, чөлөөт сонгуулийн үнэ цэнэ, ач холбогдлыг таниулах.

ЭХ СУРВАЛЖ:

Монгол эх сурвалж

1. Монгол улсын үндсэн хууль (1992)
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)
3. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хууль (2019)
4. Э.Гэрэлт-Од, "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Судалгааны тайлангийн төсөл" (2021)
5. Б.Чимид "Сонгуулийн булхайг Үндсэн хуулиар хаацайлж болохгүй" <https://itoim.mn/article/V5eCA/25400>
6. Политологи XVIII Эрдэм шинжилгээний бичиг No18 (534) Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр "Монгол улсын сонгуулийн хуулийн өөрчлөлт: хэрэгжилт, боловсронгуй болгох асуудалд" (2020) 114-р тал <https://journal.num.edu.mn/ps/article/view/2460/2177>
7. Сонгуулийн ерөнхий хороо, Сонгуулийн боловсрол мэдээ, мэдээллийн товхимол (2022)
8. Сонгуулийн ерөнхий хороо "Талархал" (2024) <https://m-election.mn/wp/talarhal/>
9. Монгол улсын их хурал, "Ес дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Монгол Улсын Их Хурал /2024-2028 он/" (2024) <https://www.parliament.mn/nn/62973/>
10. "Намууд Ч.Номинг Сонгуулийн тухай хууль зөрчсөн гэв" (2024) <https://news.mn/r/2722937/>
11. Сайнаа Сайнаа "Ардчилсан нам ялвал хүн бүрийн 10 хүртлэх сая төгрөгийн хэрэглээний зээлийг тэглэнэ." (2024 оны 6 сарын 26) https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid026YDvMYETvZ4JYn5NHT4WuFzst57PQskSAMXBmiBZqw9wgKaMFOv78sFK6ZBj7N3JI&id=100032800370697

Гадаад эх сурвалж

1. Universal Declaration of Human Rights (1948)
2. Political Parties Elections and Referendums Act (2000) <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/41/contents>
3. Office of the United Nations High Commissioner for Human Rights, Universal Declaration of Human Rights at 70: 30 Articles on 30 Articles - Article 21
4. FBI, "Election crimes" <https://www.fbi.gov/investigate/public-corruption/election-crimes>
5. IDEA "International Electoral Standards Guidelines for reviewing the legal framework of elections" (2002) p.57 <https://www.idea.int/sites/default/files/publications/international-electoral-standards-guidelines-for-reviewing-the-legal-framework-of-elections.pdf>
6. European commission for democracy through law (2013) https://www.eods.eu/library/VC.Electoral%20Law_EN.pdf
7. UK electoral commission "How investigations work" <https://www.electoralcommission.org.uk/political-registration-and-regulation/our-enforcement-work/investigations/how-investigations-work>
8. OSCE "Resolving Election Disputes in the OSCE Area: Towards a Standard Election Dispute Monitoring System" (2000) https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf?fbclid=IwZxh0bgNhZW0CMtAAAR30ysOxRRkQauPHMOFPH7z42uZ_5wkGmNyFAKjuDS3bkAyZGsmN6cmUz8_aem_wp3uK2262BkALew-I13MfQ
9. National election commission of the Republic of Korea "NEC duties and overview" <https://www.nec.go.kr/site/eng/01/10101040000002020070611.jsp>
10. Tapan Mishra: Mongolia is a Role Model for Gender Equality and Women's Empowerment (2024) <https://montsame.mn/en/read/349623>



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ




АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН 61 МАНДАТЫН ТӨЛӨӨ 121 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДЛӨӨ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн орон гарсан суудлыг нөхөх жил бүр нөхөн сонгууль зохион байгуулдаг. Ээлжит сонгуулийн дараа сонгогдсон төлөөлөгчийн бүрэн эрх хуульд заасан үндэслэлээр дуусгавар болсон бол заавал нөхөх нь ардчиллын зарчим. Өөрөөр хэлбэл, Хурлын Төлөөлөгчийн суудал эзгүйрсэн тойрог, мандатад нөхөн сонгууль явуулдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн санал хураалт 2025 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатарын цагаар 07.00-20.00 цагт боллоо.

Энэ жилийн тухайд Баянхонгор, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тус бүр нэг, 18 аймгийн 52 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 61 мандатад 121 нэр дэвшигч өрсөлдсөн юм. Тодруулбал, Баянхонгор, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тус бүр нэг, 18 аймгийн 52 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын



61 мандатад Монгол Ардын Нам (МАН)-аас 58, Ардчилсан нам (АН)-аас 49, ХҮН намаас 3, Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-аас 2, бие даан нэр дэвшигч 9 хүн өрсөлдөв.

Нөхөн сонгуулиар зөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санар авах хүсэлт гаргасан 386 сонгогчийн 97.2 хувь нь саналаа өгсөн бол нийт сонгогчийн ирц 40 хувьтай байв. Тодруулбал, Увс аймгийн Баруунтуруун сум (69.1 хувь), Өмнөговь аймгийн Ноён сум (63.5), Сүхбаатар аймгийн Халзан сум (60.2 хувь)-ын сонгогчдын ирц өндөр байлаа. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэг мандатад сонгогчдын санал тэнцсэн тул 2025 оны 6 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт санал хураалт явуулсан юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу аймаг, сумын сонгуулийн хороод тухайн шатны сонгуулийн дүнг нэгтгэж, нийтэд албан ёсоор мэдээлсэн. Түүнчлэн сонгуулийн санал хураалтын явц, сонгогчдын ирцийг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн адил дэлгэцээр шууд дамжуулж, урьдчилсан дүнг Сонгуулийн ерөнхий хороо <https://www.e-election.mn> сонгуулийн мэдээллийн цахим системээр нэгтгэж, санал хураалт дууссан даруйд <https://m-election.mn> сайтад байршуулсан нь шинэлэг байсан талаар олон нийт онцолсон.

2025 оны нөхөн сонгуулиар аймаг, сумын сонгуулийн хороо болон хэсгийн хороонд нийт 966, мэдээллийн технологийн багт 180, нийт 1146 төрийн албан хаагч сонгогчдын сонгох эрхийг ханган ажиллалаа.

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛИЙН ДҮНГЭЭР СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧ

№	Аймаг	Сум	Сонгогдсон төлөөлөгчийн мэдээлэл					
			Мандатын тоо	Нам, эвсэл, бие даагч	Овог	Нэр	Нас	Хүйс
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал								
1	Баянхонгор	Баянлиг	1	АН	Жамц	Хүрэлбаатар	58	эр
2	Дархан-Уул	Шарын Гол	1	МАН	Лүндэг	Наранбаатар	45	эр
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал								
1	Булган	Рашаант	1	МАН	Алтангэрэл	МӨНХ-ЭРДЭНЭ	38	эр
2	Булган	Сайхан	1	МАН	Лхагвасүрэн	МӨНХЗУЛ	49	эр
3	Булган	Хишиг-Өндөр	1	АН	Чаатар	ТУЯАЦЭЦЭГ	49	эм
4	Булган	Хутаг-Өндөр	1	МАН	Түмэндэмбэрэл	АМАРБАЯР	38	эр
5	Булган	Хутаг-Өндөр	1	МАН	Хашхүү	ОТГОНБАЯР	32	эр
6	Булган	Баян-Агт	1	АН	Далхжав	ГАНБАТ	45	эр
7	Булган	Бугат	1	АН	Баасандамба	ЛХАГВАЖАРГАЛ	41	эм
8	Булган	Бүрэгхангай	1	АН	Наранцогт	ӨСӨХБАЯР	28	эр
9	Булган	Гурван Булаг	1	МАН	Ишдорж	ОЮУНЧИМЭГ	60	эм
10	Булган	Дашинчилэн	1	АН	Баянмөнх	МӨНХСАЙХАН	40	эр
11	Булган	Орхон	1	АН	Алтанцэцэг	ДАВААЦОГЗОЛ	40	эм
12	Говь-Алтай	Эрдэнэ	1	АН	Гомбосүрэн	БЯМБАЧУЛУУН	61	эр
13	Говь-Алтай	Бугат	1	МАН	Довчинсүрэн	НАРАНЧИМЭГ	49	эм
14	Говьсүмбэр	Шивээговь	1	МАН	Батчулуун	БАЯРАА	42	эр
15	Дархан-Уул	Шарын Гол	1	МАН	Энхбаяр	ХАЛИУН	44	эм
16	Дархан-Уул	Шарын Гол	1	МАН	Мишитхан	СЕРКБОЛД	40	эр
17	Дорноговь	Сайхандулаан	1	АН	Сэсээр	НАРАНБАЯР	43	эр
18	Дорноговь	Айраг	1	МАН	Цогтбаатар	МӨНХБАЯСГАЛАН	36	эм
19	Дорноговь	Дэлгэрэх	1	МАН	Ганбаатар	УРАНЦЭЦЭГ	41	эм
20	Дорнод	Хөлөнбуйр	1	Бие даагч	Жаргал	МӨНГӨНДУУЛГА	49	эр
21	Дорнод	Баяндун	1	АН	Базарсад	ДОРЖНЯМ	46	эр
22	Дорнод	Баяндун	1	АН	Гарамсад	БАТТӨМӨР	54	эр
23	Дундговь	Өлзийт	1	АН	Чулуу	ЭРХЭМБАЯР	45	эр
24	Дундговь	Сайхан-Овоо	1	АН	Цогдорж	БҮДСҮРЭН	35	эм
25	Дундговь	Адаацаг	1	МАН	Адилбиш	ЦОЛМОНБААТАР	35	эр
26	Орхон	Баян-Өндөр	1	МАН	Болдбаатар	БЯМБАГЭРЭЛ	37	эр
27	Сэлэнгэ	Сүхбаатар	1	АН	Балжир	ПҮРЭВСҮРЭН	54	эм
28	Сэлэнгэ	Орхонтуул	1	АН	Батсүх	СҮХБОЛД	37	эр
29	Сэлэнгэ	Орхонтуул	1	АН	Цэдэв	НОРДОГ	51	эр
30	Сэлэнгэ	Сайхан	1	МАН	Цагаанбанди	ГАНЦЭЦЭГ	54	эм
31	Сэлэнгэ	Сайхан	1	АН	Жаргалсайхан	ӨЛЗИЙЖАРГАЛ	33	эр
32	Сэлэнгэ	Сайхан	1	АН	Дашдэмбэрэл	ДОЛЖИН	30	эм
33	Сэлэнгэ	Шаамар	1	МАН	Сүхбаатар	МЯГМАРТОГТОХ	40	эр
34	Сэлэнгэ	Алтанбулаг	1	Бие даагч	Хуягбаатар	МӨНХСАРНАЙ	41	эм
35	Сэлэнгэ	Алтанбулаг	1	МАН	Нэргүй	АРИУНЖАРГАЛ	34	эр
36	Сэлэнгэ	Баруунбүрэн	1	МАН	Мягмар	ЭЛДЭВ-ОЧИР	57	эр
37	Сэлэнгэ	Жавхлант	1	МАН	Гунахүү	НОМИНЗУЛ	33	эм
38	Сүхбаатар	Халзан	1	МАН	Бат-Өлзий	ГУАЦЭЦЭГ	51	эм
39	Төв	Заамар	1	МАН	Чулуунбаатар	БАЯНДАЛАЙ	41	эр
40	Төв	Лүн	1	МАН	Батмөнх	ОЮУНТУЯА	44	эм
41	Төв	Өндөрширээт	1	МАН	Сайнбилэг	БАТМӨНХ	34	эр
42	Төв	Угтаалцайдам	1	МАН	Сундуй	УРАНТОГОС	54	эм
43	Төв	Эрдэнэ	1	Бие даагч	Алтанпагам	ЗОЛЗАЯА	35	эр
44	Төв	Эрдэнэсант	1	МАН	Батнов	МӨНХБИЛЭГТЭЙ	30	эр
45	Төв	Эрдэнэсант	1	МАН	Тогоохүү	МӨНХЗОРИГ	49	эм
46	Увс	Баруунтуруун	1	МАН	Дашням	ЭРДЭНЭГЭРЭЛ	36	эм
47	Ховд	Мянгад	1	МАН	Нямгэрэл	БАТБОЛД	33	эр
48	Ховд	Дарви	1	МАН	Батчулуун	ГАНЗОРИГ	41	эр
49	Ховд	Манхан	1	АН	Батхүү	ЖАРГАЛМАА	43	эм
50	Хэнтий	Дархан	1	МАН	Оюунцэцэг	ЗОЛЖАРГАЛ	33	эр
51	Хэнтий	Дэлгэрхаан	1	МАН	Юра	БАТБАЯР	36	эр
52	Хэнтий	Норовлин	1	АН	Мөрөнбаяр	НЯМ-ЭРДЭНЭ	28	эр
53	Хэнтий	Бор-Өндөр	1	МАН	Санчир	УГТАХБАЯР	50	эр
54	Хэнтий	Бор-Өндөр	1	МАН	Базар	ОЮУН-ЭРДЭНЭ	39	эм
55	Хэнтий	Батноров	1	АН	Намжил	НАРАНЦЭЦЭГ	47	эм
56	Хэнтий	Батширээт	1	МАН	Гомбодорж	ГАНСҮХ	33	эр
57	Хөвсгөл	Ханх	1	МАН	Оюун	ЭРДЭНЭБАЯР	28	эр
58	Хөвсгөл	Цагаан-Үүр	1	Бие даагч	Даваасамбуу	БОЛОР-ЭРДЭНЭ	34	эм
59	Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	1	АН	Амгалан	БАТ-УНДРАХ	25	эр
60	Өвөрхангай	Нарийнтээл	1	АН	Санлигринчин	ХҮРЭЛБАТ	34	эр
61	Өмнөговь	Ноён	1	АН	Манхvv	ЧУЛУУНХҮҮ	51	эр

МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СУРГАЛТЫН ТӨВ

Д.АЛТАНШАГАЙ:

ОРОН НУТАГТ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН БАЙНГЫН ТӨЛӨӨЛӨЛ БИЙ БОЛГОХ ХЭРЭГТЭЙ



Булган аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Д.Алтаншагайтай ярилцлаа. Тэрбээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулиар Булган аймгийн сонгуулийн хорооны даргаар ажилласан юм.

-Энэ жилийн тухайд танай аймгийн 10 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 мандатад нөхөн сонгууль боллоо. Энэ жилийн сонгуулийн зохион байгуулалтын онцлог юу байв?

-Булган аймгийн хэмжээнд хуулийн өөрчлөлтөөс шалтгаалаад 10 суманд 11 мандатад нөхөн сонгууль зохион байгууллаа. Хуулийн өөрчлөлт гэдэг нь хоёр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зэрэг нэр дэвшиж сонгогдсон бол аль нэг буюу аймгийн иргэдийн хурлын төлөөлөгч, сумын иргэдийн хурлын төлөөлөгчийн аль нэгийгээ сонгож давхар төлөөлөл бий болгохгүйгээр хүсэлт өгч татгалзсан асуудал. Манай аймагт ийм тохиолдол гарч давхар сонгогдсон 11 мандатад сумын ИТХ-д нөхөн сонгууль явуулсан.

Энэ жилийн сонгуулийн онцлог бол сонгогчийн боловсрол дээшилсэн, төлөөллөө сонгоход иргэдийн оролцоо ямар чухлыг сонгогч нар маань ойлгосон сонгууль болж өнгөрлөө гэж дүгнэж байна. Сонгогчийн ирц хэдийгээр хамаарахгүй ч иргэд маань сонгуульдаа идэвхтэй оролцлоо. Сонгуулийн ерөнхий хорооноос орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд сургалт, мэдээллийг маш сайн зохион байгуулалттай өгч, мэдээлэл сурталчилгааг сайн явуулсны үр дүн гарлаа.

-Санал тоолох төхөөрөмжийн тухайд сүүлийн үеийн загварыг ашигласан гэж ойлгосон. Өмнөх сонгуулиудад ашиглаж байсан төхөөрөмжтэй харьцуулахад хэр байсан бэ?

-Нөхөн сонгуулиар шинэ төхөөрөмж ашигласан. Мэдээ дамжуулалт хурдан, ашиглахад хүндрэл бага байсан. Сонгуулийн ерөнхий хороо ч энэ талын сургалтыг хурдан шуурхай сайн хийж өгснөөр даамлууд маань алдаа гаргах нь бага байлаа.

-Улсын Их Хурлын 2024 оны сонгуулиас хойш алслагдсан, дэд бүтэцгүй хэсгүүдэд старлинк төхөөрөмж ашиглан ирц, дүнг шууд дамжуулж байгаа. Энэ удаагийн сонгуулиар ч адил уу?

-Энэ л их чухал зүйл. Ер нь иргэдийн төлөөллийг шат шатанд сонгоход ирц, дүнг хурдан шуурхай дамжуулах иргэдэд мэдээлэл хурдан шуурхай хүргэснээр хардалт, сэрдэлт ч бага

болдог юм байна. Манай аймгийн 2 хэсэгт уг төхөөрөмжийг ашиглаж хугацаа алдалгүй дамжуулсан. Өрсөлдөгч нарт ч гэсэн амар байсан байх. Сүүлийн сонгуулиудад мэдээллийн хурд өргөсөн сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл технологийн баг хурдан шуурхай ажиллаж байгаад талархалтай байгаа. Орон нутагт ажиллаж байгаа бид бүхэнд ч гэсэн ажил хөнгөвчилсэн, маргаан дагуулахгүй нээлттэй орчин бүрдэж байгаа.

-Дөрвөн жилд нэг удаа л сонгууль болдог гэж ойлгох нь элбэг. Ээлжит сонгуулиас гадна жил бүр нөхөн сонгууль болдгийг тэр бүр анзаардаггүйн учир юу юм бол?

-Ер нь тийм хандлага байдаг байсан. Сонгуулийн жил гэж маш олон телевиз, сайтаар мэдээлэл өгч иргэдийн анхаарлыг тийш нь хандуулж чаддаг. Харин нөхөн сонгуульд энэ талын мэдээ, мэдээллийг тэр бүр олон нийтэд хүргэдэггүй байснаас шалтгаалдаг байсан болов уу. Харин энэ жилийн нөхөн сонгуульд Сонгуулийн ерөнхий хорооноос ач холбогдол өгч мэдээлэл, сонгогчийн боловсролд түлхүү анхаарсан тул ирц харьцангуй өндөр хувьтай байлаа. Байнгын бус ажиллагаатай буюу аймаг, сумын сонгуулийн хороод ч сонгогч руу чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг маш сайн хийж гүйцэтгэсэн. Сонгогчдод мэдээлэл өгөх, сонгуулийн онцлог ач холбогдлыг таниулах ажилд төсөв хөрөнгийг нь хуваарилаад, хэрэгжүүлэхээр үр дүн гардаг юм байна. Өмнө нь бол бараг 10-15 хувийн ирцтэй байдаг байлаа шүү дээ. Тэгэхээр сонгогчийн боловсролд хөрөнгө хүч зарцуулахад иргэдийн оролцоо яаж нэмэгдэж байгааг статистик мэдээллээс л харахад хангалттай.

-Нөхөн сонгуулийн талаар ойлголт муугаас шалтгаалж ирц тааруу байдаг байсан гэж үү?

-Манай аймгийн хувьд нэг сумын нэг мандатад улс төрийн намуудаас сонгогдсон төлөөлөгчдийн тоо тэнцүү байсан. Нэг ёсны хайна хагалах нөхөн сонгууль болж байгаа юм. Бусад сумдын мандатууд дээр бол төлөөллийн тоо харьцангуй гайгүй, хол зөрүүтэй. Гэхдээ энэ тоо гэхээсээ илүү иргэд өөрсдийнхөө төлөөллийг төрд, сумандаа бий болгох гэж байгаа гэдэг утгаар ирц харьцангуй сайн байсан. Дээр дурьдсанчлан Сонгуулийн ерөнхий хороо, аймаг, сумын сонгуулийн хороо ажилласны үр дүн юм даа.

-Сонгууль бүрийн ирцийг харахад залуучуудын оролцоо бага байдаг. Орон нутагт үүний шалтгаан юу бол?

-Сонгуульд залуучуудын оролцоо муу байдаг. Нөхөн сонгуульд ч гэсэн ялгаагүй залуусын ирц тааруу байдагт бид ч дүгнэлт хийсэн. Нэгдүгээрт, орон нутгийн Хурлын сонгууль хичээл сургууль эхэлсэн, ид намрын ажлын үед явагддаг болохоор залуучуудын ирц тааруу байна. Оюутан залуус хичээлтэй, байнга оршин суугаа газраа байхгүй учраас саналаа өгч чаддаггүй. Хоёрдугаарт, төлөөллөө сонгохын ач холбогдлыг сайн ойлгоогүй байна. Өөрөөр хэлбэл, сонгогчийн боловсрол дутмаг байна. Сонгогчдод боловсрол олгоход илүү их анхаарч, хөрөнгө мөнгө төлөвлөж, зөвхөн сонгуулийн жил биш байнга, улс даяар хэрэгжүүлж байдаг ажил болгомоор байна.

Сонгогчийн боловсрол чухал гэдгийг Сонгуулийн шат шатны байгууллагууд ойлгосон байгаад талархалтай байгаа. Тэр ч утгаараа ээлжит сонгуулийн жилд ч тэр нөхөн сонгуулийн жилд ч тэр сургалт мэдээллийг тасралтгүй өгөхийн ач холбогдлыг сүүлийн сонгуулийн жилүүдэд бид харж байгаа. Тэр тусмаа шинээр сонгууль өгөх гэж байгаа залуучуудад сонгуулийн ач холбогдлын талаар сайн ойлгуулж байгаагийн үр дүн ерөөсөө л энэ нөхөн сонгуулийн ирц л харуулж байгаа юм. Сонгуулийн ерөнхий хорооноос залууст зориулсан "Хариуцлагатай сонгогч" сургалтыг 2022 оноос хэрэгжүүлж байгаад энэ жил нөхөн сонгуультай аймгуудад зохион байгуулсан. Үр дүн нь ирцээр харагдлаа.

-“Хариуцлагатай сонгогч” хөтөлбөрийн хүрээнд нутагт сургагч багш бэлдээд тэднээрээ дамжуулж сургалт зохион байгуулж гэсэн. Үүнийг яаж өргөжүүлбэл үр дүн илүү гарах бол.

-Давтамж хамгийн гол нь чухал байна. Сонгууль дөхөхөөр л сургалт хийдэг, сонгууль дөхөхөөр сонгуулийн хороо ажиллалаа гэдэг шүүмж их гардаг. Тэгэхээр сургалтын болон ач холбогдлыг ойлгуулах асуудлыг давтамжтайгаар хиймээр санагддаг. Хөрөнгө, хүн хүчний асуудал тулгарах байх гэхдээ түүнийг шийдэж болох гарц гаргалгаа байгаа.

-Сонгогчдод сонгуулийн боловсрол олгох ажлыг орон нутагт яаж зохион байгуулвал үр дүнтэй бол. Олон жил байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажилласан хүний хувьд санаа, оноо багагүй бий байх.

-Орон нутагт сонгуулийн байгууллагын байнгын төлөөлөл бий болгох хэрэгтэй. Сонгууль буюу төлөөллөө сонгохын ач холбогдол талаас нь энэ бол маш чухал асуудал. Иргэн та сонгуулийн боловсролыг тасралтгүй авснаар өдөр тутмын амьдрал цаашлаад улс, эх орны сайн сайхан хөгжих хөгжлийн гарцыг бий болгох төлөөллөө УИХ, аймаг, сумандаа бий болгож байгаа талаас нь харах хэрэгтэй.

-Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагаас гадна орон нутагт сонгуулийн боловсрол хариуцсан ажилтан ажиллах ёстой гэж үү?

-Нийслэл, аймаг, сумын сонгуулийн хороонд төрийн

албан хаагчид томилогддог. Сонгуулийн жил эхлэхээр төрийн албан хаагчид үндсэн ажлаасаа гадна дайвар хэлбэрээр сонгуулийн байгууллагын ажил хийж байгаа. Үндсэн ажлынхаа хажуугаар хийдэг учраас хугацаа тулгаж байж анхаарах, түүнээсээ шалтгаалж алдаа оноо гээд олон зүйл гарах эрсдэлтэй. Ядаж л мэргэшсэн байх чухал байна шүү дээ. Мэргэшсэн хүн байнга ажиллаж тухайн орон нутагт иргэдэд байнга сонгуулийн боловсрол олгоно гэдэг маш их ач холбогдолтой. Төрийн эрх барих эрхээ эдлэх мэдээлэл, сурталчилгаа хийх, сонгуулийн боловсрол олгох нь сонгуулийн ирцэд ч нөлөөлнө.

-Ээлжит ч бай нөхөн ч бай бүх сонгуулийн зохион байгуулалтын ажил тухайн оны эхнээс эхэлдэг. Орон нутаг дахь сонгуулийн байгууллага байнгын бус ажиллагаатай томилогддог. Үндсэн ажлынхаа хажуугаар сонгууль зохион байгуулахад хүндрэл, бэрхшээл хэр байдаг вэ?

-Бий бий. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулсан үндсэн ажил яах уу, хуулиар хүлээсэн сонгуулийн ажлаа яах уу гээд хоёрдмол байдалд орно. Төлөвлөгөөт ажлаа сонгуулиас болоод тасалдуулбал хувь төрийн албан хаагчийн хувьд урамшуулалаас авахуулаад үндсэн чиг үүргийн ажлууд орхигдож албан хаагчид хохирох талтай. Тийм учраас л миний хэлэх гээд байгаа санаа бол орон нутагт төлөөлөл бий болгох их чухал юм шиг санагддаг. Жишээ нь гэхэд л орон нутагт сонгууль болохгүй жил хэн бичгийн хариу өгөх үү, хэн судалгаа гаргах уу гээд үүрэг хүлээгээгүй болохоор бэрхшээл гарна.

-2024, 2025 онд гэхэд л гурван удаагийн сонгууль зохион байгууллаа. Ирэх жил дахиад нөхөн сонгууль болно. Тэгэхээр сонгуулийн байгууллага жил бүр тогтмол ажилтай байдаг гэсэн үг биз.

-Тийм. Тэр тусмаа судалгаа мэдээлэл, сургалт, сурталчилгаа гээд тогтмол ажилтай байдаг. Байнгын бус ажиллагаатай болхоор сонгуулийн байгууллагад ажиллаж байснаараа чи гаргана, би гаргана гэдэг асуудал тулгарна шүү дээ. Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан бий. АТГ-аас байгууллагуудад хөрөнгө, орлогын мэдүүлэг авдаг, сургалт мэдээлэл авдаг төлөөлөл ажилладаг шүү дээ. Ийм ажил хийснийхээ төлөө үндсэн цалин дээрээ нэмэлт авдаг. Сонгуулийн байгууллагын ажилтныг ийм байдлаар орон нутагт шийдэх боломжтой гэж хардаг.

-Улс төрийн намын тухай хуулиар намууд сонгогчдод боловсрол олгох үүрэг хүлээсэн. Орон нутаг дахь намын байгууллагуудын оролцоо хэр байдаг вэ?

-Манай аймаг дахь улс төрийн намуудын идэвхи оролцоо бол сайн. Гэхдээ нэг өрөөсгөл тал нь өөрсдийн барьж байгаа үзэл баримтлалаа тулгах шинж агуулаад байна уу даа гэсэн бодол төрдөг. Сонгуулийн жил эхлэхэд л намууд маань энэ ажлаа хийнэ шүү дээ. Тэгэхээр тасралтгүй боловсрол олгох асуудал их чухал юм шиг санагддаг.



МОНГОЛ УЛСАД “СОНГУУЛЬ АЖИГЛАХ АЗИЙН ЖИШИГ ТӨВ” БАЙГУУЛНА

Сонгуулийн ерөнхий хороо Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-тэй Хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд Монгол Улсад “Сонгууль ажиглах Азийн жишиг төв” байгуулахад хамтран ажиллах юм.

Санамж бичигт Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн Ерөнхий Нарийн бичгийн дарга Кэвин Касас-Замора нар 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан бөгөөд ёслолын ажиллагаа Швед Улсын нийслэл Стокхолм хот дахь Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн төв байранд зохион байгуулагдав.

Ёслолын ажиллагаанд Монгол Улсаас Шведийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ц.Мөнх-Өлзий, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн Ази, Номхон далайн бүсийн хөтөлбөрийн захирал Лина Рикила Таман болон албаны төлөөлөгчид оролцлоо.

“Сонгууль ажиглах Азийн жишиг төв” нь ардчилсан, шударга сонгуулийг ажиглах зарчим, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх, ажиглалтын арга зүйг боловсронгуй болгох, судалгаа, шинжилгээний үндсэн дээр шилдэг туршлагыг нэвтрүүлэх болон ажиглагчдыг чадавхжуулах, сонгууль ажиглалтын тайлан, зөвлөмжийн чанарыг сайжруулах зорилготой бүс нутгийн төв болон ажиллах юм.



ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ДАРГА ЖЕРАРД БРАУНЛИД БАРААЛХЛАА

Монгол Улсад албан ёсны айлчлал хийж байгаа Шинэ Зеланд улсын Парламентын төлөөлөгчдийн танхимын дарга Жерард Браунлид Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран 2025 оны 9 дүгээр сарын 2-нд бараалхлаа. Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран Монгол Улсад анх удаа айлчилж байгаа Жерард Браунли тэргүүтэй төлөөлөгчдөд талархал илэрхийлээд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн баярын мэнд хүргэв.

Ноён Жерард Браунли хариу талархал илэрхийлээд Шинэ Зеланд улс 1996 оноос холимог тогтолцоогоор парламентын сонгууль зохион байгуулж байгааг

дурдлаа. Мөн айлчлалын бүрэлдэхүүнд таван улс төрийн намаас парламентад сонгогдсон гишүүд багтсаныг онцолж, гишүүдийн хувьд нам бүртгүүлэх, сонгуульд оролцох болон сонгогчдыг идэвхжүүлэх арга хэлбэрийн талаар мэдээлэл авч, туршлага солилцох нь улс төрийн хувьд ач холбогдолтойг тодотгосон юм.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга хоёр улсын сонгуулийн төв байгууллагын хооронд албан ёсны харилцаа тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэх, туршлага солилцоход дэмжлэг үзүүлэхийг Ноён Жерард Браунли болон парламентын гишүүдээс уулзалтын төгсгөлд хүслээ.



ҮНДЭСНИЙ НОМЫН САНД СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ, ЭРХ ЗҮЙН УНШЛАГЫН ТАНХИМ АЖИЛЛУУЛНА

Сонгуулийн ерөнхий хороо сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн эрх зүйг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Үндэсний номын сан, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажиллахаар Санамж бичиг байгууллаа.

Сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэх нөхцөл бүрдүүлэх, энэ чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах, судлаачдыг идэвхжүүлэх зорилгоор дээрх байгууллагуудтай хамтран ажиллах юм. Түүнчлэн сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдод сонгуулийн болон эрх зүйн боловсрол олгох чиглэлээр олон талт үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.

Хамтын ажиллагааны хүрээнд сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, судалгааны бүтээл, лекц, хурал, хэлэлцүүлгийн видео бичлэгийг нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах бүтээлийн сан үүсгэж, Үндэсний номын сан Сонгуулийн боловсрол, эрх зүйн уншлагын танхимтай болох юм. Мөн их, дээд сургуулиудын багш, оюутан, судлаачдад чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцов.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭЭР СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ТЭРГҮҮЛЛЭЭ

Сонгуулийн ерөнхий хороо Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлсэн байдлаар Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагуудын үнэлгээний эрэмбээр тэргүүлжээ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлж, санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулахаар заасан. Энэ дагуу хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүнг гаргасан байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүгийн тайланг нээлттэй, ил тод мэдээлэх, сонгуульд зарцуулах зардлыг бууруулах, зардлын тайлангаа гаргаж өгөөгүй нам, эвсэл, нэр дэвшигчдэд хүлээлгэх хариуцлага тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчин бүрдүүлэх,

хэрэгжүүлэх, энэ талаар олон нийтийг мэдээллээр хангах зэрэг зорилтын хэрэгжилтийг бүрэн хангасан гэж үзжээ. Түүнчлэн иргэдийн оролцоо, хяналт, хариуцлагыг сайжруулах, олон нийтэд нээлттэй, ил тод байхаар заасан мэдээллийг тухай бүр цахим системд байршуулах, сонгогчдын боловсрол, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэрэг зорилтын хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэсэн байна. Гадаад улсад байгаа сонгогчдын сонгох эрхийг хангах болон залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээрх хөтөлбөрт тусгасан төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан гэж үнэлсэн аж. Тодруулбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгасан 6 зорилгын хүрээнд 20 зорилтын хэрэгжилтийг 92 хувиар хангасан гэж Ажлын хэсэг дүгнэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2030 он хүртэл хэрэгжинэ.

Эх сурвалж: Авлигатай тэмцэх газар



ГАДААД ОРНУУДЫН ҮНДСЭН ХУУЛИАС...



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Хорин нэгдүгээр зүйл

1. Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.

Хорин нэгдүгээр зүйл

3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

Хорин гуравдугаар зүйл

2. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно.

Хорин долоодугаар зүйл

4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.



Бүгд Найрамдах Итали Улс

55 дугаар зүйл

Парламент нь Бүгд Найрамдах Улсын Сенатын болон Төлөөлөгчийн танхимаас бүрдэнэ.

56 дугаар зүйл

Төлөөлөгчийн танхимыг шууд, нийтийн сонгуулиар сонгоно. ...

Сонгуулийн өдөр 25 нас хүрсэн сонгогч бүр төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.

58 дугаар зүйл

Сенатчийг 25 нас хүрсэн сонгогч бүр бүх нийтээр, шууд сонгоно. 40 нас хүрсэн сонгогч Сенатчаар сонгогдох эрхтэй.

61 дүгээр зүйл

Шинэ парламентийн сонгуулийг өмнөх танхимын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноос хойш 70 хоногт багтаан явуулна. Сонгуулийн дараах 20 хоногт багтаан анхдугаар хуралдааныг зохион байгуулна.

Шинэ Парламентийн анхдугаар хуралдаан хуралдах хүртэл хуучин танхимын бүрэн эрх хэвээр байна.




МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Хорин нэгдүгээр зүйл

4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хорин есдүгээр зүйл

1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.



Япон Улс

47 дугаар зүйл. Сонгуулийн тойрог, санал хураах аргачлал, хоёр танхимын гишүүдийн сонгуульд холбогдох бусад асуудлыг хуулиар тогтооно.

49 дүгээр зүйл. Хуульд зааснаар хоёр танхимын гишүүдэд жил бүр улсын төсвөөс мөнгөн урамшуулал олгоно.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Хорин гуравдугаар зүйл

1.Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

Арван зургадугаар зүйл

9/шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

Хорин нэгдүгээр зүйл

4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хорин долоодугаар зүйл

4.Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.



Герман Улс

38 дугаар зүйл

(1) Герман улсын Бундестагийн гишүүнийг нийтийн, шууд, чөлөөтэй, тэгш болон нууц сонгуулиар сонгоно. Бундестагийн гишүүд нийт ард түмний төлөөлөгч бөгөөд аливаа чиглэл, даалгаврыг биелүүлэх үүрэггүй, гагцхүү өөрийн итгэл үнэмшилд захирагдана.

(2) Арван найман нас хүрсэн иргэн бүх сонгох эрхтэй. Насанд хүрсэн иргэн бүр сонгогдох эрхтэй.

(3) Нарийвчилсан зохицуулалтыг Холбооны хуулиар тогтооно.

39 дүгээр зүйл

(2) Сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Бундестагийн анхдугаар чуулган хуралдана.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gescm@m-election.mn
(976) -51 262127